Public Disclosure Authorized
Public Disclosure Authorized
Public Disclosure Authorized
Public Disclosure Authorized

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд

2021 оны 2 дугаар сар

ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

Энэхүү тайлан нь Олон улсын сэргээн босголт, Хөгжлийн банк / Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн бүтээл бөгөөд бусад гадны байгууллагууд хувь нэмэр оруулж хамтарсан. Тайланд тусгасан үр дүн, тайлбар, дүгнэлт зэрэг нь Дэлхийн Банк, Дэлхийн Банкны Захирлуудын болон төлөөлж буй улс орнуудын засгийн газрын байр суурийг илэрхийлэх албагүй. Дэлхийн Банк энэ тайланд дурдагдсан мэдээ мэдээллийн үнэн бодит эсэхэд баталгаа өгөхгүй.

Эрх ба зөвшөөрөл

Энэ бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан. Уг бүтээлээс зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн, эсвэл бүхлээр нь хуулбарласан тохиолдолд холбогдох хуулийг зөрчиж буйд тооцогдоно. Олон улсын сэргээн босголт, Хөгжлийн банк / Дэлхийн Банк нь өөрийн ажлыг түгээн дэлгэрүүлэхийг хөхүүлэн дэмждэг бөгөөд хэсэгчлэн хэвлэн тараах зөвшөөрлийг шуурхай олгоно.

Энэхүү бүтээлийн аль нэг хэсгийг хуулбарлах, эсвэл хувилах зөвшөөрөл авах хүсэлтээ бүрэн гүйцэд мэдээллийн хамт дараах хаягаар илгээнэ үү: Copyright Clearance Center, Inc., 22 Rosewood Drive, Danvers, MA 01923, USA, telephone 978-750-8400, fax 978-750-4470, http://www.copyright.com/.

Өөр бусад хэлбэрээр хэвлэн нийтлэх эрх, холбогдох зөвшөөрөл авах талаар асууж тодруулах бол дараах хаягаар хандана уу: Office of the Publisher, The World Bank, 1818 H Street. NW, Washington, DC 20433, USA, fax 202-522-2422, e-mail pubrights@worldbank.org.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд

2021 оны 2 дугаар сар

ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

АГУУЛГА

ТАЛАРХАЛ VI

ХУРААНГУЙ VII

ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ 1

А. Эдийн засгийн сүүлийн үеийн төлөв байдал 2

А1. Үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард огцом агшив 2

А2. Нефтийн үнэ буурч, дотоод эрэлт суларснаар инфляц эрчимтэй буурав 7

А3. Цар тахлын нөлөөгөөр хөдөлмөрийн зах, түүний бүтцэд зарим өөрчлөлт ажиглагдав 8

А4. Төсвийн алдагдал 2020 онд огцом нэмэгдсэн ч 2021 онд буурахаар байна 10

А5. Урсгал дансны тохиргоо хийгдсэнээр гадаад дарамт мэдэгдэхүйц буурав 15

А6. Мөнгөний бодлогын төлөв суларсан ч активын чанар муудахын хэрээр банкны секторт эрсдэлүүд хуримтлагдсаар байна 18

Б. Хэтийн төлөв ба эрсдэлүүд 24

II. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ ӨРХӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ 31

А. КОВИД-19 цах тахлын өрхийн түвшинд үзүүлэх нөлөөллийн сувгууд 32

Б. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн хөлсний орлогод үзүүлэх нөлөө 34

В. Хөдөлмөрийн бус орлогод нөлөөлсөн байдал 41

Г. Ядуурал үзүүлж болох нөлөө 42

Д. Бодлогын арга хэмжээний үр дүн 46

Ашигласан материал 50

ШИГТГЭЭ

Шигтгээ I.1.	Монгол Улсын Засгийн газрын КОВИД-19 цар тахлыг тогтоон барих хүчин чармайлт	3
Шигтгээ I.2.	Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээ	12
Шигтгээ I.3.	2021 оны төсвийн товч танилцуулга	14
Шигтгээ I.4.	Монголбанкнаас КОВИД-19 цар тахлын нөлөөг зөөлрүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	19
Шигтгээ I.5.	Банкны салбарыг 2020-2023 онд чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр	27
Шигтгээ I.6.	Дэлхийн болон бүс нутгийн төлөв байдал, эрсдэлүүд	29
Шигтгээ II.1.	Монгол Улсад КОВИД-19 цар тахлын нөлөөллийг тодорхойлох утсанд суурилсан өрхийн судалгаа	34

ЗУРГУУД

Зураг ES.1.	Монгол Улс: Үндсэн үзүүлэлтүүд	X
Зураг ES.2.	Монгол Улс: Үндсэн үзүүлэлтүүд (үргэлжлэл)	XI
Зураг I.1.	Уул уурхай болон үйлчилгээний сектор унаж, эдийн засаг агшихад голлон нөлөөлөв	4
Зураг I.2.	Хувийн хэрэглээ тогтвортой өссөн боловч хөрөнгө оруулалтын хурдацтай уналтыг нөхсөнгүй	4
Зураг I.3.	Экспорт эхний хагас жилд хүнд цохилтод орсон ч хурдацтай сэргэв	5
Зураг I.4.	Дотоодын эрэлт суларч, түлш шатахууны үнэ буурсан нь импортод нөлөөлөв	5
Зураг I.5.	Уул уурхайн салбар оны эхний хагаст огцом унасан ч хурдацтай сэргэв	6
Зураг I.6.	Уул уурхайн бус үйлдвэрлэлийн агшилтыг үйлчилгээний сектор тодорхойлов	6
Зураг I.7.	Дотоод эрэлт хумигдаж, нефтийн үнэ буурсан нь инфляц буурахад нөлөөлөв ...	7
Зураг I.8.	... дотоодын зээл агшилт энэ нөлөөг улам хүчтэй болгов.	7
Зураг I.9.	КОВИД-19 цар тахал зарим ажлын байрыг эрсдэлд оруулав...	8
Зураг I.10.	... ажилгүйдэл буурч байсан сүүлийн жилүүдийн хандлага өөрчлөгдөв	8
Зураг I.11.	Ажилгүй иргэдийн хувьд 2020 оны эхний хагаст мөнгөн шилжүүлэг чухал болжээ	9
Зураг I.12.	Ажилгүй иргэдийн орлогын гол эх үүсвэрт 2020 оны II улирлаас өөрчлөлт оржээ	9
Зураг I.13.	Төсвийн орлого ангилал тус бүртээ тасалдав ...	10
Зураг I.14.	... гэтэл нийгмийн халамж, улсын хөрөнгө оруулалттай холбоотой төсвийн зардал эрс нэмэгдэв	10
Зураг I.15.	Орлого тасарч, зардал үлэмж нэмэгдэв ...	11
Зураг I.16.	... улмаар өнгөрсөн 3 жилийн төсвийн тэнцлийн хандлагыг өөрчлөв...	11
Зураг I.17.	КОВИД-19 цар тахлын нөлөөг сааруулахад чиглэсэн төсвийн арга хэмжээ	12
Зураг I.18.	Монгол Улсын төсвийн дэмжлэг Зүүн Ази, Номхон далайн бүс нутагтаа томоохонд тооцогдоно	12
Зураг I.19.	Төсвийн дэмжлэгт орлогын дэмжлэг, татварын хөнгөлөлт давамгайлав	12
Зураг I.20.	Төсвийн алдагдал 2020 онд үлэмж нэмэгдсэн ч 2021 онд мэдэгдэхүйц буурахаар хүлээгдэж байна	13
Зураг I.21.	2021 оны төсөвт орлогын таамаглалыг бага зэрэг өөдрөг байдлаар хийжээ ...	13
Зураг I.22.	Урсгал дансны тохиргоо нь гадаад дарамтыг сулруулахуйц байв ...	15
Зураг I.23.	Урсгал данс сүүлийн саруудад ашигтай гарсан нь ойрын жилүүдэд ажиглагдаагүй явдал болов	15
Зураг I.24.	Эхний хагас жилд уналтад орсон экспорт хурдацтай сэргэв ...	16
Зураг I.25.	Нефть болон үндсэн хөрөнгийн импорт буурсан нь импортын агшилтыг тодорхойлов	16
Зураг I.26.	Урсгал дансанд тохиргоо хийгдэж, алт худалдан авалт нэмэгдсэнээр I хагаст огцом буураад байсан валютын нөөц сэргэв ...	17
Зураг I.27.	... улмаар эхний хагас жилд алгуур суларч байсан ханш хоёр дугаар хагаст тогтворжив.	17
Зураг I.28.	Адил төстэй улс орнуудтай харьцуулахад төгрөгийн ханш алгуур сулрав ...	17
Зураг I.29.	... үүнд Монголбанкны интервенц, ялангуяа 2020 оны эхний хагас дахь оролцоо томоохон дэм үзүүлэв	17
Зураг I.30.	Зээлийн өсөлтийг сэргээх үүднээс бодлогын хүүг түүхэн доод түвшинд хүргэв	18
Зураг I.31.	Банкуудад илүүдэл нөөц хангалттай байгаа ч зээл гаргахаас болгоомжилж байна	18
Зураг I.32.	Аж ахуйн нэгжид шинээр олгосон зээл бүх секторын хувьд буурав	21
Зураг I.33.	Банкуудаас өрхийн болон ЖДҮ-д шинээр олгох зээлийн нөхцөлөө мөн чангатгав	21
Зураг I.34.	Зээлийн чанар мэдэгдэхүйц муудав	21
Зураг I.35.	... ялангуяа уул уурхай, барилга, худалдааны салбарын зээлийн чанар муудав	21
Зураг I.36.	Эрсдэлтэй секторуудын хувьд зээлийн эрсдэлийн сан хангалтгүй байна ...	22
Зураг I.37.	Цар тахлын үр нөлөө ил болохын хэрээр банкууд томоохон хүндрэлтэй тулгарахаар байна...	22

Зураг I.38.	Банк хоорондын захын нөөц тогтвортой байгаа ч...	23
Зураг I.39.	... валютын нийцгүй байдлын эрсдэл өндөр байхаар байна	23
Зураг I.40.	Нэлээдгүй улс орны засгийн газрын өр, ДНБ-ий харьцаа 2020 онд өссөн байна	26
Зураг I.41.	2020-2024 онд том дүнтэй бондуудыг төлнө	28
Зураг I.42.	ДНБ-ий бодит өсөлт	29
Зураг I.43.	Дэлхийн түүхий эдийн үнийн таамаглал (Индекс=нэрлэсэн ам.доллар, 2016=100)	29
Зураг I.44.	Зүүн Ази, Номхон далайн орнуудын таамаглал	30
Зураг II.1.	Халдварын тоо нэмэгдэхийн хэрээр хөл хорионы дэглэмийг чангаруулж байна	33
Зураг II.2.	КОВИД-19 цар тахлын өрх гэрт нөлөөлөх хэлбэрүүд	33
Зураг II.3.	Цар тахлаас өмнө хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн талаас илүү нь хоёр дахь хөл хорио эхлэхэд ажил эрхлэлтээ зогсоосон байна	35
Зураг II.4.	Аж үйлдвэрлэлийн болон үйлчилгээний хувийн салбарт ажиллагсдын томоохон хувийн хөдөлмөр эрхлэлт нь саатсан	35
Зураг II.5.	Цар тахалд өртсөн салбарт ажиллагсдын харьцаа, 2019 оны байдлаар	36
Зураг II.6.	2020 оны I, II хөл хорионы үед тээвэрлэсэн зорчигчдын тоо буурлаа	37
Зураг II.7.	2020 онд ирсэн жуулчны тоо өмнөх жилүүдээс маш бага байлаа	37
Зураг II.8.	Үйлчилгээ авах зорилготой зорчих хөдөлгөөн хөл хориотой холбоотойгоор огцом буурчээ	37
Зураг II.9.	Албан бус салбарт хөдөлмөрлөж буй ур чадвар багатай иргэд хамгийн эмзэг болоод байна	38
Зураг II.10.	ХАА-н бус салбарт бизнес эрхлэгчдэд хүчтэй нөлөөлжээ	39
Зураг II.11.	Хөдөлмөр эрхлэлт, орлогын алдагдал, амьжиргааны бүх бүлгээр	40
Зураг II.12.	Хот, суурин газрын иргэдийн ажил 2020 онд түлхүү зогссон байна	40
Зураг II.13.	Мөнгөн шилжүүлэг авдаг өрхүүд (2018)	41
Зураг II.14.	Өрхийн орлогод мөнгөн шилжүүлгийн эзлэх хувь (дэмжлэг авдаг өрхүүдийн хувьд)	41
Зураг II.15.	Ядуурлын түвшин, төсөөлөл	42
Зураг II.16.	Ядуу иргэдийн тоо, төсөөлөл	42
Зураг II.17.	Хэрэглээний өөрчлөлт (нэг хүнд ногдох хэрэглээний өөрчлөлт хувиар, 2018-с 2020 он)	44
Зураг II.18.	Иргэдийн амьжиргааны өөрчлөлт, ядуурлын төлөв байдлаар, 2018-с 2020 он	44
Зураг II.19.	Ядуурлын түвшин, байршлаар (%)	45
Зураг II.20.	Ядуурлын тархалт, газар зүйн байршлаар	45
Зураг II.21.	Ядуурлын тархалт, эдийн засгийн салбараар	45
Зураг II.22.	Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдсан өрхүүд (2018)	46
Зураг II.23.	Хүүхдийн мөнгө болон өрхийн бусад орлого, эх үүсвэрээр (2018)	46
Зураг II.24.	Хүүхдийн мөнгөний нэмэгдэл нэг иргэнд ногдох хэрэглээг нэмэгдүүлэх хувь, (2020)	48
Зураг II.25.	Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлснээр амьжиргааны түвшинд үзүүлэх нөлөө, цар тахлаас өмнөх үетэй харьцуулахад (2020)	48
Зураг II.26.	Ядуурлын түвшин, бодлогын арга хэмжээ авсан, аваагүй ялгаатай нөхцөлд (2020)[a]	48
Зураг II.27.	Засгийн газраас олгосон тусламж, дэмжлэгийн үр нөлөөг өрхүүд дүгнэсэн байдал	49

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт ES.1.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	XII
Хүснэгт I.1.	Монгол Улс: 2021 оны төсвийн нийт тэнцлийг сайжруулах нь (ДНБ-д эзлэх %)	14
Хүснэгт I.2.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	26
Хүснэгт II.1.	УСӨС-ны 1 - 3 дугаар үе шат	34
Хүснэгт II.2.	ДНБ өсөлт, инфляц[a]	43
Хүснэгт II.3.	КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах чиглэлд Засгийн газраас авсан арга хэмжээ	47

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ЖИЛ

1 дүгээр сарын 1 - 12 дугаар сарын 31

НЭРЛЭСЭН ХАНШ

(2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх ханш)

Мөнгөн тэмдэгт	=	Төгрөг (төг)
1.00 ам.доллар	=	2,850 төг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ГШХО	гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	жижиг, дунд үйлдвэрлэл
МБХ	Мөнгөний бодлогын хороо
НХТ	нийгмийн халамжийн тэтгэмж
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ӨНЭЗС	Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа
СЯ	Сангийн яам
УОК	Улсын Онцгой Комисс
УСӨС	Утсанд суурилсан өрхийн судалгаа
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХМХ	хүүхдийн мөнгө хөтөлбөр
ХТХ	хүнсний талон хөтөлбөр
ХҮИ	хэрэглээний үнийн индекс

ТАЛАРХАЛ

Монгол Улсын эдийн засгийн тоймын энэ удаагийн дугаарыг ахлах эдийн засагч Жан Паскал Нганоу, эдийн засагч Батсуурийн Даваадалай, шинжээч Батмөнхийн Ундрал, эдийн засагч Махешвор Шреста, эдийн засагч Икуко Уочи нар бэлтгэв. Эл тоймд тэргүүлэх эдийн засагч Себастян Экардт, ахлах эдийн засагч Ибрахим Саид Чоудхури, ахлах эдийн засагч Эка Т. Вашакмаджэ нарын үнэтэй санал зөвлөмжийг тусгав. Тоймыг Дэлхийн банкны БНХАУ, Монгол Улс, БНСУ-ыг хариуцсан захирал ноён Мартин Рейзер, Бүсийн захирал ноён Хасан Заман, Макро эдийн засаг, төсвийн асуудал хариуцсан менежер ноён Дипак Мишра, Монгол Улс дахь суурин төлөөлөгч Андрей Михнев нарын удирдлага дор бэлтгэв. Тайланд туслалцаа үзүүлж хамтарч ажилласан Төмөрийн Сүхчимэг (туслах ажилтан), Баатархүүгийн Индра (гадаад харилцаа хариуцсан ажилтан) нарт багийн зүгээс талархлаа илэрхийлж байна.

Монгол Улсын эдийн засгийн тойм хоёр хэсгээс бүрддэг билээ. Нэгдүгээр хэсэгт эдийн засгийн сүүлийн үеийн нөхцөл байдал, дунд хугацааны эдийн засгийн төлөвийг танилцуулдаг бол хоёрдугаар хэсэгт тодорхой сэдэв дээр төвлөрдөг уламжлалтай. Тусгайлсан сэдвийн хүрээнд энэ удаа бид утсаар авсан санал асуулгад үндэслэн КОВИД-19 цар тахлын айл өрхүүдэд үзүүлж буй нийгэм, эдийн засгийн нөлөөг авч үзэв. Энэхүү тойм нь бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид, санхүүгийн зах зээлд оролцогчид, мөн Монгол Улсад ажиллаж буй шинжээч, мэргэжилтнүүд зэрэг өргөн хүрээтэй уншигчдад зориулагдав.

Энэхүү тоймд гарсан Дэлхийн Банкны ажилтнуудын дүгнэлт, тайлбар нь Дэлхийн Банкны гүйцэтгэх зөвлөл, эсвэл төлөөлж буй засгийн газрынхаа байр суурийг илэрхийлэх албагүй болно. Дэлхийн Банк болон түүний Монгол дахь үйл ажиллагааны талаарх мэдээллийг https://www.worldbank.org/en/country/mongolia холбоосноос авна уу. Энэхүү баримт бичигтэй холбоотой санал шүүмжээ Жан Паскал Нганоуд ирүүлнэ үү (jnganou@worldbank.org). Тус тоймд ашигласан тоо, мэдээллийн хамрах хугацаа 2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгов.

ХУРААНГУЙ

Эдийн засгийн сүүлийн үеийн нөхцөл байдал

Улс оронд цар тахлын дэгдэлт үргэлжилж байгаа ч хүмүүс хоорондоо зай барих, хөдөлгөөнийг хязгаарлах, хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ нь КОВИД-19 цар тахлын хүний эрүүл мэндэд үзүүлж болох хор хөнөөлийг хязгаарлах боломж, цаг хугацааг тодорхой хэмжээнд Монгол Улсад олгосон. Эдгээр арга хэмжээг цаг алдалгүй авсан нь нэг талаас цар тахлыг тогтоон барихад чухал үүрэг гүйцэтгэсэн ч нөгөө талдаа эдийн засагт мэдэгдэхүйц хүндрэл учрууллаа. Ялангуяа, дотоод халдвар тархсантай холбоотойгоор 2020 оны 11 дүгээр сарын дунд үеэс хэрэгжүүлж эхэлсэн хатуу хөл хорионы арга хэмжээ нь эдийн засгийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц хүндрэл боллоо. Гэвч цар тахлын тархалтыг цаг алдалгүй хяналтад оруулах нь хүмүүсийн амь насыг хамгаалаад зогсохгүй эдийн засгийг эргэн хэвийн байдалд хурдан оруулахад туйлын чухал болоод байна.

Монгол Улсын эдийн засагт КОВИД-19 цар тахал багагүй нөлөө үзүүлж, цар хүрээ нь өргөн байлаа. 2020 оны эхний 9 сард Монгол Улсын эдийн засаг 7.3 хувиар агшсан нь 1990-ээд оноос хойших эдийн засгийн хамгийн том агшилт болохоор байна. Гол экспортын түүхий эдийн эрэлт огцом буурч, Монгол-Хятадын хил хаагдсан нь уул уурхайн салбарт ихээхэн хүндрэл учруулсан. Хөл хорио, орлогын бууралт нь үйлчилгээний салбарт багагүй хүндрэлийг мөн дагууллаа. ААН-үүдийн түвшинд хийсэн сүүлийн судалгаанаас үзэхэд КОВИД-19 цар тахал нь жижиг, дунд үйлдвэрлэгчдэд; аж үйлдвэр, аялал жуулчлал, худалдаа, тээвэр, барилга, боловсролын салбарт түлхүү нөлөөлж буй байдал ажиглагджээ. Харин бодлого боловсруулагчдаас авч хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих хөтөлбөр нь олон аж ахуйн нэгжийг хаалгаа барихаас сэргийлж, тодорхой нэмэр болж байна.

Мөн цар тахал нь хөдөлмөрийн зах зээлд дарамт учруулах, улмаар түүний бүтцийг өөрчлөх зэрэг тодорхой хэмжээний өөрчлөлт авчирч байна. Тухайлбал, 2020 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар соёл урлаг, амралт чөлөөт цаг, үзвэр үйлчилгээ, зочид буудал зэрэг салбаруудын ажиллагсдын тоо буураад байгаа бол нөгөө талдаа эдийн засгийн үйл ажиллагаа илүү цахим хэлбэрт шилжиж байгаагаас мэдээлэл технологийн салбарын ажиллах хүчний тоо мэдэгдэхүйц өсөөд байна. Үүний зэрэгцээ нийт ажиллах хүчний оролцооны түвшин 2020 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 хувиар буурсан бөгөөд ажилгүйдлийн түвшин 2020 оны 3 дугаар улиралд ялимгүй өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлж буй тодорхой хүндрэлүүдийг илтгэж байна. Гэвч бодлого боловсруулагчдаас хэрэгжүүлж буй цар тахлын эсрэг хөтөлбөрүүд нь цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөөг тодорхой хэмжээнд зөөллөсөн байна. Мөн нөгөө талдаа ААН-үүд ажлын байраа шууд цомхотгохоос илүүтэй ажиллагсдынхаа цалинг бууруулах болон бусад хэлбэрийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа нь ажлын байрны тоо огцом буурахаас сэргийлж буй дүр зураг ажиглагдлаа. Түүнчлэн, засгийн газраас хэрэгжүүлж буй иргэд, ААН-үүдийн орлогыг хамгаалах хөтөлбөрүүд, сургууль, цэцэрлэг хаалттай үед хүүхэд харах болон бусад нийгмийн халамжийн үр дүнтэй хөтөлбөр үгүйлэгдэж байгаа нь ажиллах хүчний оролцоо буурахад нөлөөлсөн байж болзошгүй юм.

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн уналт өрхийн түвшинд нэлээд хүндрэл учруулж байна. Орлогын бүлгээр авч үзэхэд дийлэнх өрхүүдэд цар тахлын сөрөг нөлөө мэдрэгдэж байгаа ба ялангуяа албан бус салбарт ажиллаж буй ур чадвар бага шаарддаг ажлын байрны хувьд энэ байдал түлхүү ажиглагдаж байна. Мөн санхүүгийн чадавх сул, ажлын байрны баталгаа бага, эрсдэлтэй ажиллагсдын хувьд илүү хүндээр нөлөөлж байхаар байна. Дээр дурдсан ажиллагсдын орлого буурах, улмаар ядуурлын шугам руу гулсах эрсдэлтэй байна. Сүүлд Дэлхийн Банк болон Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос хамтран утсаар хийсэн санал асуулгын дүгээс харахад өрхийн орлого нь цар тахлын нөлөөгөөр буурч буй урьдчилсан хандлага ажиглагдаж байна. Ялангуяа 11 дүгээр сарын дундаас буюу хатуу хөл

хорионы туршид ААН-үүд ажлын цагаа бууруулсан, зарим нь үйл ажиллагаагаа зогсоосон нь дээрх судалгаанд оролцсон иргэдийн хариултад голлон нөлөөлсөн байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй өрхийн орлогын хамгаалах өргөн хүрээтэй хөтөлбөрүүд цар тахлын зарим сөрөг нөлөөг зөөллөхөд үр дүнгээ өгсөн болох нь судалгаанаас ажиглагдаж байна. 2018 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон ДНБ-ны сүүлийн төсөөлөл дээр үндэслэсэн симуляц шинжилгээний үр дүнгээс үзэхэд дэмжлэг туслалцаа үзүүлээгүй байсан бол 195,000-аас 260,000 хүн ядууралд өртөх боломжтой байсан гэсэн тооцоо харагдаж байна. Энэ нь 2018 онд 28.4 хувь байсан ядуурлын түвшнийг 2020 онд 33.6 хувьд хүргэн нэмэгдүүлэх эрсдэлтэй байсан гэсэн үг юм. Харин хүүхдийн мөнгөний хэмжээг 2020 оны 5 дугаар сараас 2021 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд 5 дахин нэмэгдүүлсэн арга хэмжээ нь ядуурлын түвшнийг 2018 оны түвшнээс доогуур хадгалахад томоохон нөлөө үзүүлэх төлөвтэй.

Гадаад секторын хувьд хүлээгдэж байснаас харьцангуй сайн гүйцэтгэлтэй байсан нь урсгал тэнцлийн дарамт оны 2 дугаар хагаст хурдтай буурснаас голлон шалтгааллаа. 2020 оны эхний саруудад эрчимтэй нэмэгдэж байсан урсгал тэнцлийн дарамт харин эрс буурч, ялангуяа оны хоёрдугаар хагаст ашигтай гарсан нь экспорт харьцангуй хурдан сэргэж нөгөө талдаа импорт агшилттай хэвээр байснаас голлон шалтгаалав (тухайлбал, хөрөнгө оруулалттай холбоотой импортын эрэлт буурсан, монголчуудын гаднын үйлчилгээнд төлдөг төлбөр багассантай холбоотой байв). Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, хувийн сектор багагүй хэмжээний гадаад төлбөр хийгдсэн ч дэлхийн санхүүгийн зах зээл дээр эх үүсвэрийн өртөг буурсан нөхцөл байдлыг Монголын Засгийн газар овжин ашиглаж чадсан нь төлбөрийн тэнцэл сайжрахад багагүй нөлөө үзүүллээ. Үр дүнд нь төгрөгийн ханшийн сулрах дарамт харьцангуй бага байж, гадаад валютын нөөц түүхэн дээд түвшин буюу 4.5 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнд Төв банкны худалдаж авсан алтны хэмжээ ч мөн багагүй нөлөө үзүүллээ.

Төсвөөс үзүүлж буй дэмжлэгийн нийт өртөг 2020 оны хүлээгдэж буй ДНБ-ий 9 гаруй хувьтай тэнцэх хэмжээгээр тооцогдохоор байна.[1] Төсвийн орон зай багасаж буй байдал 2020 оны эхээр буюу цар тахлаас өмнө ажиглагдаж эхэлсэн нь засгийн газраас цалин, тэтгэврийг нэмэгдүүлсэн, ахмадуудын тэтгэврийн зээлийг тэглэсэнтэй холбоотой байв. Цар тахлын үр дагавар нэмэгдэхийн хэрээр төсвийн алдагдал 2020 оны 4 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл мэдэгдэхүйц өссөн. 2020 оны эцсээр төсвийн алдагдал хүлээгдэж буй ДНБ-ий 9.5 орчим хувьтай байгаа нь 2016 оноо хойш хамгийн өндөр түвшин бөгөөд энэ нь орлого багагүй хэмжээгээр тасарсан, цар тахлын эсрэг төсвийн зардал өссөнөөс голлон шалтгаалав. Ерөнхийд нь авч үзвэл эдийн засаг эрэлтийн ч тэр, нийлүүлэлтийн ч тэр томоохон цочролд өртөж байгаа тул засгийн газраас хэрэгжүүлж буй төсвийн арга хэмжээ нь ААН, иргэдийг дэмжихэд тодорхой үр дүнтэй байсан гэж хэлж болохоор байна. Харин төсвийн алдагдлын хэмжээ цаашид өндөр байвал цаашдын төсвийн зохистой байдлын талаар санаа зовниход хүргэж байна.

Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөллөхийн тулд бодлогын хүүг бууруулах, банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ААН, иргэдийн зээлтэй холбоотой дүрэм журмын шаардлагыг зөөлрүүлэх, түдгэлзүүлэх болон бусад арга хэмжээ (төсвийн шинжтэй үйл ажиллагаа) авах замаар Төв банк ч мөн мөнгөний бодлогоо зөөлрүүлсэн. 2018 оны сүүлээс мөнгөний бодлого харьцангуй чанга чиглэлд хэрэгжиж байсан нь зээлийн өндөр өсөлтийг сааруулах, инфляцыг бууруулахад тодорхой үр дүнгээ өгсний зэрэгцээ цар тахлын шок бий болоход мөнгөний бодлогыг зөөлрүүлэх тодорхой орон зайг Төв банкинд олголоо. Харин цаашид мөнгөний бодлогыг нэмж зөөллөх орон зай Монгол Улсын гадаад секторын эмзэг байдлаар хязгаарлагдаж болзошгүй.

Санхүүгийн секторын хувьд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сулруулж, дүрэм журмын биелэлтийг түдгэлзүүлсэн ч банкууд зээл гаргахаас болгоомжилсон хэвээр байна. Банкуудын зээл 2019 онд жилийн 5.1 хувиар өссөн ч 2020 онд жилийн 5 орчим хувиар буураад байна. Бодлого боловсруулагчдаас 2020 оны 1 дүгээр сард тэтгэврийн зээлийг тэглэх шийдвэр гаргасан нь энэхүү бууралтын нэлээдгүй хэсгийг тайлбарлаж байгаа ч банкууд зах зээлийн эрсдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор

[1] Төсвөөс 2020 болон 2021 оны эхний хагаст олгосон тусламж, дэмжлэгийг оруулав.

зээл олгохдоо харьцангуй болгоомжилж байна. Үүний сацуу банкны системийн гадаад валютын эх үүсвэр болон гадаад валютын зээл хоорондын зөрүү нэмэгдэх (жишээ нь хадгаламжийн долларжилт өссөн) болон зээлийн чанар муудах зэрэг эрсдэлүүдтэй нүүр тулж байна. Мөн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сулруулж, дүрэм журмын биелэлтийг түдгэлзүүлсэн явдал санхүүгийн салбарын эрсдэлийн бодит төрхийг зарим талаар халхлах, улмаар нарийн тооцож, үнэлэхэд хүндрэл учруулж байх талтай.

Эдийн засгийн хэтийн төлөв ба эрсдэлүүд

Цар тахлын дараах сэргэлт удаан, амаргүй байхаар байна. Монголын эдийн засаг 2020 онд 5.2 хувиар агшихаар хүлээгдэж байна. Харин 2021 онд хэрэв цар тахлыг хяналтад амжилттай оруулж, эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээ нь үр дүнгээ өгч, дэлхийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, аж ахуйн нэгжүүд болон иргэд КОВИД-19-тэй шинэ орчинд үр дүнтэй дасан зохицож, вакцинжуулалт цаг хугацаандаа амжилттай хийгдвэл эдийн засаг 4.3 хувиар өсөх боломжтой гэж үзэж байна. Гэхдээ эдийн засгийн сэргэлтэд дараах гол эрсдэлүүд байсаар байна. Үүнд: i) дотоодын КОВИД-19 халдварын тохиолдол эрс нэмэгдэж хатуу, илүү удаан хугацаатай хөл хорио тогтоох; ii) дэлхий даяар КОВИД-19 вирусын тархалтын шинэ давлагаануд нэмэгдсэнээр гадаад, дотоод орчин муудах; iii) цар тахал банкны системийн зээлд нөлөөлж улмаар санхүүгийн секторын тогтвортой байдалд хүндрэл учруулах; iv) цаг агаарын нөхцөл байдал (жишээ нь зуд) ХАА-н секторын үзүүлэлтүүдэд ноцтой нөлөөлөх; v) Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор улсын төсвийн зардал нэмэгдэх, нэмэлт ачаалал үүсэх зэргийг нэрлэж болох юм.

Бусад орны адилаар Монгол Улс эдийн засгийн богино хугацаат дэмжлэгийн бодлогоос сэргэлтийг хурдасгаж, дархлаагаа сайжруулах бодлого руу аажмаар шилжихэд анхаарах шаардлагатай. Энэ чиглэлд эн тэргүүний бодлогуудын нэг нь төсвийн хянамгай бодлогыг хэрэгжүүлэх явдал юм. 2020 онд хэрэгжүүлсэн ААН, иргэдийн орлогыг хамгаалах өргөн хүрээт арга хэмжээг үргэлжлүүлэх төсвийн нөөц боломж хомс бөгөөд нөгөө талдаа дэмжлэгээ огцом зогсоох нь ААН, иргэдэд мөн багагүй хүндрэлтэй байх томоохон сорилттой тулгараад байна. Одоогийн төсвийн бодлогыг ажиглахад дунд хугацааны төсвийн тогтвортой байдалд чиглэхийн зэрэгцээ, 2021 оны эхний хагас хүртэл дэмжлэгээ үргэлжлүүлэх төлөвтэй байна. Одоогийн төсвийн төлөв нь зарим талаар харьцангуй боломжийн хувилбар ч хэрэв 2021 оны дундаас цаашид төсвийн зардал өндөр түвшинд хадгалагдвал төгрөгийн ханшинд дарамт учруулах, хөрөнгийн гадагшлах урсгалыг өдөөх зэрэг эрсдэлтэй тул, түүнийг нарийн тооцох, макро эдийн засгийн зохистой хяналтыг эргэн сэргээх тал дээр сайтар анхаарах нь зүйтэй юм. Өнөөг хүртэл Монгол Улс макро эдийн засгийн хэлбэлзлийг бууруулах чиглэлд харьцангуй амжилттай ажиллаж байна. Цаашид энэ ахиц, амжилтаа улам бататгах нь чухал юм. Үүнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг илүү уян хатан байлгаж, дотоод бодлогын орон зайгаа нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой.

Мөн түүнчлэн бас нэг анхаарах чиглэл нь санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулах эдийн засгийн шокоос зайлсхийх явдал юм. Цар тахлын эсрэг түргэн шуурхай хариу үйлдэл зөв зүйтэй, шаардлагатай зүйл ч гэсэн зээлийн дүрэм журмын хэрэгжилтийг хэт удаан хугацаанд түдгэлзүүлэх нь банкны салбарын ил тод байдлыг бууруулах, банкуудын балансын чанарыг бууруулах эрсдэлтэй юм. Энэхүү цар тахал нь ААН-үүдэд томоохон сорилт болж байгаа ба зарим нь энэ хүндрэлийг бүрэн даван туулж чадахгүй ч байж болох юм. Тиймээс ААН-үүд илүү өөр хоорондоо нягт хамтран ажиллаж, нөөцөө оновчтой хуваарилж, орлого, ашгийн хэмжээгээ огцом бууруулахгүй байхад анхаарах шаардлагатай. Банкуудын хувьд нөөцийн зөв хуваарилалтад онцгой үүрэг гүйцэтгэх бөгөөд дүрэм, журмын хөнгөлөлт нь муу хөрөнгө оруулалтад нөөц удаан хугацаагаар төвлөрөх боломжийг бий болгох эрсдэлтэй юм. Энэ нь урт хугацаанд эдийн засагт ихээхэн зардалтай болохыг мөн анхаарах хэрэгтэй. Иймээс банкны салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг үр дүнтэй, чанартай хийх шаардлагатай. Энэ хүрээнд Монгол Улсын санхүүгийн секторын дархлааг нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, банкны засаглалыг сайжруулах, түүн дотроо өмчлөгчдийн төвлөрлийг сааруулах зэрэг суурь реформууд нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Дээрх реформуудад КОВИД-19 цар тахалтай холбоотой дүрэм, журмын хөнгөлөлтийг аажмаар

Зураг ES.1. Монгол Улс: Үндсэн үзүүлэлтүүд

Хөл хорионы хатуу дэглэмийн ачаар 2020 оны ихэнх саруудад цар тахлыг тогтоон барьж чадав

Засгийн газраас авсан арга хэмжээний төлөв ба КОВИД-19 халдварын тохиолдлууд



Эх сурвалж: Оксфордын Их сургууль (OxCGRT).
Жич: БГТ = Баруун гар тал; ЗГТ = Зүүн гар тал. Хязгаарлалтын дэглэмийн индекс нь КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор сургууль болон ажлын байран дахь үйл ажиллагааг зогсоох, олноор цугларахыг хориглох зэрэг тархалтыг тогтоон барих арга хэмжээ хэр чанга байсныг харуулна. Индекс нэмэгдэх тусам арга хэмжээ илүү чанга байсныг илтгэнэ.

Гэсэн хэдий ч бүс нутгийн орнуудтай харьцуулахад халдвар 2020 оны 11 сараас огцом өсөв...

КОВИД-19 халдварын бүртгэгдсэн тохиолдол, өсөн нэмэгдэх дүнгээр



Эх сурвалж: Оксфордын Их сургууль (OxCGRT).

Экспорт оны эхний хагаст огцом буурсан ч түргэн сэргэв ...

Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт, улирлаар (өмнөх оны мөн үетэй харьцуулахад)



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

... уул уурхай болон үйлчилгээний сектор хамгийн ихээр өртөж, сэргэлт нь удаан байв

ДНБ-ий өсөлтөд нийлүүлэлтийн оруулсан хувь нэмэр, нэгж хувиар



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Засгийн газрын зүгээс томоохон дүнтэй төсвийн хөнгөлөлт, түслалцаа үзүүлэв ...



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банк (2020), Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

... ингэснээр өрхийн хэрэглээг дэмжив

ДНБ-ий өсөлтөд эрэлтийн оруулсан хувь нэмэр, нэгж хувиар



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг ES.2. Монгол Улс: Үндсэн үзүүлэлтүүд (үргэлжлэл)

Инфляцын дарамт бага орчинд мөнгөний бодлогын хүүг түүхэн доод хэмжээнд хүргэж бууруулав



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.
Жич: БГТ = баруун гар тал; ЗГТ = зүүн гар тал.

Банкуудад хангалттай хэмжээний илүүдэл нөөц байгаа ч чанаргүй зээлийн өсөлттэй холбоотойгоор зээл гаргах сонирхол сул байна

(банкны салбар дахь илүүдэл нөөц ба зээлийн өсөлт)



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.
Жич: БГТ = баруун гар тал; ЗГТ = зүүн гар тал.

Зээлийн чанар муудсаар ...

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь

Эх сурвалж: Монголбанк.

Банкны системд валютын нийцгүй байдлын эрсдэл өндөр байв



Эх сурвалж: Монголбанк.

Урсгал тэнцэл сүүлийн саруудад ашигтай гарч гадаад валютын нөөцийг дэмжив ...

Урсгал дансны тэнцэл ба гадаад валютын нөөц (сая ам.доллар)

Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

... нөгөө талдаа гадаад секторын дарамт суларснаар ханш тогтворжив

Ханш: Төгрөг (Спот ханш, Индекс, 2015 оны 12-р сар=100)

Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

цуцлах нь ихээхэн хувь нэмэртэй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Эцэст нь, Монгол Улс илүү цогц, төсөвт хэт ачаалал үүсгэхгүй дунд хугацааны эдийн засгийн зөв хөгжил, ажил эрхлэлтийг дэмжих бодлогуудад голчлон төвлөрөх шаардлагатай. Ийм цогц бодлого нь илүү чанартай ажлын байрыг бий болгох, монгол хүнийг орлогын тогтвортой эх үүсвэртэй болгох, уул уурхай ба бусад салбаруудад хувийн хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах тал дээр төвлөрөх шаардлагатай. Энэ нь төсвийн хөрөнгийг илүү зорилтот, нэн шаардлагатай дэд бүтцийн төслүүдэд чиглүүлэхийн зэрэгцээ зорилтот бүлэгт чиглэсэн, төсвийн хувьд хэмнэлттэй нийгмийн хамгааллыг бүрдүүлэхээс ихээхэн хамаарна. Мөн илүү чанартай ажлын байранд ур чадвартай ажиллах хүчнийг бүрдүүлэх, хүний хөгжлийг тууштай сайжруулах, ялангуяа одоогийн сургууль, цэцэрлэг хаалттай байгаа нөхцөлд ядуу, орлого багатай иргэдийн дээрх асуудлуудад сайтар анхаарах шаардлагатай. Ирэх жилүүдэд засгийн газрын бодлого нь цар тахлын эсрэг үндэсний болон глобал түвшний менежментэд өндөр мэдрэмжтэй байж, аливаа эрсдэлд уян хатан байдлаар хариу үйлдэл үзүүлэхэд чиглүүлэх нь зүйтэй. Эцэст нь вакцинжуулалтын талаар сүүлийн үед гарч буй ололт, эерэг мэдээнүүд нь бодлого боловсруулагчдыг цаашдаа дунд хугацааны нийгэм, эдийн засгийн гол асуудлуудад илүү төвлөрөх боломжийг олгох юм.

Хүснэгт ES.1. | Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2016	2017	2018	2019	2020 урьд	2021 төс	2022 төс
	өөрөөр тусгаагүй бол жилийн өөрчлөлт, хувиар						
ДНБ-ий бодит өсөлт, тогтмол үнээр	**1.4**	**5.4**	**7.0**	**5.0**	**-5.2**	**4.3**	**5.4**
Хувийн хэрэглээ	-2.2	5.4	12.4	9.9	2.0	3.6	4.5
Засгийн газрын хэрэглээ	10.6	-1.8	-0.8	11.5	17.5	-5.1	1.6
Үндсэн хөрөнгийн хуримтлал	0.5	35.6	21.3	23.5	-16.3	9.0	10.0
Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт	13.8	14.8	24.0	9.1	-5.0	13.4	7.4
Бүтээгдэхүүн, үйлчилгээний импорт	12.7	24.8	30.9	22.3	-9.0	14.1	8.4
ДНБ-ий бодит өсөлт, хүчин зүйлсийн тогтмол үнээр	**1.2**	**5.3**	**7.2**	**5.2**	**-5.2**	**4.3**	**5.4**
Хөдөө аж ахуй	6.2	1.8	4.5	8.4	10.8	5.0	6.0
Аж үйлдвэр (уул уурхайг оруулаад)	-0.4	0.7	7.9	3.1	-11.0	6.3	5.4
Үйлчилгээ	1.1	7.7	4.7	5.8	-5.7	2.5	5.2
Инфляц (ХҮИ, хугацааны эцэст)	**0.9**	**6.4**	**8.1**	**5.2**	**2.3**	**5.0**	**7.0**
Урсгал дансны тэнцэл (ДНБ-ий хувиар)	**-6.3**	**-10.2**	**-16.8**	**-15.4**	**-3.3**	**-7.7**	**-8.3**
Санхүүгийн болон Хөрөнгийн данс (ДНБ-ий хувиар)	**7.6**	**24.5**	**17.4**	**21.1**	**9.2**	**11.8**	**13.2**
Гадаадын шууд хөрөнгө оруулалт, цэвэр (ДНБ-ий хувиар)*	1.1	12.7	16.3	16.5	12.5	14.0	15.0
Төсвийн тэнцэл (ДНБ-ий хувиар)**	**-15.3**	**-3.8**	**2.6**	**1.4**	**-9.5**	**-2.7**	**-1.9**
Анхдагч тэнцэл (ДНБ-ий хувиар)	**-10.1**	**0.4**	**5.8**	**3.7**	**-6.9**	**-0.3**	**0.1**
Засгийн газрын өр (ДНБ-ий хувиар)***	**87.6**	**84.7**	**72.6**	**69.0**	**79.4**	**77.7**	**73.0**

* 2016 оны хувьд цэвэр ГШХО-ын дүнд 2016 оны 5-6 сарын Оюу Толгой-2 төслийн санхүүжилтийн дүн ороогүй болно.

**Хөгжлийн банкны зардлыг төсвийн тэнцэлд оруулаагүй бөгөөд тусдаа хянагдана.

***Засгийн газрын өрийн дүнд төрийн өмчит компаниудын өр болон Монголбанкны Хятадын ардын банкнаас своп хэлцлийн шугамаар авсан өр төлбөр ороогүй болно.

ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

I. ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

А. Эдийн засгийн сүүлийн үеийн төлөв байдал 2

Б. Төлөв байдал ба эрсдэлүүд 24

I. ЭДИЙН ЗАСГИЙН ГҮЙЦЭТГЭЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

A ЭДИЙН ЗАСГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

A1. Үйлдвэрлэл 2020 оны эхний 9 сард огцом агшив

Түүхэнд тэмдэглэгдэн үлдэх КОВИД-19 цар тахал дэлхийн эдийн засгийг нөмөрснөөр эдийн засгийн үйл ажиллагаа дэлхийн өнцөг булан бүрд зогсонги байдалд оров. Цар тахалтай холбоотой хөл хорионы улмаас Зүүн Ази, Номхон далайн (EAP) бүс нутгийн эдийн засгийн нөхцөл байдал улам хүндрэв. Хятадын эдийн засаг хурдацтай сэргэж байгаа ч бүс нутгийн бусад хэсэгт эдийн засгийн үйл ажиллагаа хүлээгдэж байснаас сул байх тул сэргэлт удаан, тогтворгүй байх төлөвтэй. Цар тахал нь нас баралт, өвчлөлийг нэмэгдүүлж, сая сая хүнийг ядуурал хүргэж, эдийн засгийн идэвхжил, орлогыг урт удаан хугацааны турш царцааж магадгүй байна. Үүний сацуу цар тахлаас шалтгаалан улс орнуудын өр нэмэгдэж, түүхэн өндөр түвшинд хүрсэн тул өрийн асуудлыг хурцатгаж, санхүүгийн зах зээлийн эмзэг байдлыг нэмэгдүүлж магадгүй байна.

Монгол Улсад цар тахлын хямрал нь аж ахуйн нэгжүүд, өрхийн амьжиргаа, төсвийн орлогод нөлөөлж эдийн засгийн томоохон хүндрэлийг дагуулав. Энэхүү нөлөө нь дараах 4 үндсэн сувгаар илэрч байна: (i) халдварыг тогтоон барих Засгийн газрын арга хэмжээ нь жижиг бизнес болон өрхийн орлогод шууд сөргөөр нөлөөлж нэгэнт суларч байсан эдийн засгийн дотоод идэвхжилийг улам царцаав (шигтгээ I.1-ийг үзнэ үү); (ii) Хятадын эрэлт буурч, халдвараас шалтгаалан хил хаагдаж, түүхий эдийн үнэ унасны зэрэгцээ хөрөнгө оруулагчид эрсдэлээс болгоомжилсон явдал нь уул уурхайн салбарт хүчтэй цохилт болов; (iii) цар тахлыг хязгаарлах арга хэмжээ нь Монголын эдийн засгийн 40 хувийг бүрдүүлдэг үйлчилгээний сектор (аялал жуулчлал, тээвэр ороод)-т сөргөөр нөлөөлөв; (iv) төсвийн орлого тасалдаж эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зардал өсөн нэмэгдсэн нь төсвийн дарамтыг улам даамжруулав.

Шигтгээ I.1.
Монгол Улсын Засгийн газрын КОВИД-19 цар тахлыг тогтоон барих хүчин чармайлт

Улс орны түвшин дэх онцгой байдалд хариу үйлдэл үзүүлэх үүрэгтэй Улсын онцгой комисс /УОК/-оор дамжуулан Монгол Улсын Засгийн газар 2020 онд КОВИД-19 цар тахлыг тогтоон барих хэд хэдэн арга хэмжээ авав. Үүнд:

- **Хил хаах** – 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Хятадаас (агаар, автозам, төмөр замаар) болон Хятадаар дамжих бүх зорчигч тээврийг зогсоов. Засгийн газраас зохион байгуулах чартер нислэгээр ирж буй монголын иргэдийг эс тооцвол хил дамнасан зорчигч тээврийн бүх хэлбэрийг 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зогсоов. Дотоод халдварын эрсдэлийг бууруулахын тулд чартер нислэгээр ирсэн иргэдийг 21 хоног карантинд заавал байлгаж байна. ОХУ-аас өргөн хэрэглээний бараа тээвэрлэж буй ачааны машинуудад тавих эрүүл ахуйн шаардлагыг чангатгав.
- **Экспортыг зогсоох** – Нүүрс, түүхий нефтийн экспортыг 2 дугаар сарын 10-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр зогсоосон нь Монгол-Хятадын хилээр нэвтэрч буй ачааны машины жолооч нарын халдвар авах эрсдэлийг бууруулах зорилготой байв. Хуваарийн дагуу хилийг эргэн нээсэн ч экспорт сэргээгүй тул Засгийн газраас 8 дугаар сард "Ногоон гарц" хөтөлбөрийг санаачлав. "Ногоон гарц"-ын зорилго нь гаалийн бүрдүүлэлтийг эрчимжүүлж, ариун цэврийн шаардлагыг зохих ёсоор биелүүлсний үндсэн дээр ачаа тээврийг хурдасгахад оршиж байв.
- **Боловсролын үйл ажиллагааг зогсоох** – дунд болон их дээд сургууль, мэргэжил, үйлдвэрлэлийн төв, бүх шатны мэргэжлийн бэлтгэлийн төвүүдийн үйл ажиллагааг 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл зогсоов. Сурагчдын хичээл 9 дүгээр сарын 1-ний өдөр цахимаар эхэлсэн бол 9 дүгээр сарын 21-ний өдрөөс анги танхимын хэлбэрт шилжив.
- **Үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээг хязгаарлах** – бар, кафе, ресторанууд 2020 оны 2 дугаар сарын дундаас 7 дугаар сар хүртэл 4:00 цагт бус харин 22:00 цагт хааж байхаар болов. 5 дугаар сарын эхнээс шөнийн клуб болон караоке-барын үйл ажиллагааг хэдэн сараар хориглов. Засгийн газар 3 дугаар сараас эхлэн олон нийтийг хамарсан арга хэмжээ, тухайлбал, хурал цуглаан, спортын уралдаан тэмцээн, аялал, урлаг, соёлын арга хэмжээ, кино, жолооны сургалт, тоглоомын төвүүдийн үйл ажиллагааг зогсоов. Яваандаа хязгаарлалтуудыг үе шаттайгаар сулруулж эхэлсэн байдаг.
- **2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр анхны дотоод тохиолдол бүртгэгдсэнээр хатуу хөл хорионы дэглэмд шилжив.** 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл Улаанбаатар хот болон хэд хэдэн аймагт хөл хорионы дэглэм тогтоов. Архи согтууруулах ундааг зарж борлуулах, гудамж талбайгаар явган буюу автомашинтай зорчихыг хориглов (хүнсний дэлгүүр орох, эрүүл мэндийн болон бусад зайлшгүй үйлчилгээг эс тооцвол). Нийтийн тээвэрлэлтийг хязгаарлаж, хот хоорондын хөдөлгөөн, чартер нислэгийг зогсоов. Хөл хорионы үеэр эрх баригчид дотоод тохиолдлыг илрүүлэх үүднээс хавьтлын болон санамсаргүй түүвэрлэгдсэн иргэдээс PCR шинжилгээ авч байв. 12 дугаар сарын 14-ний өдөр хатуу хөл хориог сулруулснаар хүн хоорондын зайг мөрдлөг болгож чадах байгууллагуудын үйл ажиллагааг нээхийг зөвшөөрөв. Хот хоорондын хөдөлгөөнд оролцохын тулд шинжилгээ өгсөн байх ёстой. Анги танхимаар хичээллэхийг 11 дүгээр сарын 11-ний өдрөөс зогсоож зайны сургалтад шилжив.
- **Хөл хорионы дэглэмийг Улаанбаатар хотод түр сулруулсны дараа 12 дугаар сарын 14-ний өдрөөс дахин чангаруулав.** КОВИД-19 халдварын тохиолдол нэмэгдсэнээр эрх баригчид хатуу хөл хориог 2021 оны 1 дүгээр сарын 11 хүртэл тогтоохоор болов. Өмнө нь зөвшөөрч байсан хүргэлтийн үйлчилгээг хязгаарласан нь хот доторх хөдөлгөөнийг хязгаарлах зорилготой байв. Хөл хорионы улмаас бизнесийн үйл ажиллагаа, эдийн засагт хохирол учирч байсан тул 1 дүгээр сарын 11-ний өдрөөс хөл хориог шат дараатайгаар сулруулж эхлэв.

Эх сурвалж: Засгийн газрын цахим хуудаснууд.

Цар тахлын дэгдэлт, түүнийг тогтоон барих арга хэмжээтэй холбоотойгоор Монгол Улсын эдийн засаг маш том уналттай тулгараад байна. Экспортын гол бараа болох зэсийн агууламж муудсан, түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ буурсантай холбоотойгоор Монголын эдийн засгийн өсөлт 2019 оны 2 дугаар хагасаас саарч байсан бол яг энэ үетэй давхцаад КОВИД-19 цар тахлын шоктой нүүр тулсан билээ. Цар тахлын сөрөг нөлөө Монголын эдийн засагт дотоод болон гадаад сувгуудаар дамжин нөлөөлсний үр дүнд, Монголын ДНБ 2020 оны эхний 9 сарын байдлаар 7.3 хувиар агшаад байна. Энэ нь Монгол Улсын хувьд 1990-ээд оны шилжилтийн үеэс хойших хамгийн томоохон уналт юм (зураг I.1). Эдийн засгийг бүхэлд нь доргиосон уналт ялангуяа уул уурхай (жилийн -20.7 хувь), уул уурхайн бус аж үйлдвэр (-3.7 хувь), үйлчилгээний салбарт (-7 хувь) онцгой мэдрэгджээ. Харин цаг агаарын таатай нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өсөж эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн байна. Эдийн засгийн гадаад орчин муудаж байх явцад эрх баригчдын цар тахлыг тогтоон барих хязгаарлалтын арга хэмжээ нь (үүний дотор экспортын хориг багтана) дотоод эдийн засгийн идэвхжилийг эрс сулруулаа.

Хувийн хэрэглээний өсөлт 2020 оны эхний 9 сард саарсан ч, эрэлтийн талаас өсөлтийг дэмжих гол хүчин зүйл хэвээр байв (зураг I.2). Эцсийн хэрэглээ 2019 оны эхний 3 улиралд жилийн 9.9 хувиар өсөж байсан бол 2020 оны мөн үед 7.1 хувиар өсжээ. Өрхийн хэрэглээ 2019 оны эхний 3 улиралд 9.5 хувиар өсөж байсан бол 2020 оны дээрх хугацаанд өсөлт нь 6.1 хувь хүртэл буурчээ. Энэ нь цар тахлын эсрэг арга хэмжээ жижиглэн худалдаа, амралт аялал, үзвэр үйлчилгээний хувийн зардалд нөлөөлсөнтэй холбоотой байна. Утсанд суурилсан өрхийн судалгааны үр дүнгээс харахад цар тахал иргэдийн цалин хөлсний орлогод, тэр дундаа хувиараа хөдөлмөр эрхэлдэг мөн бизнес эрхлэгчдийн орлогод хүчтэй нөлөөлсөн байхаар байна. Харин, өрхийн хэрэглээ ийнхүү өссөн нь цалин, тэтгэврийн өсөлт, тэтгэврийн зээлийг тэглэх шийдвэр, КОВИД-19 цар тахалтай холбоотой Засгийн газраас олгосон орлогын дэмжлэг зэрэг арга хэмжээтэй холбоотой байна. Түүнчлэн, цар тахалтай холбоотой төсвийн зардлууд нэмэгдсэнээр засгийн газрын хэрэглээ 11.7 хувиар өсжээ.

Хөрөнгө оруулалт (ялангуяа хувийн секторын) эрс буурсан нь дотоод эрэлтэд сөргөөр нөлөөлөв. Үндсэн хөрөнгийн хуримтлалын ДНБ-ий өсөлтөд оруулах хувь нэмэр 2019 онд +10 нэгж хувь байсан бол 2020 оны эхний 9 сард хасах утгатай болжээ (-14.3 нэгж хувь). Энэ нь түүхий эдийн үнэ, дотоод эрэлт, хөрөнгө оруулагчдын итгэл буурсан зэрэг хэд хэдэн хүчин зүйлстэй холбоотой. Тухайлбал, үндсэн хөрөнгийн хуримтлалын 70 хувийг бүрдүүлдэг гадаадын шууд

Зураг I.1. Уул уурхай болон үйлчилгээний сектор унаж, эдийн засаг агшихад голлон нөлөөлөв



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.2. Хувийн хэрэглээ тогтвортой өссөн боловч хөрөнгө оруулалтын хурдацтай уналтыг нөхсөнгүй



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

хөрөнгө оруулалт /ГШХО/-ын урсгал 2020 оны эхний 9 сард жилийн 20 хувиар буурч 1.2 тэрбум ам.долларт хүржээ. Түүнчлэн, дотоодын хөрөнгө оруулалтын үндсэн эх сурвалж болсон банкны зээлийн үлдэгдэл жилийн 5 хувиар буурч байгаа нь зээлийн чанар муудаж байгаатай холбоотой. Нөгөө талаас, улсын секторын хөрөнгө оруулалтыг эрчимжүүлсэн ч хувийн секторын хөрөнгө оруулалтын уналтыг нөхөж чадсангүй.

Экспорт эхний хагас жилд огцом буурсан ч хурдацтай сэргэв (зураг I.3). 2020 оны эхний 9 сард бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт бодит дүнгээр 8 хувиар буурсан нь 2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш тохиож буй хамгийн том уналт юм. Гэтэл 2019 оны мөн үед бодит экспорт 15.1 хувиар өсөж байжээ. Хятадын эрэлт суларч, цар тахлын эрсдэлийг тогтоон барих үүднээс 2020 оны 2-3 дугаар сард экспортыг түр зогсоосноор нүүрс, түүхий нефтийн экспорт (2019 оны экспортын 45 хувийг бүрдүүлж байв) мэдэгдэхүйц буурав. Үүний сацуу цар тахлын нөлөөгөөр зэсийн эрэлт, үнэ буурч, Монголын зэсийн экспорт (2019 оны экспортын 24 хувийг бүрдүүлж байв) 1 дүгээр улиралд огцом буурахад нөлөөлөв. Гэвч экспорт 3 дугаар улирлаас хурдацтай сэргэсэн нь түүхий эдийн үнэ өссөн, цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ суларсан, Засгийн газраас экспортыг сэргээх "Ногоон гарц" хөтөлбөрийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байв.[2] Үүний сацуу 2020 оны 3 дугаар улиралд алтны экспорт 2008 оноос хойш оргилдоо хүрсэн нь Төв банкнаас алт олборлогч компаниудад хөнгөлөлттэй зээл (эхний 10 сард ДНБ-ий 0.3 хувьтай тэнцэх) олгосонтой холбоотой.

Дотоодын эрэлт суларч, түлш шатахууны үнэ буурснаар импорт мэдэгдэхүйц агшив. Эрчим хүчний цэвэр импортлогч улсын хувьд дэлхийн зах зээлд нефтийн үнэ буурсан нь Монгол Улсад ашигтай байв. Бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит импорт 2019 оны эхний 3 улиралд 23.2 хувиар өсөж байсан бол 2020 оны эхний 3 улиралд жилийн 8 хувиар агшжээ (зураг I.4). Импортын агшилтад үндсэн хөрөнгийн худалдан авалт багассан (хувийн хөрөнгө оруулалт буурсны илрэл), нефтийн үнэ буурсан, хэрэглээний барааны импорт цар тахалтай холбоотойгоор (2020 оны Цагаан сарыг тэмдэглэхгүй байх шийдвэр гарч жижиглэн худалдаа болон үйлчилгээний бусад салбарт идэвхжил суларсан) агшсан нь тус тус нөлөөлжээ. Үйлчилгээний импорт мөн ялгаагүй буурсан нь тээврийн үйлчилгээний эрэлт суларсан (зорчих хөдөлгөөн болон ачаа тээвэрт тавьсан хязгаарлалтаас шалтгаалан), гадаад аялал жуулчлал болон гадаадын зөвлөх үйлчилгээ (ялангуяа уул уурхайн секторт) багассантай холбоотой юм.

Зураг I.3. Экспорт эхний хагас жилд хүнд цохилтод орсон ч хурдацтай сэргэв



Эх сурвалж: ҮСХ.

Зураг I.4. Дотоодын эрэлт суларч, түлш шатахууны үнэ буурсан нь импортод нөлөөлөв



Эх сурвалж: ҮСХ.

[2] Засгийн газрын "Ногоон гарц" санаачилга нь нүүрс, зэсийн экспортыг алгуур сэргээхэд тус дэм болов.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл ялангуяа 2020 оны эхний хагаст огцом буурсан ч хурдацтай сэргэв. 2020 оны эхний хагаст нүүрс олборлолт жилийн 49 хувиар, экспорт нь жилийн 52.1 хувиар тус тус буурчээ.[3] Тус салбар ийнхүү унасан нь Хятадын эрэлт муудсан, эрх баригчдын зүгээс цар тахлын эсрэг авсан арга хэмжээтэй холбоотой.[4,5] Мөн хугацаанд түүхий нефтийн олборлолт өмнөх оны мөн үеэс 70 хувиар агшжээ. 2020 оны эхний хагаст зэсийн үйлдвэрлэл 8 хувиар буурсан нь Оюу толгойн баяжмал дахь зэсийн агууламж муудсан, дэлхийн зах зээлийн үнэ буурсны илэрхийлэл болов.[6] Харин, 3 дугаар улиралд уул уурхайн секторын үйлдвэрлэлийн уналт саарч жилийн 5.2 хувьд хүрсэн юм (зураг I.5). Тус салбарын агшилт ийнхүү саарахад алтны үнэ өссөн, Монголбанкнаас алт олборлох, экспортлохыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлсэн нь голлон нөлөөлжээ.[7,8] Үүгээр зогсохгүй Засгийн газрын нүүрсний экспортыг нэмэгдүүлэх хүчин чармайлтын үр дүнд ("Ногоон гарц" г.м.) нүүрс олборлолт ч мөн 3 дугаар улиралд сэргэжээ.

Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл ч мөн мэдэгдэхүйц буурсны дотор үйлчилгээний секторт КОВИД-19 цар тахал хүндээр тусав. Уул уурхайн бус ДНБ 2019 онд жилийн 6.7 хувиар өссөн бол 2020 оны эхний 9 сард жилийн 3.7 хувиар буурав (зураг I.6). Үйлчилгээний салбар (үндсэндээ худалдаа ба тээвэр) 13-25 хувиар агшсан нь уул уурхайн сектортой нягт холбоотойг нь харуулна. Боловсруулах салбарын бүтээгдэхүүн 2019 онд 9.2 хувийн өсөлт үзүүлж байсан бол 2020 оны эхний 9 сард жилийн 6.6 хувиар буурлаа. Энэ нь үндсэндээ оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний салбарын уналттай холбоотой байна.[9] Барилгын салбарын ДНБ 2019 онд 8 хувиар өсөж байжээ. Хэдийгээр 2020 оны хувьд Засгийн газраас төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой төслүүдийг эрчимжүүлж, Монголбанкнаас орон

Зураг I.5. Уул уурхайн салбар оны эхний хагаст огцом унасан ч хурдацтай сэргэв



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.6. Уул уурхайн бус үйлдвэрлэлийн агшилтыг үйлчилгээний сектор тодорхойлов



Эх сурвалж: ҮСХ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[3] 2019 оны уул уурхайн экспортын 45 хувийг нүүрс бүрдүүлж байв.
[4] Урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотойгоор 2-3 дугаар сард экспорт зогссон нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл огцом унахад нөлөөлөв.
[5] 2019 онд нүүрсний үйлдвэрлэл 1.9 хувиар өсөж 50.8 сая тонн, нүүрсний экспорт 2 хувиар өсөж 36.5 сая тоннд тус тус хүрсэн нь түүхэн дээд амжилт байв.
[6] КОВИД-19 цар тахал түүхий эдийн захад хүчтэй нөлөөлж, улмаар 2020 оны эхний хагаст зэсийн үнэ 14.3 хувиар унав.
[7] 2020 оны эхний 9 сард алтны үйлдвэрлэл жилийн 35 хувиар өсөв.
[8] Монголбанкнаас алт олборлогчдод олгосон хөнгөлөлттэй зээл алт үйлдвэрлэлийг дэмжсэн байх талтай.
[9] Бизнесийн идэвхжил суларсан нь боловсруулах салбарын 14 орчим хувийг бүрдүүлдэг оёмол сүлжмэл бүтээгдэхүүний салбарын уналтыг (ялангуяа ноолууран бүтээгдэхүүн) тодорхойлов.

сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг олгох ажлыг сэргээсэн ч орон сууцны болон үйлдвэрлэлийн барилгын ажил багассан (гол төлөв Оюу толгойн гүний уурхайн төслийн явц удааширсан)-тай холбоотойгоор барилгын сектор дээрх хугацаанд жилийн 6.3 хувиар агшсан байна. Харин хөдөө аж ахуйн салбарын өсөлт 2019 оны 8.4 хувиас 2020 оны эхний 9 сарын байдлаар 11.3 хувьд хүрч эрчимжсэн. Энэ нь цаг агаарын тааламжтай нөхцөл, малын зүй бус хорогдол бага байсантай холбоотой байна. Дотоод эрэлт багасаж, импорт агшсан (автомашин болон уул уурхайтай холбоотой үндсэн хөрөнгийн импорт огцом буурсан)- тай холбоотойгоор бүтээгдэхүүний цэвэр татвар жилийн 8.4 хувиар буурчээ.

А2. Нефтийн үнэ буурч, дотоод эрэлт суларснаар инфляц эрчимтэй буурав

Дотоод эрэлт сул байсантай холбоотойгоор инфляц 2020 онд нам түвшинд байлаа. 2019 оны 12 дугаар сард инфляц 5.2 хувьтай байсан бол 2020 оны 12 дугаар сард 2.3 хувь болжээ. Хувийн хөрөнгө оруулалт огцом унаж, хувийн хэрэглээний өсөлт саарсан нь дотоодын эрэлтийн гаралтай инфляцын дарамтыг сулруулав (зураг I.7). Нийлүүлэлттэй холбоотой хүчин зүйлс ч мөн (Монгол нефтийн цэвэр импортлогч улс тул дэлхийн зах зээл дэх нефтийн үнэ буурсан нь эергээр нөлөөлсөн) инфляцыг бага түвшинд байлгахад нөлөөлөв. Түүнчлэн, засгийн газраас сайжруулсан түлшний үнийг бууруулсан нь 2020 оны эцэст инфляц буурах нэг гол шалтгаан боллоо. Харин хүнсний бүтээгдэхүүний инфляц оны эцэст 8.5 хувьд хүрч өндөр түвшинд хадгалагдсан нь цар тахалтай холбоотойгоор иргэд хүнсээ нөөцөлсөнтэй холбоотой байж болзошгүй.

Инфляцын дарамт бага орчинд КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг үр дагаврыг зөөлрүүлэхийн тулд мөнгөний бодлогын хүүг түүхэн доод түвшинд хүргэв. Суурь инфляц 2020 оны 1 дүгээр улиралд жилийн 5.2 хувь байсан бол 2020 оны эцэст 0.2 хувь болж буурсан нь дотоодын эрэлт суларсныг илтгэнэ (зураг I.8). Цар тахалтай холбоотой тодорхойгүй байдал нэмэгдсэн тул банкуудын шинээр зээл гаргах сонирхол сул байж, улмаар 2020 оны 3 дугаар сараас эхлэн зээлийн өсөлт хасах болж эхэлсэн. Энэ нь ч бас суурь инфляц буурахад нөлөөлөв. Ийнхүү бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар буулгаж 6 хувьд хүргэсэн нь түүхэн доод үзүүлэлт болж байна.

Зураг I.7. Дотоод эрэлт хумигдаж, нефтийн үнэ буурсан нь инфляц буурахад нөлөөлөв ...



Эх сурвалж: ҮСХ-ны бюллетень; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.
Жич: Үндэсний тооцооноос эцсийн хэрэглээ болон хөрөнгө оруулалтын нийлбэрийг дотоод эрэлт гэж үзэв. БГТ = баруун гар тал; ЗГТ = зүүн гар тал.

Зураг I.8. ... дотоодын зээл агшилт энэ нөлөөг улам хүчтэй болгов.



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.
Жич: БГТ = баруун гар тал; ЗГТ = зүүн гар тал.

А3. Цар тахлын нөлөөгөөр хөдөлмөрийн зах, түүний бүтцэд зарим өөрчлөлт ажиглагдав

КОВИД-19 цар тахлын улмаас зарим салбарт ажил эрхлэлт буурч, ажиллах хүчний оролцооны түвшин сүүлийн арваад жилийн доод түвшинд хүрлээ. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллээр 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад нийт ажил эрхлэлт 20,400 хүнээр (жилийн 1.7 хувиар) нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үеэс ажил эрхлэлт өсөлттэй гарсан нь төрөөс ажлын байрыг хадгалах зорилгоор аж ахуйн нэгжүүдэд олгож буй томоохон хэмжээний дэмжлэгтэй холбон тайлбарлахаар байна.[10] Харин, ажиллагсдын ур чадвар, салбаруудын цар тахалд өртсөн байдал зэргээс шалтгаалан ажил эрхлэлт зарим салбаруудад харилцан адилгүй өсөж, буурсан дүр зураг ажиглагдлаа. Тухайлбал, ҮСХ-ны ажиллах хүчний судалгаагаар 2020 оны 9 дүгээр сарын байдлаар уул уурхай, барилга, үйлдвэрлэл, ХАА, үзвэр үйлчилгээний салбаруудад ажил эрхлэлт бууралттай байна. Энэ нь цар тахалтай холбоотой хөл хорио болон бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс голлон шалтгаалсан байх талтай (зураг I.9). Тодруулбал, мэдээллийн технологи, санхүү, боловсрол, эрүүл мэнд зэрэг мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг салбаруудтай харьцуулахад үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудад харьцангуй ур чадвар доогуур, албан бус ажлын байр зонхилдог тул эдгээр салбарт ажиллагсад нь цар тахлын үед ажлын байрны баталгаагүй, мөн гэрээсээ ажиллах боломж нь хомс байсан байх боломжтой юм. Харин, цар тахалтай холбоотойгоор сүүлийн нэг жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарын ажиллагсдын тоо нэмэгджээ. Мөн мэдээлэл харилцаа холбоо, худалдааны салбарын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн бөгөөд үүнийг хөл хориотой орчинд эдийн засгийн үйл ажиллагаа илүү цахим хэлбэрт шилжсэн, цахим худалдаа эрчимжиж буйтай холбон тайлбарлахаар байна.[11] Харин, дээрх хугацаанд нийт ажиллах хүч (хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд) өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурч, ажиллах хүчнээс гадуурх иргэд 4 хувиар

Зураг I.9. КОВИД-19 цар тахал зарим ажлын байрыг эрсдэлд оруулав...

Эх сурвалж: ҮСХ-ны бюллетень; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.10. ... ажилгүйдэл буурч байсан сүүлийн жилүүдийн хандлага өөрчлөгдөв



Эх сурвалж: ҮСХ-ны бюллетень; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[10] Эдгээр арга хэмжээнүүдэд татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс хөнгөлөх, ажиллагсдаа цомхотгоогүй аж ахуйн нэгжүүдэд ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг олгох зэрэг арга хэмжээнүүд багтана.

[11] Коронавирусийн өрхөд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зорилгоор ҮСХ болон Дэлхийн Банкнаас хамтран зохион байгуулсан Утсанд суурилсан өрхийн судалгаа (ҮСӨС)-наас харахад цар тахлын хувийн сектор дахь ажил эрхлэлтэд үзүүлэх сөрөг нөлөө нь 2020 оны 11 дүгээр сараас тогтоосон хөл хориотой холбоотойгоор эрчимжсэн байхаар байна (дэлгэрэнгүйг II бүлгээс үзнэ үү).

нэмэгдээд байна. Эндээс харахад цар тахлын үед шинээр ажилд орох нь хүндрэлтэй болж, зарим ажил идэвхтэй хайж байсан иргэдийн тоо буурч, ажиллах хүчнээс гарсан байж болзошгүй юм.

Ажилгүйдлийн түвшин 2020 оны 3 дугаар улиралд бага зэрэг өсөв. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл огцом агшсан ч ажилгүйдлийн түвшин 2020 оны эхний хагаст харьцангуй тогтвортой байлаа. Үүнд төсвөөс олгосон орлогын томоохон дэмжлэг эергээр нөлөөлөв.[12] Гэсэн хэдий ч ажилгүйдлийн түвшин оны эхний хагаст 6.6 хувь байсан бол 3 дугаар улиралд 7.3 хувь болж алгуур өсжээ (зураг I.10).[13] Ажилгүйдлийн түвшин эрчүүдийн дунд хурдтай өссөн нь эмэгтэйчүүд ажиллах хүчнээс гарсан, ажил идэвхтэй хайж буй эмэгтэйчүүдийн тоо цөөрсөнтэй холбоотой юм.

Орлогын харамгүй дэмжлэг нь цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөөг зөөлрүүлсэн байх магадлалтай (дэлгэрэнгүйг II хэсгээс үзнэ үү). Эдийн засгийн хямралын үед ажилгүйдлийн түвшин алгуур өсөх, ажиллах хүчний оролцоо хумигдах нь ихэнх тохиолдолд хүмүүсийн ажил олдоно гэх итгэл цөхөрч ажил хайхаа больсны илэрхийлэл байдаг. Иргэд хурдацтай тархаж буй КОВИД-19 вирусийн халдвараас эмээн ажил эрж хайхаа больсныг үгүйсгэх аргагүй. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа анги танхимд явагдахаа байж ажилгүй эцэг эхчүүд ар гэр, үр хүүхдээ харж хандах ажилд уягдан ажил эрэхээ байсан байж болно. Энэ нь ялангуяа асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг уламжлалт ёсоор хүлээдэг эмэгтэйчүүдэд бүр ч хамаатай билээ. Түүнчлэн нийгмийн өгөөмөр халамж, тэтгэмж нь өрхийн санхүүгийн боломжийг нэмэгдүүлж, ажил хайх хэрэгцээ шаардлагыг сулруулсан байж болно (зураг I.11). Ажилгүй байгаа иргэдийн хувьд орлогын тусламжийн гол эх үүсвэр нь өрхийн дэмжлэг хэвээр байна. 2019 онд ажилгүй иргэдийн 85 хувь нь гэр бүлийн гишүүдийн санхүүгийн дэмжлэг нь орлогын гол эх үүсвэр болж буйг тэмдэглэж байжээ. Энэ үзүүлэлт 2020 оны 2 дугаар улиралд 80 хувь болж буурсан бол ажилгүй иргэдийн 14 орчим хувь нь ихэвчлэн бэлэн мөнгөн шилжүүлэг, нийгмийн халамжийн тэтгэмжид найддаг хэмээн мэдээлжээ (зураг I.12).

Зураг I.11. Ажилгүй иргэдийн хувьд 2020 оны эхний хагаст мөнгөн шилжүүлэг чухал болжээ

Эх сурвалж: ҮСХ (Ажиллах хүчний судалгаа 2019, 2020); Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.12. Ажилгүй иргэдийн орлогын гол эх үүсвэрт 2020 оны II улирлаас өөрчлөлт оржээ



Эх сурвалж: ҮСХ (Ажиллах хүчний судалгаа 2019, 2020); Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[12] Эдгээр арга хэмжээнүүдэд татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс хөнгөлөх, ажиллагсдаа цомхотгоогүй аж ахуйн нэгжүүдэд ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг олгох зэрэг арга хэмжээнүүд багтана.

[13] 2020 оны эхний хагас жилд 83.7 мянган ажилгүй иргэд байсан бол 9 дүгээр сард 92.6 мянга болж өсжээ.

А4. Төсвийн алдагдал 2020 онд огцом нэмэгдсэн ч 2021 онд буурахаар байна

Цар тахлаас үүдэн эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж төсвийн орлого тасарсан, нөгөө талдаа туслалцаа дэмжлэгтэй холбоотойгоор зардал өссөн нь 2020 онд төсөв ихээхэн хэмжээний алдагдалтай гарахад нөлөөлөв. 2020 онд төсвийн нийт орлого жилийн 13 хувиар буурсан нь эрдэс баялгийн олборлолтоос олох орлого унасан, хэрэглээ буурсан, орлого тасарсан, татварын хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой байв (зураг I.13).[14] Татварын орлого жилийн 12.8 хувиар, татварын бус орлого жилийн 12.6 хувиар тус тус буурчээ. Цар тахлаас үүдэн дэмжлэг туслалцаа үзүүлэх, уул уурхайн орлого буурахтай зэрэгцэн татварын орлогын 61 хувийг бүрдүүлдэг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар жилийн 15.8 хувиар, нийгмийн даатгалын шимтгэл 19.6 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 11.2 хувиар тус тус буурчээ. Түүнчлэн, цар тахлыг хумих зорилгоор авсан арга хэмжээ ажлын байр, орлогод нөлөөлснөөр хүн амын орлогын албан татвар жилийн 7.2 хувиар буурчээ. Онцгой албан татвар болон гаалийн хураамжийн орлого мөн буурав. Төсвийн алдагдал 2020 оны хүлээгдэж буй ДНБ-ий 3.9 хувьд 2020 оны 7 дугаар сар гэхэд хүрсэн тул 2020 оны төсвийн тодотголын хүрээнд орлого нэмэгдүүлэх зарим арга хэмжээг авав (татварын өрийг цуглуулах, төрийн өмчит компаниудын татварыг урьдчилан авах г.м.).

Цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ зардлыг ийнхүү өсгөв. Төсвийн нийт зарлага 2019 онд 24 хувиар өссөн бол 2020 онд 22.1 хувиар өсжээ (зураг I.14). Хямралд хариу үйлдэл үзүүлэхтэй холбоотойгоор нийгмийн халамж, хамгааллын зардал дээрх хугацаанд жилийн 128.7 хувиар өсөв (хүүхдийн мөнгөний хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбоотой, шигтгээ I.2-ыг үзнэ үү). Мөн хугацаанд эрүүл мэндийн зардал жилийн 27 хувиар өсжээ. Засгийн газраас дотоод эрэлтээ нэмэгдүүлэн эдийн засгаа дэмжихийн тулд төсвийн хөрөнгө оруулалтын зардлаа өмнөх жилүүдээс эрчимжүүлсэн (хөрөнгийн зардлын гүйцэтгэл 8.3 хувиар өндөр) байна.[15]

Зураг I.13. Төсвийн орлого ангилал тус бүртээ тасалдав ...



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: ХХОАТ = хувь хүний орлогын албан татвар, ААНОАТ = аж ахуй нэгжийн орлогын албан татвар, НӨАТ = нэмэгдсэн өртгийн албан татвар.

Зураг I.14. ... гэтэл нийгмийн халамж, улсын хөрөнгө оруулалттай холбоотой төсвийн зардал эрс нэмэгдэв



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[14] Тодруулбал, 2020 оны 7 дугаар сарын байдлаар төсвийн орлогын тасалдал 2020 оны хүлээгдэж буй ДНБ-ий 3.9 хувьд аль хэдийн хүрээд байсан тул төсвийн тодотголыг хэлэлцэж эхэлсэн байдаг.

[15] Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг ДНБ-ий 0.6 хувиар танаж (2020 оны төсвийн тодотголоор) нийгмийн шилжүүлэг, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тодорхой хэсгийг санхүүжүүлсэн билээ.

Орлого тасарч, цар тахалтай тэмцэх зардал нэмэгдсэнээр төсвийн алдагдал ихээхэн тэлэв. Төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ий 9.5 хувьд хүрсэн нь 2016 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт юм (зураг I.15 болон I.16).[16] Төсвийн алдагдал, төсвийн өрийг бууруулах бодлого хэрэгжүүлсэн өмнөх 3 жилд бүрдүүлсэн нөөц хөрөнгө нь 2020 оны эхний саруудад цар тахлыг сөрөн зогсох боломжийг Засгийн газарт олгосон билээ.[17] 2015-2016 оноос ялгаатай нь гэвэл Засгийн газарт 2020 оны эхний 5 сард гадаад, дотоод захаас хөрөнгө босгох шаардлага үндсэндээ байсангүй. Харин 2020 оны 6 дугаар сараас эхлэн Засгийн газрын донорын тусламж авах хэрэгцээ шаардлага нэмэгдсэнээр ОУВС, АХБ, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Япон улсаас 2020 оны сүүлийн хагаст 550 сая ам.долларын төсвийн дэмжлэг авчээ.

Төсвийн алдагдал 2020 онд огцом өссөн ч, 2021 онд эргүүлэн бууруулах бодлого баримтлах төлөвтэй. 2020 оны төсвийн тодотголоор ДНБ-д эзлэх төсвийн алдагдлыг төлөвлөж байсан 2.4 хувиас 9.9 хувь хүртэл өсгөсөн билээ. Харин 2021 оны төсөвт төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувь дотор байхаар тусгасан байна (зураг I.20). Орлого сэргэж (ДНБ-ий 3.4 хувь), зардал дорвитой буурснаар (ДНБ-ий 4.6 хувь) 2021 оны төсвийн нөхцөл байдал эрс сайжрах аж. Төсөвт мөн эдийн засаг 2021 онд 7.2 хувиар өсөх, хил гаалийн шалган нэвтрүүлэх цэгүүдийг шинэчлэн тоноглох, татварын системд цахим технологийг нэвтрүүлэх, төрийн өмчит компаниудын удирдлагыг сайжруулах, малын тоо толгойд шинэ төрлийн татвар ногдуулахаар тусгажээ (шигтгээ I.3-ыг үзнэ үү). Үүний сацуу нийт зардлыг багасгахаар байгаа нь цар тахалтай холбоотой тусламж дэмжлэг үзүүлэх хугацаа дуусгавар болж (хүүхдийн мөнгөнөөс бусад), 2020 оны төсөвтэй харьцуулахад төсвийн хөрөнгө оруулалтыг алгуур бууруулахтай холбоотой байхаар байна. Мөн төсвийн тогтворжуулалтын сан, ирээдүйн өв санг 2019 оны түвшинд хүргэж зузаатгах заалт орсон байна. Эцэст нь Засгийн газраас эдийн засгийн үйл ажиллагаа хурдацтай сэргэж, өрийн нэлээдгүй хэсэг нь хөнгөлөлттэй ангилалд багтсанаар, төсвийн алдагдлыг тодорхой хэмжээнд бууруулж, 2020 онд өссөн өр, ДНБ-ий харьцаа 2021-2022 онд эргээд буурна хэмээн хүлээж байна.

Зураг I.15. Орлого тасарч, зардал үлэмж нэмэгдэв ...



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.16. ... улмаар өнгөрсөн 3 жилийн төсвийн тэнцлийн хандлагыг өөрчлөв...



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[16] 2020 оны төсвийн тодотголоор (2020 оны 8-р сар) ДНБ-д эзлэх төсвийн алдагдлыг төлөвлөж байсан 2.4 хувиас 9.9 хувь хүртэл өсгөжээ.
[17] Эрх баригчид 2017-2019 онд төсвийн зохистой бодлогыг хэрэгжүүлсэн нь төсвийн тодорхой хэмжээний орон зайг бий болгож 2019 оны эцэс гэхэд 2.7 их наяд төгрөгийн (ДНБ-ий 7 гаруй хувь) мөнгөн хөрөнгийн нөөц бүрдүүлэх боломж олгов.

Шиглтгээ I.2. Цар тахлын эдийн засгийн нөлөөг зөөлрүүлэхэд төрөөс үзүүлсэн санхүүгийн тусламж, арга хэмжээ

Улсаас КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор 3.6 их наяд төгрөгийн (ДНБ-ий 9 гаруй хувь) тусламжийг 3 үе шаттайгаар зарцуулав.[18] Улсын тусламж юуны түрүүнд айл өрхүүдийг болон эдийн засгийн уналтад өртсөн компаниуд, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэгдэж компаниудын алдагдлыг сааруулах, дампуурууллахгүй байлгах, ажилгүйдлийг огцом өсгөхгүй байх зорилготой байв. Үүнд ДНБ-ий 3 хувьтай дүйцэх татварын хөнгөлөлт болон ДНБ-ий 6 хувьтай дүйцэх нийгмийн шилжүүлэг, эрүүл мэндийн зардал багтана (зураг I.17).

Зураг I.17. КОВИД-19 цар тахлын нөлөөг сааруулахад чиглэсэн төсвийн арга хэмжээ

Татвар, хураамжийн хөнгөлөлт (ДНБ-ий 3 гаруй хувь)

Нэмэлт зардлууд (ДНБ-ий 6 гаруй хувь)

Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: НДШ = нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ = хувь хүний орлогын албан татвар, ААНОАТ = аж ахуй нэгжийн орлогын албан татвар, НӨАТ = нэмэгдсэн өртгийн албан татвар.

Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Монгол Улс бүс нутагтаа томоохонд тооцогдох төсвийн дэмжлэг туслалцаа үзүүлжээ. Тусламж, дэмжлэгийн багц оновчтой байсан эсэх нь цар тахлын дэгдэлт болон улс орны угтвар нөхцөл байдлаас (тухайлбал, эрүүл мэндийн тогтолцоо, байгалийн баялгаас хамаарах хамаарал, төсөв мөнгөний бодлогын орон зай г.м.) хамаарна. Тэгвэл Зүүн Ази, Номхон далайн бүс нутагт дахь ДНБ-ий 5 хувийн төсвийн зарлагатай харьцуулбал Монгол Улсын хямралын эсрэг тусламжийн багц харьцангуй өндөр байхаар байна (зураг I.18). Тусламжийн гуравны хоёрыг иргэдэд үзүүлсэн нь өрхийн орлогыг дэмжихэд чиглэж байв (зураг I.19). Эдгээр арга хэмжээ нь нийгмийн даатгалыг ашиглан албан секторын ажилтнуудыг хамгаалах, хүн амын эмзэг, ядуу хэсэгт нийгмийн халамж үзүүлэх гэсэн өргөн цар хүрээг хамрав.

Зураг I.18. Монгол Улсын төсвийн дэмжлэг Зүүн Ази, Номхон далайн бүс нутагтаа томоохонд тооцогдоно



Зураг I.19. Төсвийн дэмжлэгт орлогын дэмжлэг, татварын хөнгөлөлт давамгайлав

Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банк 2020b; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Өгөгдлийг 2020 оны 9 дүгээр сарын 12-ны байдлаар харуулав. Өгөгдөл нь ерөнхий засгийн газарт хамаатай бол Индонези, Малайз, Филиппиний хувьд зөвхөн төв засгийн газарт хамаарна. Орлогын дэмжлэгт шууд шилжүүлэг; хорогдуулсан буюу хойшлуулсан төлбөрийн үүрэг; татварын хөнгөлөлт, зээл, чөлөөлөлтөөс алдсан орлого; иргэд аж ахуйн нэгжүүдэд үзүүлсэн бусад санхүүгийн тусламж орно.

[18] Үүнд төсвөөс 2021 оны 7 дугаар сар хүртэл олгох зарим хөнгөлөлт, дэмжлэгүүдийг оруулж тооцсон боловч сүүлд зарласан байрны ашиглалтын мөнгөнөөс чөлөөлөх хөнгөлөлтийг тусгаагүй болно.

Монгол Улсад санхүүгийн хөнгөлөлт, тусламж дэмжлэг үзүүлэх (улмаар эдийн засгийн сэргэлтийг хурдасгах) нэмэлт боломж хомс байна. Засгийн газрын өрийн тогтвортой байдлын хувьд Монгол Улс бусад улсаас тааламжгүй нөхцөлд байна. Хөгжиж буй орнуудын Засгийн газрын өр, ДНБ-ий харьцаа 2019 оны эцэст дунджаар 40 хувь байхад Монгол Улсынх 70 хувьд хүрчээ. Банкуудын илүүдэл нөөц 7.7 их наяд төгрөг, үүний 5.4 их наяд төгрөг нь Төв банкны үнэт цаасанд байршиж байгаа нь дотоодоос зээл авах томоохон боломж байгааг харуулж байна. Гадаад өр ДНБ-ий 60 гаруй хувьтай (хөгжиж буй орнуудын дундаж 40 хувь) тэнцэж байгаа үед гадаад валютаар зээл авах нь төдийлөн тааламжтай хувилбар биш юм. Нүүрсний үнэ буурч буй нөхцөлд Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг ашиглаад ч цар тахлын үр дагаврыг зөөллөхөд хүрэлцэхээргүй байна. 2020 оны 11 дүгээр сарын байдлаар тус санд 150 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө байна.

Эх сурвалж: СЯ, Дэлхийн Банк 2020b; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

2021 оны төсвийн орлогын таамаглалыг бага зэрэг өндрөг байдлаар хийжээ. Халдварын дотоод тархалтаас сэргийлэх хатуу арга хэмжээ үргэлжилж буйг харгалзан үзвэл төсөв 2021 онд 7 хувиар тэлнэ гэх таамаглал өндрөг байж магадгүй. Гэхдээ уул уурхайн экспорт эрчимтэй сэргэж, цар тахлын халдварыг дотооддоо барьж чадвал энэ зорилтоо хүрэх боломжтой. Түүхий эдийн үнийн талаар хийсэн таамаглал олон улсын байгууллагуудын таамаглалтай ерөнхийдөө дүйж байгаа ч экспортыг ялимгүй өндрөгөөр төсөөлсөн байж магадгүй. Тухайлбал, 2021 оны төсөвт нүүрсний экспорт 2021 онд 42 сая тонн болж өснө гэсэн нь 2019 онд хүрсэн түүхэн дээд үзүүлэлт болох 36.6 сая тонноос даруй 15 хувиар өндөр үзүүлэлт юм. Дээрх зорилтод хүрэхийн тулд Засгийн газраас хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулж, хүнд суртлыг багасгаж тоон технологид шилжихээр төлөвлөж байна. Гэвч дотоодын халдварын эсрэг авч буй арга хэмжээ, хөгжингүй орнуудад халдварын тохиолдол эргэн өсөх болгоомжлол хэвээр байгааг харгалзан үзвэл энэ нь өндрөг төсөөлөл юм. Үүгээр зогсохгүй татварын системийн реформуудыг (хялбаршуулах, тоон технологи нэвтрүүлэх, олон улсын татвар ногдуулалтын асуудлууд) хэрэгжүүлснээр төсөвт 1.1 их наяд төгрөгийн (ДНБ-ий 1.5 хувь) нэмэлт орлого төвлөрөхөөр байгаа нь орлогын хүлээгдэж буй өсөлтийн 44 хувийг бүрдүүлнэ гэж үзжээ (зураг I.21). Цар тахал арилаагүй үед энэ зорилтыг төлөвлөсөн хугацаанд амжилттай хэрэгжүүлнэ гэдэг нь томоохон сорилт болж магадгүй.

Зураг I.20. Төсвийн алдагдал 2020 онд үлэмж нэмэгдсэн ч 2021 онд мэдэгдэхүйц буурахаар хүлээгдэж байна



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.21. 2021 оны төсөвт орлогын таамаглалыг бага зэрэг өндрөг байдлаар хийжээ ...



Эх сурвалж: СЯ; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Шигтгээ I.3. 2021 оны төсвийн товч танилцуулга

Монгол Улсын 2021 оны төсөв макро эдийн засгийн дараах өөдрөг төсөөлөлд тулгуурлажээ: (i) эдийн засгийн бодит өсөлт 2020 онд -1 хувь байх бол 2021 онд 7.2 хувиар өснө, (ii) нүүрсний эрэлт өндөр байна, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэнэ, (iii) 2021 онд татварын шинэчлэл үргэлжилнэ, г) төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд нийцтэйгээр 2021 онд инфляц 7 хувьтай байна. Төсвийн хүлээгдэж буй орлого, зарлагыг Хүснэгт I.1.-д үзүүлэв.

Хүснэгт I.1. | Монгол Улс: 2021 оны төсвийн нийт тэнцлийг сайжруулах нь (ДНБ-д эзлэх %)

	2020 оны төсвийн тодотгол	2021 оны батлагдсан төсөв	Зөрүү
Орлого	27.7	31.1	3.4
Тогтворжуулалтын ба Ирээдүйн өв сан	2.6	3.2	0.6
Татварын орлого	22.9	25.5	2.6
Татварын бус орлого	2.3	2.5	0.2
Зарлага	37.7	33.0	-4.6
Урсгал зардал	26.3	23.3	-3.0
Үүнээс: цалин	6.9	5.7	-1.1
Бараа, үйлчилгээ	5.9	4.8	-1.2
Бусад (нийгмийн зарцуулалт орно)	13.5	12.8	-0.7
Хөрөнгө оруулалтын зардал	8.8	8.4	-0.4
Хүүний төлбөр	2.5	2.7	0.2
Нийт тэнцэл	-9.9	-1.9	8.0
Анхдагч тэнцэл	-7.4	0.8	8.2

Эх сурвалж: СЯ.

Монгол Улсын 2021 оны төсвөөс онцлох зүйлс:

- Орлого огцом буурч, цар тахлын нөлөөг сааруулах зардал өссөнөөр 2020 онд огцом нэмэгдсэн төсвийн алдагдлыг бууруулан санхүүгийн тогтвортой байдлыг хангах замд эргэн орох.
- Төсвийг сайжруулахад дараах зүйлс нөлөөлнө. Үүнд:
  - Түүхий эдийн үнэ болон экспортын эрс өсөлттэй холбоотойгоор уул уурхайгаас олох орлого нэмэгдэнэ.
  - Эдийн засгийн өсөлт хурдсаж татварын орлого өнөөгийн болон ирээдүйн бодлогын хүрээнд нэмэгдэнэ.
  - Цар тахлын эсрэг арга хэмжээ дуусгавар болж түүнтэй холбоотой урсгал болон урсгал бус зардлууд хэмнэгдэнэ, төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг оновчтой болгосноор 2021 оны эхний хагас жилд төлөвлөгдсөн томоохон нийгмийн халамж (гол төлөв хүүхдийн мөнгө)-ийн зардлуудыг санхүүжүүлнэ.
  - 2020 оны төсвийн тодотголтой харьцуулахад төсвийн нийт тэнцэл 1 тэрбум ам.доллар (ДНБ-ий 8 хувь), анхдагч тэнцлийн алдагдал 1.1 тэрбум ам.доллар (ДНБ-ий 8.2 хувь)-аар сайжирна.
- Уул уурхайн экспорт сэргэснээр эдийн засаг хурдацтай өсөх өөдрөг боловч хэрэгжих боломжтой төсөөлөл.
- Татварын системийн реформыг (хялбаршуулах, тоон технологид шилжүүлэх, трансферт үнэ бүрдэлтийг нэвтрүүлэх болон гаалийн хүчин чадлыг шинэчлэх зэрэг олон улсын татвар ногдуулалтын асуудлууд) тууштай хэрэгжүүлнэ гэдэгт суурилан орлогын таамаглалыг хийв.
- Цар тахлыг амжилттай тогтоон барьсан тохиолдолд түүнтэй холбоотой урсгал зардлыг бууруулахаар тооцов.
- Төрийн албан хаагчдын тоо, цалингийн фонд, тэтгэвэр тэтгэмж өсөхгүй.
- Хүүхдийн мөнгийг өгөх хугацааг түр сунгасан нь төсвийн нэлээдгүй дарамтыг дагуулна (ДНБ-ий 2.2 орчим хувь).

- Төсвийн хөрөнгө оруулалт (ДНБ-ий 8.4 хувь)-ын зардал 2020 оны төсвийн тодотголтой харьцуулахад бага зэрэг буурах ч (одоо үргэлжилж буй төслүүдийг дуусгахад зориулагдана) цар тахлын өмнөх хурдацтай тэлж байсан түвшнээс давна.
- 2020 оны төсөвт суулгасан хуучин барилгыг нурааж шинээр барих олон төслийг (тухайлбал, улсын драмын болон дуурь бүжгийн эрдмийн театрууд, улсын номын сан) зогсоож засвар үйлчилгээ хийх болсноор ихээхэн хөрөнгө мөнгө хэмнэгдсэн билээ. Нөгөө талаас өнөөгийн төсвийн хөрөнгө оруулалтуудын үр ашиг, эрэмбэ дараалыг сайжруулах орон зай байсаар байна. Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл сүүлийн 3 жилийн дунджаар 80 хувь байв.
- Ерөнхийдөө 2020 оны дунд хугацааны төсвийн төсөөлөлтэй нийцтэй байгаа тул төсвийн сахилга батыг хангах эрмэлзэлтэй байна гэж үзэж болно.

Эх сурвалж: СЯ; 2020 оны төсвийн баримт бичиг; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

A5. Урсгал дансны тохиргоо хийгдсэнээр гадаад дарамт мэдэгдэхүйц буурав

Хөрөнгийн дотогшлох урсгал багасаж, хувийн секторын зүгээс томоохон дүнтэй гадаад төлбөрийг барагдуулсан хэдий ч экспорт сэргэж, импорт агшсанаар гадаад дарамт мэдэгдэхүйц сулрав. 2020 онд Монгол Улсын төлбөрийн тэнцэл 787 сая ам.долларын ашигтай гарав (зураг I.22). Санхүүгийн дансны орох урсгал багассан ч урсгал дансанд томоохон тохиргоо хийгдсэнээр гадаад дарамт ийнхүү сулрахад голлон нөлөөлжээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт татарч (2020 онд 30 орчим хувиар), хувийн секторын зүгээс гадаад өр төлбөр барагдуулсан (2020 оны 5 дугаар сард 500 сая ам.доллар) нь санхүүгийн дансанд сөргөөр нөлөөлсөн хэдий ч АХБ, ОУВС, Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага болон Япон улсаас Монгол Улсад үзүүлсэн төсвийн дэмжлэгтэй холбоотойгоор санхүүгийн данс тодорхой хэмжээний ашигтай гарлаа.[19] Нөгөө талаас, дотоод эрэлт суларч, экспорт эрчимтэй сэргэсэн нь урсгал дансанд томоохон тохиргоо хийгдэхэд дэм боллоо.

Зураг I.22. Урсгал дансны тохиргоо нь гадаад дарамтыг сулруулахуйц байв ...

Эх сурвалж: Монголбанк.

Зураг I.23. Урсгал данс сүүлийн саруудад ашигтай гарсан нь ойрын жилүүдэд ажиглагдаагүй явдал болов



Эх сурвалж: Монголбанк.

[19] Засгийн газраас 2020 оны 9 сарын сүүлээр гаргасан 600 сая ам.долларын бондыг өр төлбөр барагдуулахад зарцуулсан тул Монгол Улсын гадаад позицод мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй ч гадаад валютын дотоод зах, ханшийн хүлээлтэд шууд нөлөөлөв.

Худалдааны тэнцэл сайжирч урсгал дансыг дорвитой дэмжив. Урсгал дансны алдагдал 2019 онд 2.1 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 433 сая ам.доллар болж буурчээ. Урсгал дансны ашиг 2020 оны 5-12 сард 530 сая ам.доллар болсон нь сүүлийн 10 жилд тохиолдож байгаагүй үйл явдал болов (зураг I.23). Нэг талаас дотоод эрэлт сул байж, нефтийн үнэ хямдарснаар импортын агшсан бол нөгөө талаас экспортын хурдацтай сэргэлт нь урсгал дансны тохиргоог тодорхойлов (зураг I.24, зураг I.25).[20, 21, 22] Урсгал дансны тэнцэл сайжрахад ашгийн гуйвуулга багассан, үйлчилгээний төлбөр буурсан нь (аялал жуулчлал болон ачааны машинуудын үйл ажиллагааг хязгаарласан явдал) мөн чухал үүрэг гүйцэтгэв. Төв банк 2020 онд түүхэнд байгаагүй 23 тонн алт худалдаж авсан нь экспортыг сэргээхэд томоохон дэм болов (зураг I.24).[23]

Урсгал дансанд тохиргоо хийгдэж, Монголбанкны худалдан авах алтны хэмжээ огцом нэмэгдсэнээр эхний 5 сард мэдэгдэхүйц буураад байсан гадаад валютын нөөц дахин сэргэв. Экспорт огцом унаж, хөрөнгийн дотогшлох урсгал саарч (гол төлөв гадаадын шууд хөрөнгө оруулалт), хувийн секторын зүгээс гадаад өр төлбөрөө барагдуулсан тул Монгол Улсын гадаад валютын нөөцөд сөргөөр нөлөөлөв (зураг I.26). Гэвч урсгал тэнцэлд хийгдсэн тохиргоо, зарим донорын тусламж, Монголбанк алт худалдан авалтаа эрс нэмэгдүүлсэн зэргээс шалтгаалан оны хоёр дугаар хагаст гадаад валютын албан нөөцийг сэлбэх боломж олгов. Гадаад валютын улсын нийт албан нөөц 2019 онд 4.3 тэрбум ам.доллар байсан бол 2020 оны эцэст 4.5 тэрбум ам.долларт (импортын 8 сар) хүрч түүхэн дээд амжилт тогтоолоо.

Зураг I.24. Эхний хагас жилд уналтад орсон экспорт хурдацтай сэргэв ...

Экспортын жилийн өсөлтөд оруулах хувь нэмэр, нэгж хувь



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Нүүрс, зэс, алт нь 2020 оны нийт экспортын 75 хувийг бүрдүүлэв.

Зураг I.25. Нефть болон үндсэн хөрөнгийн импорт буурсан нь импортын агшилтыг тодорхойлов

Импортын жилийн өсөлтөд оруулах хувь нэмэр, нэгж хувь



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[20] Орос, Хятадтай хиллэдэг боомтууд дээр хилийн шалган нэвтрүүлэх явц удааширч импортод мөн хүчтэй нөлөөлөв. Цар тахлын дотоод халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш хил дамнасан тээвэрлэлтийг зогсоож, хилийн нөгөө талд бараа таваар саатах, машин техникийн цуваа үүсэх нь нэмэгджээ. Гаалийн бүрдүүлэлтгүйгээр эдгээр барааг төлбөрийг нь шилжүүлсэн ч импорт гэж бүртгэхгүй. Энэ нөхцөл байдал нэг хэсэгтээ хадгалагдах тул импортыг 2021 оны 1 дүгээр сарын сүүл буюу 2 дугаар сард бүртгэж магадгүй юм.

[21] Хятадтай хиллэдэг боомтуудаар нүүрсийг түргэн шуурхай тээвэрлэх Засгийн газрын хүчин чармайлт экспортыг мөн дэмжив.

[22] Экспорт 2020 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 45.3 хувиар агшсан ч цаашид сэргэж 2020 онд жилийн 0.6 хувийн бууралт үзүүлсэн байна. Энэ нь Хятадын эрэлт, түүхий эдийн үнэ (гол төлөв зэсийн үнэ) сэргэсэн, алтны экспорт огцом нэмэгдсэнтэй холбоотой байв.

[23] Алт олборлолтыг дэмжих үүднээс Монголбанк 110 тэрбум төгрөгийн (42 сая ам.доллар) хөнгөлөлттэй зээлийг "Алт-2" хөтөлбөрийн хүрээнд алт олборлогчдод олгов.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш валютын захын интервенцийн тусламжтайгаар 2020 онд алгуур сулрав. Нэрлэсэн дүнгээр төгрөг ам.долларын эсрэг 4.2 хувиар, хятадын юаний эсрэг 11.2 хувиар суларчээ (зураг I.27). Мөн хугацаанд Казахстаны тенге, Оросын рублийн ханш төгрөгөөс илүү сулрав (зураг I.28). Монголбанкны валютын зах дахь интервенц төгрөгийн ханш ийнхүү алгуур сулрахад дэмжлэг болов. Монголбанк 2020 онд 2.63 тэрбум ам.долларын интервенц (томоохон уул уурхайн компаниудаас худалдаж авсан гадаад валютыг хасаад) хийсэн нь гадаад дарамт нэмэгдэж байсан 2019 оны 2.87 тэрбум ам.доллартай дүйцэхүйц байна (зураг I.29). Инфляц нам түвшинд хадгалагдсан тул төгрөгийн бодит ханш 2020 оны 11 дүгээр сар гэхэд жилийн 3 хувиар суларчээ.

Зураг I.26. Урсгал дансанд тохиргоо хийгдэж, алт худалдан авалт нэмэгдсэнээр I хагаст огцом бууруулсан валютын нөөц сэргэв ...

Эх сурвалж: Монголбанк.

Зураг I.27. ... улмаар эхний хагас жилд алгуур суларч байсан ханш хоёр дугаар хагаст тогтворжив.

Эх сурвалж: Монголбанк.

Зураг I.28. Адил төстэй улс орнуудтай харьцуулахад төгрөгийн ханш алгуур сулрав ...



Эх сурвалж: https://www.x-rates.com/, Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.29. ... үүнд Монголбанкны интервенц, ялангуяа 2020 оны эхний хагас дахь оролцоо томоохон дэм үзүүлэв



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Монголбанкны худалдсан валютын нийт дүнд уул уурхайн томоохон компаниудаас худалдаж авсан (2018 оны 6 дугаар сараас эхэлсэн) гадаад валют ороогүй болно.

ЗГТ = Зүүн гар тал; БГТ = баруун гар тал.

А6. Мөнгөний бодлогын төлөв суларсан ч активын чанар муудахын хэрээр банкны секторт эрсдэлүүд хуримтлагдсаар байна

КОВИД-19 цар тахлаас өмнө мөнгөний бодлого нь макро зохистой бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан зээлийн тогтворгүй өсөлтийг шийдвэрлэхэд чиглэгдэж байв. 2018-2019 оны инфляц Монголбанкны зорилтот 8 хувь дотор байсан тул Монголбанк мөнгөний болон макро зохистой бодлогоор дамжуулан зээлийн тогтворгүй өсөлт (ялангуяа хэрэглээний зээл) болон гадаад тэнцвэргүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд анхаарч байв.[24] 2017-2018 оны зээлийн хурдацтай тэлэлт нь голчлон иргэдийн зээл байсан тул 2012 онд 39 хувьтай байсан өрхийн өр, орлогын харьцаа 2018 оны эцэст 70 орчим хувьд хүрсэн тооцоотой байна. Макро зохистой бодлогын арга хэмжээний үр дүнд нийт мөнгө болон дотоод зээлийн өсөлт 2018 онд харгалзан 23 хувь болон 26.5 хувь байснаа 2019 оны эцэст харгалзан 7 хувь болон 5.1 хувь болон буурчээ (зураг I.30).

Харин 2020 оны мөнгөний бодлого цар тахлын нөлөөг зөөлрүүлэхэд чиглэгдэв. 2020 оны 3 дугаар сараас эхлэн Монголбанк бодлогын хүүгээ нийлбэр дүнгээр 5 нэгж хувиар бууруулж түүхэн доод үзүүлэлт болох 6 хувьд хүргэв (зураг I.30). Ингэснээр зах зээлийн хүүг бууруулж дотоод эрэлтийг дунд хугацаанд тэтгэхээр зорьж байв. Банкуудад илүүдэл нөөцөө зээл болгон гаргаж эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих сэдэл өгөх үүднээс Монголбанк төв банкны богино хугацаат үнэт цааснаас хүртэх өгөөжийг харьцангуй бууруулжээ. Үүгээр зогсохгүй Монголбанкны зүгээс заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсны сацуу урт хугацаатай санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэв. Монголбанк Засгийн газрын ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр дэх оролцоогоо сэргээж, ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, актив худалдан авах хэд хэдэн хөтөлбөрт оролцох, уул уурхайн бус салбар, ЖДҮ-ийг дэмжихэд нь зориулж банкуудад хөнгөлөлттэй санхүүжилт олгох зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. Эдгээр арга хэмжээний өртөг нь ДНБ-ий 3 хувь орчимд хүрэх тооцоотой байгаа бол зохицуулалтын бусад арга хэмжээний бодит өртгийг тооцоолох боломжгүй байна (шигтгээ I.4-ийг үзнэ үү).

Зураг I.30. Зээлийн өсөлтийг сэргээх үүднээс бодлогын хүүг түүхэн доод түвшинд хүргэв



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: БГТ = баруун гар тал; ЗГТ = зүүн гар тал.

Зураг I.31. Банкуудад илүүдэл нөөц хангалттай байгаа ч зээл гаргахаас болгоомжилж байна



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: БГТ = баруун гар тал; ЗГТ = зүүн гар тал.

[24] Макро зохистой бодлогын арга хэмжээнд өрхийн ипотекийн бус зээлийн хугацааг хязгаарлах, иргэдийн өр, орлогын харьцааг 100 хувиас 60 хувь болгон бууруулах, гадаад валютаар авах зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлэх зэрэг багтана.

Шигтгээ I.4.
Монголбанкнаас КОВИД-19 цар тахлын нөлөөг зөөлрүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

КОВИД-19 цар тахал 2020 оны 2 дугаар сард дэгдсэнээс хойш Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) зургаан удаа хуралджээ. МБХ-ноос зээлийн өсөлтийг дэмжих, өрийн дарамтыг бууруулах, банк хоорондын захын нөөцийг дэмжих үүднээс хэд хэдэн шийдвэр гаргав. Үүнд:

- **2020 оны 3, 4, 9, 11 дүгээр сарын хурлаас бодлогын хүүг 11 хувиас 6 хувь хүртэл тууштай бууруулав.** Инфляц зорилтот түвшинд байсан тул бодлогын хүүний бууралт нь банкуудын санхүүжилтийн зардлыг бууруулах, санхүүгийн зуучлалыг дэмжих, дотоод эрэлтийг идэвхжүүлэхэд чиглэгдэж байв.
- **Банкуудын нөөц хөрөнгийг дэмжих үүднээс репо санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэв.** МБХ нь хүүний коридорын өргөнийг 2 нэгж хувиар нарийсгаснаар богино хугацаат репогийн хүү буурав. 9 дүгээр сард урт хугацаат репо хэлцлийн хугацаа 90 хоног байсныг 180 хоног болгож, хүүг нь 16 хувиас 11 хувь болгон бууруулав. Ийнхүү банкуудад төв банкнаас санхүүжилтийг доогуур хүүгээр, илүү урт хугацаагаар авах боломжийг бүрдүүлэв.
- **Банкны системийн нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх** үүднээс 2020 оны 3 дугаар сард төгрөгийн эх үүсвэрийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 4.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэв. Үр дүнд нь 730 тэрбум төгрөг суларч зах зээлд нийлүүлэгдэв.
- **Валютын хадгаламжийн хүүг бууруулах, банкны эх үүсвэрийн долларжилтыг багасгах** зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэр гаргав. Гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй зэрэгцээд тус арга хэмжээ нь өсөн нэмэгдэж буй валютын нийцгүй байдлын эрсдэлийг бууруулж санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах зорилготой юм.
- **Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж,** хугацааг нь 12 хүртэлх сараар сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болов. Эдгээр арга хэмжээ нь зээлийн сарын төлбөрийн хэмжээг бууруулах, хувийн хэрэглээг дэмжих зорилготой билээ.а
- **Актив худалдан авах, хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авав.** Цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн хөтөлбөрийг дэмжих үүднээс 100 тэрбум төгрөгийн нийслэлийн бонд худалдан авав; банкуудад жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд нь зориулж 230 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийн зээл олгов; "Алт-2" хөтөлбөрийн хүрээнд алт олборлогч компаниудад 110 тэрбум төгрөгийн зээлийг шууд олгов.

Монголбанк хяналт шалгалтын чиг үүргийнхээ хүрээнд зохицуулалтын бодлого журамдаа 2020 оны эцэс хүртэл үйлчлэх өөрчлөлтүүдийг оруулав. Тэдгээрээс заримыг нь дурдвал:

- **2020 оны 3 дугаар сараас эхлэн Активын ангиллын журамд өөрчлөлт оруулж** зээлдэгчид зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээхээр болов. 90 хүртэл хоногоор хугацаа хэтэрсэн хэрэглээний болон ипотекийн зээлийг хэвийн (өмнө нь 15 хоног), 91-120 хүртэл хоногоор хэтэрсэн бол хугацаа хэтэрсэн (өмнө нь 90 хоног), 121 дээш хоног төлөгдөөгүй зээлийг чанаргүй хэмээн ангилахаар болов.
- **Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 25 хувь байсныг 20 хувь** болгон бууруулж банкуудын хөрвөх чадвар өндөртэй активын хэмжээг бууруулж зээл олгох орон зайг бий болгов.
- **Банкууд гүйлгээний шимтгэлээ бууруулахыг дэмжих, долларын хадгаламжийг** даатгалаас гаргаж хадгаламжийн долларжилтыг бууруулах арга хэмжээ авав.

УИХ-ын 4 дүгээр сарын 29-ний Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай тогтоолын хүрээнд Монголбанкнаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- **Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлж 6 сараар (дараа нь дахиад 8 сараар) хойшлуулахыг зөвшөөрөв.** Ипотекийн хөнгөлөлттэй зээл авсан зээлдэгчдэд 5 дугаар сарын 1-нээс зээлийн нөхцөлдөө хүү тооцохгүйгээр өөрчлөлт оруулах нэг удаагийн боломж олгов. 6 дугаар сарын 19-ний байдлаар нийт 38270 зээлдэгч зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулж 121 тэрбум төгрөгийн төлбөрийг хойшлуулав. 11 дүгээр сард эргэн төлөлтийг дахин 8 сараар хойшлуулснаар 310 тэрбум төгрөгийн төлбөр хойшлогдохоор хүлээгдэж байна.
- **Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрийг үргэлжлүүлэн олгохоор болов.** ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр болон Дэлхийн Банкны эдийн засгийн удирдлагыг дэмжих цуврал арга хэмжээний хүрээнд Монголбанк ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн санхүүжилтийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс зогсоохоор тохиролцсон билээ. Гэсэн хэдий ч 2020 оны 4 дүгээр сард баталсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тухай хуулиар Төв банк орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх үүрэг хүлээж одоогоор 245 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлээд байна.

Эх сурвалж: Монголбанк.

Жич: Зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах боломжийг Монголбанкнаас хязгаарладаггүй. Гэхдээ 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнөх үед хамаарах зээлүүдийн хувьд өр, орлогын харьцаа 60 хувиас давахгүй байх, хугацаа нь 30 сараас ихгүй байх журам хараахан мөрдөгдөөгүй байв. Эдгээр зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулах нь дээрх хязгаарлалтын аль нэгийг зөрчихөд хүргэж байв. Иймд Монголбанк өрхийн зээлийн дарамтыг бууруулах үүднээс хугацааны 30 сарын хязгаарлалтыг нэг удаа түдгэлзүүлэх боломж олгов.

Мөнгөний зөөлөн бодлогын үр нөлөөг зээлийн тасалдал бүдгэрүүлэв. Нийт мөнгөний өсөлт 2020 оны 4 дүгээр сард жилийн 1.6 хувиас 12 дугаар сард жилийн 16 хувь болтлоо хурдасжээ. Дээрх хугацаанд дотоод зээлийн өсөлтийн сөрөг тэмдэгтэй хэвээр байсан бол нөгөө талаас банкуудын илүүдэл нөөц алгуур нэмэгдсээр байна (зураг I.31). Эдийн засаг агшиж, чанаргүй зээл нэмэгдэн, зах зээлд тодорхой бус байдал хуримтлагдаж байгаа тул банкууд зээл олгох, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийх сонирхол бага байна. Ийм ч учраас мөнгөний бодлогыг ихээр зөөлрүүлсэн ч зээлийн өсөлтөд ихээр нөлөөлж чадахгүй байна. Харин хямралын дараа шинэ зээл олголтыг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг тэтгэхийн тулд банкуудын балансыг сайтар цэгцлэх шаардлагатай юм.

КОВИД-19 цар тахал хэрэглэгчдэд болон жижиг, дунд үйлдвэрлэгчдэд хүнд цохилт учруулснаас болж зээлийн тасалдал улам хурцдав. Монгол Улсад зээлийн өсөлт 2020 оны эцсийн байдлаар -5 хувь болж 10 сар дараалан агшжээ. Нэг талаас, зээлийн чанар хурдацтай муудаж байгаа тул банкууд иргэд болон аж ахуйн нэгжүүдэд шинээр зээл гаргахаас зайлсхийж байгаа бол нөгөө талаас иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлого, ашигт ажиллагаа муудаж, зээл авах боломж нь тэр хэрээр хязгаарлагдаж байна. ҮСХ-ноос явуулсан асуулгын дүнгээс харахад аж ахуйн нэгжүүдийн 64.2 хувь нь цар тахлаас болж орлогын 50 гаруй хувиа алдсаныг мэдээлэв. Цар тахлаас шалтгаалан аж ахуйн нэгжид олгосон зээл буурч байгаа бөгөөд барилга, худалдаа, тээвэр, боловсруулах, уул уурхайн салбаруудад зээл олголт муу байна (зураг I.32). Банкууд зээл олгох нөхцөлөө чангатгасны зэрэгцээ өрхүүдийн орлогод цар тахал нөлөөлж, удаан эдэлгээт бараа, автомашин худалдан авах сонирхол нь буурсан тул иргэдэд шинээр олгож буй зээл мөн хумигдсан байна (зураг I.33).

Зураг I.32. Аж ахуйн нэгжид шинээр олгосон зээл бүх секторын хувьд буурав



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.33. Банкуудаас өрхийн болон ЖДҮ-д шинээр олгох зээлийн нөхцөлөө мөн чангатгав



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Банкны активын чанар цар тахлын нөлөөгөөр мэдэгдэхүйц муудав. Банкуудын чанаргүй зээл 12 дугаар сар гэхэд 2 их наяд төгрөгт хүрч 2019 оны эцэстэй харьцуулахад 10 хувиар нэмэгджээ. Чанаргүй зээл, зээлийн өрийн нийт үлдэгдлийн харьцаа 2019 оны 12 дугаар сард 10.1 хувь байсан бол 2020 оны эцэст 11.7 хувь болтлоо өсөв (зураг I.34). Хугацаа хэтэрсэн зээл бүр ч илүү хурдацтай өсөв. Хугацаа хэтэрсэн зээл 2019 оны 12 дугаар сарын 816 тэрбум төгрөгөөс 1.3 их наяд төгрөг хүртэл өсөв. Хугацаа хэтэрсэн зээл, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа 2019 оны 12 дугаар сард 4.5 хувь байсан бол 2020 оны эцэст 7.4 хувь болов. Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг түр хугацаанд бууруулахгүй байх шийдвэр 2021 оны 7 дугаар сард дуусгавар болоход асуудалтай зээл (чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл)-ийн хэмжээ нэмэгдэж магадгүй байна. Монголбанкны мэдээлж байгаагаар 2020 оны 2 дугаар сарын байдлаар банкны секторын зээлийн 20 орчим хувь нь цар тахлын нөлөөнд өртсөн бол үүний заримынх нь нөхцөлийг хүүний болон/эсвэл үндсэн төлбөрийг царцаах замаар өөрчилжээ. Цар тахлын нөлөөнд өртсөн зээлийг сектороор ангилж үзвэл уул уурхай (46 хувь), барилга (38 хувь), худалдаа (35 хувь), үл хөдлөх хөрөнгө (26 хувь)-ийн секторуудын зээлүүд хамгийн их өртсөн байхаар байна (зураг I.35).

Зураг I.34. Зээлийн чанар мэдэгдэхүйц муудав



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.35. ... ялангуяа уул уурхай, барилга, худалдааны салбарын зээлийн чанар муудав

Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Аж ахуйн нэгж, иргэдийн зээлийн аль алиных нь хувьд байгуулсан зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээт байдал нь тодорхой бус байна.[25] 2020 оны эцсийн байдлаар аж ахуйн нэгжийн хувьд байгуулсан зээлээс хүлээж болзошгүй алдагдлын сан 1.2 тэрбум төгрөг байна. Энэ дүн чанаргүй зээлийн 80 гаруй хувийг, харин хүндрэлтэй зээлийн (чанаргүй зээл+хугацаа хэтэрсэн зээл) 50 хувийг хаахаар байна (зураг I.36). Зээлийн эрсдэлийн сан уул уурхай, барилга, аж үйлдвэр, худалдааны секторын асуудалтай зээлүүдийн 33-77 хувийг тус тус хаахаар байгаа бол нийт хүндрэлтэй зээлийн 70 хувийг эдгээр салбаруудын асуудалтай зээлүүд бүрдүүлж байна. Иргэдэд олгосон хүндрэлтэй зээлийн 51 хувийг эрсдэлийн сангаар хааж болохоор байна (зураг I.37). Эрсдэлийн сангийн хүрэлцээ автомашины зээлийн хувьд хамгийн сул байгаа аж.

Банк хоорондын захад нөөцийн хомсдол үүсээгүй байна. Монголбанкны мэдээлж байгаагаар хөрвөх чадварын харьцаа (хөрвөх хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа) 2020 оны 6 дугаар сараас эхлэн сайжирч оны эцэст 40.6 хувьд буюу сүүлийн хоёр жилийн хамгийн дээд түвшинд хүрчээ (зураг I.38). Банкуудын нөөц нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15.9 хувьтай тэнцэж байгаа нь заавал байлгах нөөцийн хувь хэмжээнээс илүү байна (гадаад валютын хувьд 15 хувь, төгрөгийн хадгаламжийн хувьд 6.5 хувь). Гэсэн хэдий ч энэ бол 2020 оны 4 дүгээр сарын 25.6 хувьтай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Гадаад валютын хадгаламж (хуваарь) 5 дугаар сараас хойш эрс өссөн нь дээрх харьцааны бууралтыг тайлбарлана.[26]

Зураг I.36. Эрсдэлтэй секторуудын хувьд зээлийн эрсдэлийн сан хангалтгүй байна ...

Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Хүндрэлтэй зээл = Хугацаа хэтэрсэн зээл + Чанаргүй зээл.

Зураг I.37. Цар тахлын үр нөлөө ил болохын хэрээр банкууд томоохон хүндрэлтэй тулгарахаар байна...

Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Хүндрэлтэй зээл = Хугацаа хэтэрсэн зээл + Чанаргүй зээл.

[25] Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа нь чанаргүй зээлээс үүсэж болзошгүй алдагдлын эсрэг банкууд хэрхэн хамгаалагдсаныг тодорхойлно.

[26] Гадаад валютын хадгаламж 2020 оны 3 дугаар сараас тогтмол нэмэгдэж байсан бол 10 дугаар сараас энэ байдал өөрчлөгдлөө. Ингэснээр 2020 оны 9 дүгээр сард 31 хувьд хүрээд байсан хадгаламжийн долларжилт оны эцэст 25.7 хувь болж буурав. Энэ нь 2020 оны 3-4 дүгээр сарын харьцаатай ойролцоо дүн юм.

Банкны системд валютын нийцгүй байдал өндөр байна. Банкуудын гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрийн дүн нь гадаад валютаарх активаас 3 дахин их байгаа нь банкуудын валютын нийцгүй байдлын эрсдэл өндөр байгааг харуулна. 2020 оны 9 дүгээр сарын байдлаар банкуудын татан төвлөрүүлсэн хадгаламжийн 31 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байсан нь сүүлийн 2 жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Харин, банкуудын нийт зээлийн 9 хувийг гадаад валютаар олгосон зээл эзэлж байна (зураг I.39). Банкууд сүүлийн жилүүдэд валютаар зээл олгох нөхцөлөө чангалсан тул ханшийн хэлбэлзэлтэй холбоотой зээлийн эрсдэл харьцангуй бага байхаар байна. Нөгөө талаас гадаад орчны дарамт нэмэгдсэнтэй холбоотойгоор өрх болон аж ахуйн нэгжүүд (ялангуяа оны эхний хагаст) валютын хадгаламжаа нэмэгдүүлжээ. Гэсэн хэдий ч урсгал данс сайжирсан, Монголбанкнаас гадаад валютын хадгаламжид тавих заавал байлгах нөөцийн шаардлагыг нэмэгдүүлсэн, банк дампуурсан нөхцөлд валютын хадгаламжид нөхөн олговор олгохгүй байхаар шийдвэрлэсэн зэргээс шалтгаалан хадгаламжийн долларжилт сүүлийн саруудад буурч байна (шигтгээ I.4). Гадаад орчны тааламжгүй, тодорхойгүй нөхцөлд хадгаламжийн болон зээлийн долларжилтын зөрүү их байх нь банкны системийн тайлан тэнцлийг ханшийн огцом савлагаанд өртөмтгий болгодог.

Зураг I.38. Банк хоорондын захын нөөц тогтвортой байгаа ч...



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг I.39. ... валютын нийцгүй байдлын эрсдэл өндөр байхаар байна



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Аж ахуйн нэгж, иргэдийн валютын хадгаламж нь банкуудын хувьд өр төлбөр, харин валютаар олгосон зээл нь банкуудын хувьд актив хөрөнгө болно. БГТ = баруун гар тал, ЗГТ = зүүн гар тал;

5

ХЭТИЙН ТӨЛӨВ БА ЭРСДЭЛҮҮД

Б. Хэтийн төлөв ба эрсдэлүүд

КОВИД-19 дотоод халдвартай холбоотойгоор тодорхойгүй байдал мэдэгдэхүйц нэмэгдсэн тул Монголын эдийн засаг цаашдаа алгуур сэргэх хүлээлттэй байна. Монгол Улсын бодит ДНБ 2020 онд 5.2 хувиар агшихаар байгаа нь сүүлийн 10 жилд тохиож буй анхны уналт юм (хүснэгт I.2).[27] Монгол Улс Зүүн Ази, Номхон далайн бүс нутагтаа ДНБ нь хамгийн их хохирол амссан Филиппин, Тайланд, Малайзын ард байна (шигтгээ I.6). Гадаад эрэлт сул байгаагийн зэрэгцээ цар тахлын эсрэг арга хэмжээ нь уул уурхай болон үйлчилгээний салбарт хамгийн хүнд цохилт өгөв. Харин 2021-2022 онд эдийн засаг 5 хувиар өсөх тооцооллыг боловсруулаа. Үүнд, Оюу толгойн гүний уурхайн ашиглалт хойшлогдсон ч уул уурхайн секторын хөрөнгө оруулалт эргэн сэргэх (зэсийн илүү өндөр агууламж, алтны үйлдвэрлэлийн өсөлттэй хавсран) нь голлон нөлөөлөхөөр байна.[28] Түүнчлэн уул уурхай, аж үйлдвэр, тээврийн салбар дахь хувийн хөрөнгө оруулалтыг гадаадын шууд хөрөнгө оруулалт, дотоодын зээл (аж ахуйн нэгжүүдэд олгох) тэтгэснээр 2021-2022 оны эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Дунд хугацааны эдийн засгийн өсөлтөд хувийн хэрэглээ ч мөн хувь нэмрээ оруулна.

[27] Бидний тооцоолсноор Монгол Улсын бодит ДНБ 2020 онд ийнхүү агшихаар байгаа бол 2021 оны төсвийн баримт бичгийг боловсруулахдаа 2020 онд эдийн засаг 1 хувиар агших, 2021 онд 7.2 хувиар сэргэх өөдрөг төсөөллийг боловсруулж тусгасан байна (шигтгээ I.3-ыг үзнэ үү).

[28] Оюу толгойн алт олборлолтыг нэмэгдүүлэх хэд хэдэн санаачилга нь 2020 болон 2021 онд баруун-өмнөд цооногоос өндөр агууламжтай алтны хүдэр олборлох боломжийг бий болгож байна. Ингэснээр зэсийн үйлдвэрлэлийг 2022-2028 онд 315 хувиар, алтны үйлдвэрлэлийг мөн хугацаанд 140 хувиар тус тус өсгөхөөр төлөвлөжээ.

Инфляц өсөж, гадаад секторын дарамт нэмэгдэхийн хэрээр мөнгөний бодлогын төлөв дунд хугацаанд чангарах магадлалтай. Инфляцын түвшин 2020 онд саарахад дотоод эрэлт сул байж, импорт агшсан, зээл буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн билээ. Харин эдийн засгийн үйл ажиллагаа сэргэхийн хэрээр инфляц 2021-2022 онд алгуур өсөж Төв банкны зорилтот түвшнээс давах эрсдэлийг бий болгоно.[29] Тухайлбал өмнөх 2 жилтэй харьцуулахад төсвийн зарлага 2020 онд өндөр байсны зэрэгцээ дотоод зээл аажмаар сэргэх үед 2021 онд инфляцын дарамтыг нэмэгдүүлэх юм.[30] Бид суурь таамаглалаа боловсруулахдаа мөнгөний бодлогын эрх баригчид инфляцын тогтвортой байдлыг хадгалах зорилтоосоо хазайхгүй, инфляцыг төв банкны зорилтот түвшинд барих замаар хүлээлтийг бууруулна гэж авч үзлээ. Түүнчлэн, төв банкны валютын захын оролцоо нь ханшийн огцом савлагааг зөөлрүүлэх хэмжээнд л хязгаарлагдах хүлээлттэй байна. Энэ нь ханш зах зээлийн зарчмаар уян хатан тогтох, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх боломжийг олгоно. Гадаад орчны тогтворгүй байдал үргэлжилж, хүүний түвшин түүхэн доод хэмжээнд (6 хувь) байгааг харгалзан үзвэл бодлогын хүү цаашдаа буурах орон зай бага байна. Түүнчлэн, заавал байлгах нөөцийн хувь хэмжээ 6.5 хувь байгаа нь 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш хамгийн доогуур үзүүлэлт тул түүнийг улам бууруулан санхүүгийн системийн нөөцийг дэмжих боломж хомс юм. Урт хугацаатай репо санхүүжилт (2020 оны 4 дүгээр улиралд банкуудад 230 тэрбум төгрөгийг олгосон бол 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөг хүртэл авах боломжтой) зэрэг сүүлийн үед нэвтрүүлсэн мөнгөний бодлогын хэрэгслүүд нь гадаадын шууд хөрөнгө оруулалт сул байгаа орчинд гадаад валютын дотоод захад дарамт үүсгэж магадгүй юм.[31, 32]

Банкны зээлийн зохицуулалтыг цаашид зөөлрүүлэх, сулруулах нь дунд хугацаанд эдийн засгийн өсөлт, тогтвортой байдалд таамаглаж байгаагүй үр нөлөө үзүүлж болзошгүй. Дээр дурдсанчлан сүүлийн хэдэн сард аж ахуйн нэгжүүдийн орлого, ашигт ажиллагаа муудахын хэрээр банкуудын активын чанар муудаж байгаа нь ажиглагдлаа. Үүний зэрэгцээ, активын чанартай холбоотой зохицуулалтыг түр зуур зөөлрүүлснээр аль хэдийн чанарын асуудалд орсон зээлүүд халхлагдаж байж болзошгүй юм. 2020 оны 2 дугаар сарын байдлаар банкны зээлийн багцын 20 хувь нь цар тахлын нөлөөнд өртсөн байхаар байна. Хүндрэлтэй зээлтэй, ашигт ажиллагаа багатай, өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалтгүй болж болзошгүй зарим банкуудыг харгалзан үзэж, банкны салбарын реформ шинэчлэлийг эрчимжүүлэх нь эдийн засгийн дунд хугацааны өсөлтөд чухал ач холбогдолтой байна.

2021 оны төсөв, 2021-2013 оны дунд хугацааны төсвийн төсөөлөл нь төсвийн алдагдлыг бууруулах, засгийн газрын өрийг бууруулах зорилттой нийцтэй байна. Төсвийн дунд хугацааны мэдэгдэлд 2021-2023 оны төсвийн нийт алдагдлыг ДНБ-ий 1.5 хувийн түвшинд байхаар төлөвлөжээ. Харин орлогын төсөөллийг өндөр бусаар авч үзвэл бидний тооцооллоор төсвийн алдагдал 2021-2023 онд ДНБ-ий 1.9 хувьд хүрэхээр байна. Тийм ч учраас олон талт болон хоёр талт донорын санхүүгийн дэмжлэг туслалцаа нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд чухал ач холбогдолтой байх төлөвтэй. Хүүний төлбөрт ДНБ-ий 2019 онд 2.3 хувийг, 2020 онд 2.6 хувийг төлж байсан бол хөнгөлөлттэй санхүүжилт авснаар 2021-2023 онд 2 хувийг төлөхөөр байна.[33]

---

[29] Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийг батлуулснаар Монголбанкны 2021-2023 оны инфляцын зорилт нь 6 хувь дээр нэмэх, хасах 2 нэгж хувь болов.

[30] ОУВС (2012), "Inflation Dynamics in Mongolia: Understanding the Roller Coaster" /Монголын инфляцын динамик: Галзуу хулганыг ойлгохуй/.

[31] Ковид-19 дотоод халдвараас үүдэн Монгол-Хятадын хил дээр эргээд асуудал үүссэн нь гадаад секторын дарамтыг нэмэгдүүлэх бас нэг хүчин зүйл болж байна. Монголд 2020 оны 11-р сарын дундуур дотоод халдвар илэрч хөл хорио тогтоосны дараахан Хятадад кокс нүүрсний үнэ сүүлийн 4 жил байгаагүй өндөр түвшинд хүрэв. Цар тахал нь хилийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөв. Хятадын эцсийн хэрэглэгчдийн кокс нүүрсний эрэлт тогтвортой байгааг анзаарсан трейдерүүд Монголын нүүрсний үнийг үргэлжлүүлэн өсгөж байв.

[32] МБХ-ны 12-р сарын 18-ны хурлаас 2021 оны 1-р улиралд жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд 250 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудаар дамжуулан олгохоор шийдвэрлэв.

[33] Засгийн газрын өрийн менежментийн стратегийн нэг онцлог шинж чанар нь дотоодын өндөр хүүтэй өрийг хөнгөлөлттэй зээл, хөнгөлөлттэй нөхцөлөөр дахин санхүүжүүлсэн гадаад өрөөр орлуулах явдал юм. Энэ стратегийн ачаар хүүний төлбөрийг 2017-2018 онд дорвитой бууруулж чадсан.

Цар тахлаас үүдэн 2020 онд өр нэмэгдсэн бол, ДНБ-д эзлэх харьцаа ойрын жилүүдэд эргээд буурахаар хүлээгдэж байна. Эдийн засгийн мөчлөгийн сэргэлт нь өр-ДНБ-ий харьцаа буурахад эергээр нөлөөлөх төлөвтэй. Цар тахал дэгдэхээс өмнө буюу 2017-2019 онд хэрэгжүүлсэн төсвийн зохистой бодлого нь засгийн газрын өрийг эрс бууруулж, төсвийн хариу үйлдэл үзүүлэх тодорхой хэмжээний орон зай бий болгосон билээ. Харин 2020 онд зардлын өсөлт, орлогын тасалдал зэрэг нь төсвийн алдагдал, засгийн газрын өрийг нэмэгдүүлсэн байхаар байна. Засгийн газар цар тахлын сөрөг үр нөлөөг сааруулах зорилгоор гурван үе шаттай тусламж, дэмжлэгийн арга хэмжээ авсан нь ДНБ-ий 9 хувьтай дүйцэхүйц зардалтай байна. Үүнийг засгийн газрын харилцах болон гадаад хөнгөлөлттэй зээл, тусламжаар санхүүжүүлжээ. Нэг талаас орлого их хэмжээгээр тасалдаж, нөгөө талдаа төсвөөс үлэмж хэмжээний тусламж дэмжлэг үзүүлснээр засгийн газрын өр 2020 онд нэмэгдэхээр, харин 2021 оноос эхлэн алгуур буурахаар хүлээгдэж байна. Гэхдээ бусад адил төстэй улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын өрийн харьцаа өндөр хэвээр байна (зураг I.40).

Зураг I.40. Нэлээдгүй улс орны засгийн газрын өр, ДНБ-ий харьцаа 2020 онд өссөн байна



Эх сурвалж: ОУВС 2020; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Хүснэгт I.2. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2016	2017	2018	2019	2020 урьд	2021 тес	2022 тес
	Өөрөөр дурдаагүй бол хувиар илэрхийлсэн жилийн өөрчлөлт						
Бодит ДНБ-ий өсөлт, зах зээлийн тогтмол үнээр	**1.4**	**5.4**	**7.0**	**5.0**	**-5.2**	**4.3**	**5.4**
Хувийн хэрэглээ	-2.2	5.4	12.4	9.9	2.0	3.6	4.5
Засгийн газрын хэрэглээ	10.6	-1.8	-0.8	11.5	17.5	-5.1	1.6
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	0.5	35.6	21.3	23.5	-16.3	9.0	10.0
Бараа үйлчилгээний экспорт	13.8	14.8	24.0	9.1	-5.0	13.4	7.4
Бараа үйлчилгээний импорт	12.7	24.8	30.9	22.3	-9.0	14.1	8.4
Бодит ДНБ-ий өсөлт, хүчин зүйлийн тогтмол үнээр	**1.2**	**5.3**	**7.2**	**5.2**	**-5.2**	**4.3**	**5.4**
Хөдөө аж ахуй	6.2	1.8	4.5	8.4	10.8	5.0	6.0
Аж үйлдвэр (уур уурхай ороод)	-0.4	0.7	7.9	3.1	-11.0	6.3	5.4
Үйлчилгээ	1.1	7.7	4.7	5.8	-5.7	2.5	5.2
Инфляц (ХҮИ, хугацааны эцэст)	**0.9**	**6.4**	**8.1**	**5.2**	**2.3**	**5.0**	**7.0**
Урсгал дансны тэнцэл (ДНБ-д эзлэх %)	**-6.3**	**-10.2**	**-16.8**	**-15.4**	**-3.3**	**-7.7**	**-8.3**
Санхүүгийн болон хөрөнгийн данс (ДНБ-д эзлэх %)	**7.6**	**24.5**	**17.4**	**21.1**	**9.2**	**11.8**	**13.2**
Гадаадын шууд хөрөнгө оруулалт, цэвэр (ДНБ-д эзлэх %)*	1.1	12.7	16.3	16.5	12.5	14.0	15.0
Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх %)**	**-15.3**	**-3.8**	**2.6**	**1.4**	**-9.5**	**-2.7**	**-1.9**
Анхдагч тэнцэл (ДНБ-д эзлэх %)	**-10.1**	**0.4**	**5.8**	**3.7**	**-6.9**	**-0.3**	**0.1**
ЗГ-ын өр (ДНБ-д эзлэх %)***	**87.6**	**84.7**	**72.6**	**69.0**	**79.4**	**77.7**	**73.0**

* 2016 оны цэвэр ГШХО-ын дүнд 2016 оны 5-6 сарын Оюу толгой-2 төслийн санхүүжилтийн дүн ороогүй болно.

** Хөгжлийн банкны зардлыг төсвийн тэнцэлд оруулаагүй бөгөөд тусдаа хянагдана.

*** Засгийн газрын өрийн дүнд төрийн өмчит компаниудын өр болон Монголбанкны Хятадын ардын банкнаас своп хэлцлийн шугамаар авсан өр төлбөр ороогүй болно.

Эрсдэлүүд

Суурь таамаглалыг дээш, доош татаж магадгүй тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Цар тахлын дэгдэлтийг алдаж улмаар хатуу хөл хориог удаан хугацаанд тогтоох хувилбар бол өнөөдрийн хувьд тулгамдсан хамгийн том эрсдэл юм. КОВИД-19 цар тахлыг үр дүнтэй хянаж чадахгүй тохиолдолд ойрын саруудад нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт асар их хор хохирол учрах нь дамжиггүй. Эдийн засгийн өсөлтөд эрсдэл учруулж болох бусад хүчин зүйлсэд дэлхий дахин дахь цар тахлын дараа дараагийн давлагааны түүхий эдийн (ялангуяа, нүүрс болон зэс) үнэд үзүүлж болох сөрөг нөлөө, засгийн газраас эдийн засгийн реформыг хэрэгжүүлэх эрмэлзэл нь буурах явдал, цаг агаарын тааламжгүй нөхцөл байдал (ган гачиг, үер, зуд), банкны секторын бүтцийн өөрчлөлт, шинэчлэл гацах зэргийг дурдаж болно (шигтгээ I.5). Цар тахал хөгжингүй орнуудын эдийн засгийг боомилсон хэвээр, үүн дээр магадгүй АНУ, Хятадын худалдааны тодорхойгүй байдал нэрмээс болбол бүх үзүүлэлт дордох муу хувилбар хэрэгжинэ. Үйл явдал ингэж өрнөвөл гадаад эрэлт, экспортын түүхий эдийн үнэ (ялангуяа зэс), санхүүгийн захын хувьд маш ноцтой үр дагавар бий болно. Цаг агаарын нөхцөл байдалтай холбоотой шок (зудын эрсдэлийг оруулаад) үүсвэл уул уурхайн бус экспорт (тухайлбал, мах, ноолуур), хөдөөгийн ядуу, эмзэг өрхүүдийн орлогод сөргөөр нөлөөлөх боломжтой. Эцэст нь хэлэхэд 2021 оны төсвийн баримт бичигт

Шигтгээ I.5. Банкны салбарыг 2020-2023 онд чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр

2020 оны 1 дүгээр сарын 29-нд УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо "Банкны салбарыг чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр"-ийг баталж, хэрэгжилтийг хангах чиглэлийг Монголбанкинд өгөв. 2020-2023 онд хэрэгжих тус хөтөлбөрт нийт 5 үндсэн зорилтыг тодорхойлжээ. Үүнд:

I. **Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах,** банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулах үүднээс хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээс хувьцаат компанийн хэлбэрт шилжих, саналын эрхтэй хувьцааны дүнг хязгаарлах, хувьцааны нэг хэсгийг олон нийтэд санал болгох, цөөнх хувьцаа эзэмшигчдийн эрхийг баталгаажуулсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг Монголбанк шаардана. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийн бүтэц төрөлжиж, олон нийтийн оролцоонд суурилсан банкны дотоод хяналт сайжирна.

II. **Банкны салбарын хяналт, шалгалт, зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор** Монголбанк Базелийн хорооны зарчимд нийцсэн зохистой шалгуурыг нэвтрүүлж, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын эрх зүйн орчныг бүрдүүлж, бусад зохицуулагч байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг нь хангана. Ингэснээр олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн, уян хатан, эрсдэлд суурилсан зохицуулалт бий болно.

III. **ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлж дуусгахын** тулд банкуудаас өөрийн хөрөнгөө хууль ёсны эх үүсвэрээс бүрдүүлэхийг шаардах, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагыг биелүүлээгүй банкуудад холбогдох арга хэмжээ авах, ОУВС 6 дахь шатны үнэлгээг дуусгах, тохиролцоонд хүрэхийг хичээх юм. Ингэснээр, банкны системийн тогтвортой байдал хангагдаж, эрсдэл даах чадвар нэмэгдсэнээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй, эерэг өсөлтөд зохих хувь нэмрээ оруулна.

IV. **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох** үүднээс Монголбанк банкуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтыг өргөтгөх, бусад байгууллагатай хамтран хяналт шалгалтын үр ашгийг нэмэгдүүлэх; банкуудын корреспондент банкны харилцааг дэмжих, банкны хувьцаа эзэмшигчид болон тэдний дүрмийн санд тавигдах шаардлага, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр ажиллана.

V. **Банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;** FinTech-г банкны салбарт нэвтрүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд зохих өөрчлөлтийг оруулах.

Эх сурвалж: Монголбанк, Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 1 дүгээр сарын 29-ний хуралдааны протокол.

тусгасны дагуу төсвийн төлөвийг зохистой түвшин рүү эргүүлэн татаж, сахилга батыг баримтлахгүй бол хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийн зах зээлийн итгэлд сөргөөр нөлөөлж, дөнгөж сэргэж буй эдийн засгийн өсөлтийг унагаж болзошгүй. Түүнчлэн, банкны секторыг дахин хөрөнгөжүүлж чадахгүй аваас дээрх эрсдэл, тогтворгүй байдлыг улам эрчимжүүлж, албан секторыг дэмжих донор тусламжид ч мөн нөлөөлж болно. Эерэг үйл явдал гэвэл мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт (буюу "саарал жагсаалт")-аас ФАТФ Монгол Улсыг хассан явдал юм. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалд эергээр нөлөөлж санхүүгийн секторт итгэх итгэлийг нэмэгдүүлэх билээ.

Төсөв, мөнгөний бодлогын орон зай хумигдсан өнөө цагт цар тахал удаан үргэлжилбэл Монголын эдийн засаг томоохон сорилттой тулгарах болно. Монгол Улс КОВИД-19 цар тахлын эдийн засгийн сөрөг үр нөлөөг зөөлрүүлэх мөнгө,төсвийн бодлогын орон зайг шавхжээ. Цар тахал удаан хугацаанд үргэлжилбэл Монголбанк түүхэн доод түвшинд байгаа бодлогын хүүгээ улам бууруулж эдийн засгаа дэмжих боломж хомс байна. Үүний сацуу Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй уламжлалт бус мөнгөний бодлогын арга хэрэгслүүд нь (тухайлбал, урт хугацаат репо) банк хоорондын захын нөөцийг цаашдаа нэмэгдүүлэх боломжийг хязгаарлахаар байна. Засгийн газар цар тахлын эсрэг арга хэмжээгээ гадаад хөнгөлөлттэй болон дотоод зээлээр санхүүжүүлсэн тул Засгийн газрын өр нэмэгдэж төсвийн орон зай улам хумигдахаар хүлээгдэж байна. Иймд дунд хугацаанд төсвийн хуримтлал бий болгох нь нэн тэргүүний ач холбогдолтой байхаар байна.

Дунд хугацаанд гадаад санхүүжилтийн дарамт нэмэгдэж магадгүй байна. 2021-2022 онд экспорт мэдэгдэхүйц хэмжээгээр өсөхөөр хүлээгдэж байгаа ч хөрөнгө оруулалттай холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээний импорт сэргэх тул урсгал тэнцэл ойрын жилүүдэд алдагдалтай гарах хүлээлттэй байна. Гадаад санхүүжилтийг түргэн шуурхай босгож чадахгүй бол урсгал дансны алдагдал нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг дагуулж болзошгүй. Хэдийгээр Монголбанкнаас Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн хугацааг дахин 3 жилээр сунгаж, ойрын хугацаанд төлөгдөх байсан 570 сая ам.долларын гадаад өрийг бондоор амжилттай дахин санхүүжүүлсэн боловч 2021-24 онд төлөгдөх 2.1 тэрбум ам.долларын өр хүлээгдэж байна (зураг I.41).[34] Түүнчлэн эдийн засгийн реформуудын хэрэгжилт саарч, цар тахлын эсрэг арга хэмжээ үр дүн муутай байвал Монгол Улсын зээлжих зэрэглэл буурч дахин санхүүжилтийг таатай нөхцөлөөр хийх боломж хумигдах юм. Гадаад валютын улсын нийт албан нөөц 2020 оны эцэст түүхэн дээд хэмжээ болох 4.5 тэрбум ам.долларт (импортын 8 сар) хүрч дунд хугацаанд энэ түвшинд хадгалагдахаар байгаа ч ОУВС-гийн валютын нөөцийн хүрэлцээний шаардлага болох 100 хувьд хүрэхгүй хэвээрээ байна (100-150 хувь гэсэн харьцааг хүрэлцээтэй гэж үздэг).[35]

Зураг I.41. 2020-2024 онд том дүнтэй бондуудыг төлнө

Эх сурвалж: СЯ; Монголбанк; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[34] Хятадын ардын банктай байгуулсан Монголбанкны своп хэлцлийн хугацааг 3 жилээр сунгасан. Мөн 2022 оныг хүртэлх хугацаанд төлөгдөх том дүнтэй Засгийн газрын өр байхгүй байгаа нь 2020 оны 9 дүгээр сард 600 сая ам.долларын (5.5 жилийн хугацаатай, 5.1 хувийн купонтой) бондыг амжилттай гаргасантай мөн холбоотой. Тус бондын арилжаа нь: (i) Монгол Улсад олон улсын зах зээлийн хандах хандлагыг бататгах, (ii) 2021 онд хугацаа нь дуусах 500 сая ам.долларын бондын 3/4-ийг, 2022 онд хугацаа нь дуусах 1 тэрбум ам.долларын 1/5-ийг эргүүлэн худалдан авах; (iii) Засгийн газарт жилдээ 27 сая ам.долларын хүүний төлбөр хэмнэх боломж олгов.

[35] Валютын нөөцийн хүрэлцээ (ARA) нь нөхцөл байдал хүндрэх үеийн төлбөрийн тэнцлийн гадаад валютын хэрэгцээ шаардлагыг илэрхийлэх бөгөөд гадаад валютын болзошгүй гадагшлах урсгалын эсрэг нөөц хэр хүрэлцээтэй байгааг үнэлэхэд ашиглана (ОУВС, 2016 үзнэ үү).

Шиг тгээ I.6. Дэлхийн болон бүс нутгийн төлөв байдал, эрсдэлүүд[a]

Цар тахал, түүнтэй холбоотой хөл хорионы арга хэмжээ нь дэлхийн эдийн засгийг гүн хямралд оруулаа[b] (зураг I.42). Хөгжингүй орнуудын хувьд 2020 оны дунд үед КОВИД-19 халдварын тоо нэмэгдэхийн хэрээр хүн хоорондын зай барих шаардлага нэмэгдэж, хатуу хөл хорио тогтоосноор дотоод эрэлт хязгаарлагдаж, үйлчилгээний нийлүүлэлт саатсан бол халдварын хоёр, гурав дахь давлагаанаас шалтгаалан эргэн сэргэх явц нь удааширч байна. Хөгжиж буй орнуудын хувьд КОВИД-19 цах тахлаас шалтгаалан эдийн засаг нь 2020 онд 2.6 хувиар агшсан бөгөөд энэ нь 1960 оноос хойших хамгийн том уналтад тооцогдож байна. Хөгжиж буй орнуудаас Хятадын эдийн засгийг хасаж тооцвол, эдийн засаг 5 хувиар агшсан буюу эдгээр бүлгийн улс, орнуудын 80 гаруй хувь нь эдийн засгийн уналтад орсон байхаар байна. Үүнтэй харьцуулбал, 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын үеэр дээрх бүлгийн улс орнуудын 1/3 нь л хямралд өртөж байжээ. Дотоод халдварын нөхцөл байдал, дэлхийн эдийн засгаас хамаарах хамаарал зэргээс шалтгаалан хөгжиж буй орнуудын хямралын хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, урт хугацаанд хөл хорио тогтоосон, дотооддоо олон халдварын тохиолдолтой эсвэл дотоод арга хэмжээ бодлого нь тодорхой бус байсан, аялал жуулчлалын салбараас өндөр хамааралтай улс орнуудын эдийн засаг хамгийн ихээр өртжээ.

Дэлхийн эдийн засаг 2021 онд 4 хувиар өсөх хүлээлттэй байгаа боловч цар тахлын өмнө боловсруулж байсан үйлдвэрлэлийн түвшнээс 5 хувиар сул байхаар байна. Энэхүү төсөөллийг боловсруулахдаа улс орнууд цар тахлын эсрэг вакциныг үр дүнтэй хэмжээнд хийж, халдварын тохиолдлыг хязгаарлаж чадах, төсвийн дэмжлэгийг аажмаар бууруулах ч мөнгөний бодлогын дэмжлэг хэвээр үргэлжилнэ гэсэн урьдач нөхцөлийг авч үзлээ. Цар тахал нь потенциал өсөлтөд нөлөөлөх тул 2022 онд дэлхий эдийн засгийн өсөлт 3.8 хувьд хүрэх тооцоотой байна. Хэдийгээр хөгжиж буй орнуудын эдийн засаг 2021 онд 5 хувиар өсөж, 2022 онд 4.2 хувийн орчимд тогтворжих хүлээлттэй байгаа боловч энэхүү сэргэлтийн дийлэнхийг Хятадын эдийн засаг дангаар тодорхойлохоор байна. Харин, Хятадын эдийн засгийг оруулахгүйгээр тооцвол хэрэглээ, хөрөнгө оруулалт дорвитой сэргэхгүй тул өсөлт 2021-22 онд 3.5 хувийн орчимд л хэлбэлзэх төлөвтэй. Эдийн засаг ийнхүү сэргэх боловч цар тахлаас өмнө тооцоолж байсан үйлдвэрлэлийн түвшнээс 6 хувиар доогуур байхаар байна. Цар тахал нь хүмүүн капитал болон үйлдвэрлэлийн капиталын хуримтлалд нөлөөлөх замаар бүтээмжийг унагах тул потенциал өсөлтөд илүү хүндээр нөлөөлөх төлөвтэй.

Зураг I.42. ДНБ-ий бодит өсөлт



Эх сурвалж: Дэлхийн Банк 2021; Консенсус таамаглал.

Зураг I.43. Дэлхийн түүхий эдийн үнийн таамаглал (Индекс=нэрлэсэн ам.доллар, 2016=100)

Эх сурвалж: Дэлхийн Банк 2021; Консенсус таамаглал.

Цар тахлаас шалтгаалан сүүлийн 10 жилд сул байсан хөрөнгө оруулалт 2020 онд уналтад орлоо. 2021 онд хөрөнгө оруулалт тодорхой хэмжээнд нэмэгдэх боловч 2020 онд алдсан хэмжээгээ нөхөхөөргүй байна. Өмнөх цар тахлуудын жишгээс харахад КОВИД-19 цар тахлын дараа ч хөрөнгө оруулалт тийм ч амархан сэргэхээргүй байна. Тийм ч учраас хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын арга хэмжээ зайлшгүй шаардлагатай юм. Хөгжиж буй орнуудын хувьд өр хуримтлагдаж, түүнтэй холбоотойгоор өрийн тогтвортой байдал, санхүүгийн хямралын эрсдэл нэмэгдэж байсан бол цар тахлын нөлөөгөөр улс орнуудын өр улам нэмэгдэж дээрх эрсдэлийг эрчимжүүллээ.

Ихэнх түүхий эдүүдийн үнэ дэлхийн зах зээлд 2020 оны сүүлийн хагаст эргэн сэргээд байгаа боловч дэлхийн эрэлт хязгаарлагдмал байгаагаас газрын тосны үнэ хараахан сэргээгүй байна. Газрын тосны үнэ 2021 онд одоогийн түвшний орчимд буюу нэг баррель нь 44 ам.долларын орчимд хэлбэлзэх бол 2022 онд сэргэж 50 ам.долларт хүрэх төлөвтэй. Газрын тосны эрэлт нь хөл хорионы арга хэмжээнээс шууд хамаарах тул үүнээс шалтгаалан үнэ төсөөллөөс доогуур байх ч эрсдэлтэй. Гэхдээ вакцины талаарх эерэг мэдээлэл нь дээрх эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулж байна. Суурь металлуудын хувьд 2020 онд үнэ дунджаар тогтмол байсан бол оны эхний хагаст огцом унаж, сүүлийн хагаст Хятадын эрэлтийг дагаад эрчимтэй сайжирсантай холбоотой. 2021 онд дэлхийн эрэлт сэргэж, үнэ 5 хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байна (зураг I.43). ХАА-н гаралтай бүтээгдэхүүнүүдийн хувьд 2020 онд үнэ нь 4 хувиар өссөн юм. Үүнд нийлүүлэлтийн тасалдал, хүнсний тос болон бусад хүнсний хэрэглээ хүлээлтээс эрчимтэй нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, зарим бүс нутагт хүнсний үнэ огцом нэмэгдэж, өрхийн орлого буурснаар ядуу, эмзэг бүлгийн иргэдийн хувьд хүнсний аюулгүй байдлын эрсдэл бий болжээ. 2021 онд ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үнэ ялимгүй өсөх төсөөлөлтэй байна.

Бүс нутгийн эдийн засгийн өсөлт огцом саарч 2020 онд 0.9 хувьд хүрч байгаа бол 2021 онд 7.4 хувиар өсөх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч энэ нь цар тахлын өмнөх үеийн төсөөллөөс 3 хувиар доогуур үзүүлэлт юм. (зураг I.44). Хязгаарлагдаж байсан дотоод эрэлт огцом тэлж, үйлдвэрлэл болон экспорт хүлээлтээс эрчимтэйгээр сэргэж байгаа тул Хятадын эдийн засаг 2021 онд 7.9 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Харин 2022 онд өсөлт нь 5.2 хувьд хүрэх бөгөөд ингэснээр үйлдвэрлэлийн түвшин нь цах тахлаас өмнөх үеийн төсөөллөөс 2 хувиар доогуур гарах, потенциал өсөлт нь саарах төлөвтэй. Зүүн Ази, Номхон далайн бүсийн бусад орнуудын хувьд эдийн засаг 2021 онд 4.9 хувиар, 2022 онд 5.2 хувиар өсөх тооцоололтой байна. Энэ нь цар тахлын өмнөх үеийн төсөөллөөс 7.5 хувийн доогуур үзүүлэлт болж байгаагийн зэрэгцээ эдийн засгийн сэргэлт улс бүрийн хувьд харилцан адилгүй байна.

Зураг I.44. Зүүн Ази, Номхон далайн орнуудын таамаглал



Эх сурвалж: Дэлхийн Банк, 2021.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд сэргэхээр хүлээгдэж байгаа ч цар тахлыг хяналтад авахын тулд илүү их хүчин чармайлт гаргах шаардлага бий болох, КОВИД-19 вакцины нийлүүлэлт, хуваарилалт саатах, эдийн засгийн удаан хугацаанд үргэлжилж буй хямрал нь санхүүгийн секторт нөлөөлж улмаар санхүүгийн болон өрийн хямралд хүргэвэл өсөлт хүлээгдэж байснаас сул байх болно. Тухайлбал, төсвийн дэмжлэг туслалцаа нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн алдсан орлогын тодорхой хэсгийг нөхөх, дампуурлын эрсдэлийг бууруулах, зээлийн баталгаа гаргаснаар хувийн бизнесийг авч үлдэх, төв банкуудын санхүүжилт нь санхүүгийн системийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхад нөлөөлсөн билээ. Харин цар тахлыг хяналтад авч чадахгүй, халдвар улам нэмэгдвэл санхүүгийн хямралууд бий болж, зээллэгийг бүрэн зогсоох, илүү урт хугацааны уналтад хүргэх эрсдэлтэй. Дэлхийн санхүүгийн систем хямралаас зайлсхийлээ гэсэн ч цар тахалтай холбоотойгоор хуримтлагдсан өр нь урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хязгаарлах төлөвтэй.

Эх сурвалж: Дэлхийн Банк, 2020b; 2021.

Жич: a. Энэхүү шигтгээг Дэлхийн Банк (2021)-ээс иш татан боловсруулав. b. Дэлхийн Банк 2021.

ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

II. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ ӨРХӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

А. КОВИД-19 цах тахлын өрхийн түвшинд үзүүлэх нөлөөллийн сувгууд 34
Б. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн хөлсний орлогод үзүүлэх нөлөө 36
В. Хөдөлмөрийн бус орлогод нөлөөлсөн байдал 43
Г. Ядуурал үзүүлж болох нөлөө 44
Д. Бодлогын арга хэмжээний үр дүн 48

II. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ ӨРХӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ[36]

А. КОВИД-19 цах тахлын өрхийн түвшинд үзүүлэх нөлөөллийн сувгууд

Монгол Улс хоёр дахь удаагаа бүх нийтийн хөл хориог 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр тогтоосон билээ. Халдвар дэлхий дахинаа анх дэгдэх үед Монгол Улсын Засгийн газар КОВИД-19 халдвар зөөвөрлөгдөн орж ирэхээс сэргийлэн шийдвэртэй арга хэмжээ авсны дотор хилээ хааж, бүх түвшний боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоосон юм (зураг II.1). Мөн дэлхий даяар халдварын тохиолдол нэмэгдэхийн хэрээр олон улсад зорчих хөдөлгөөнийг хязгаарлав. Үүнд Транс Сибирийн төмөр замын тээвэр болон гадаад улсаас ирэх бүх нислэгийг зогсоож, ОХУ-тай хилээ хаав. Мөн Цагаан сарын баярыг бүх нийтээр тэмдэглэхгүй байхаар шийдвэрлэн, Улаанбаатар хот, 21 аймагт зорчих хөдөлгөөнийг хязгаарласан юм. Хөл хөдөлгөөн хорих эдгээр арга хэмжээг шуурхай авсны үр дүнд Монгол Улсад КОВИД-19 халдварын дотоодод тархах эрсдэлийг хязгаарлаж чадсан байхаар байна. Улмаар 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хөл хориог хэсэгчлэн цуцалж, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс цахимаар нээсэн юм. Харин, дотоод халдварын анхны тохиолдол бүртгэгдсэн 11 дүгээр сарын дунд үеэс эхлэн улсын хэмжээнд дахин бүх нийтийн хөл хориог тогтоов. Хэдийгээр бүх нийтийн чанга хязгаарлалтуудыг сулруулаад байгаа хэдий ч 2021 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар зарим төрлийн бизнесүүд хаалттай хэвээр, зарим хязгаарлалтууд үргэлжилсэн хэвээр байна.[37]

Монгол Улсад бүртгэгдсэн халдварын тохиолдол хөрш орнуудтай харьцуулахад бага боловч цар тахал нь өрх гэрийн амьжиргаанд урт хугацаанд нөлөөлж, эмзэг, ядуу өрхүүдийн хувьд илүү хүндээр тусахаар байна. Эмзэг, ядуу бүлгийн иргэдэд болзошгүй эрсдэлийн үед ашиглах нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг тул аливаа бэрхшээл, санхүүгийн хүндрэлд орох магадлал өндөр байдаг. КОВИД-19 цар тахал ч мөн ялгаагүй тэдэнд хүндээр тусч, урт хугацаанд гүн гүнзгий нөлөө үзүүлэх төлөвтэй байгаа тул Монгол Улсын ядуурлыг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнг сааруулах эрсдэлтэй байна. Монгол Улсад ядуурлын түвшин 2016-2018 онд буурсан хэдий ч ядуурлаас гарах хурд нь удааширч хүн амын нэлээдгүй хувь нь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр нөхцөлд амьдарч байна. Эдийн засгийн сөрөг шок бий болох үед эдгээр эмзэг нөхцөлд байгаа өрх айлууд эргээд ядуурлын шугам руу унах, ядуу иргэдийн нөхцөл байдал улам доройтох, ядуурал гүнзгийрэх эрсдэлтэй.

[36] Энэ бүлгийг Дэлхийн Банкны Ядуурал, тэгш байдлын асуудал хариуцсан газрын эдийн засагч Икуко Уочи, зөвлөх Лидия Ким (зөвлөх) нар боловсруулав.
[37] 2021.01.16-ны байдлаар 1512 тохиолдол бүртгэгджээ.

Зураг II.1. Халдварын тоо нэмэгдэхийн хэрээр хөл хорионы дэглэмийг чангаруулж байна



Эх сурвалж: Оксфордын Их сургууль (OxCGRT);

Жич: Хязгаарлалтын дэглэмийн индекс нь төрөөс авч хэрэгжүүлж буй сургууль, албан газрыг хаах, хүн олноор цугларахыг хязгаарлах зэрэг арга хэмжээний төлөвийг тодорхойлно. Хязгаарлалт чангарах тусам индекс нэмэгдэнэ.

КОВИД-19 цар тахлын сөрөг үр дагавар өрхийн амьжиргаанд олон хэлбэрээр нөлөөлж болзошгүй байна. Зураг II.2-т КОВИД-19 цар тахал өрх гэр, хувь хүнд хэрхэн нөлөөлж байгааг харуулав. КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийг нийгмийн болон эдийн засгийн гэж ангилж болно. Эдийн засгийн нөлөөлийг цааш нь хөдөлмөрийн хөлсний орлого, хөдөлмөрийн бус орлогын, үнийн өсөлтийн шалтгаантай хэрэглээний гэж задлан авч үзэж болох юм. Монголд дотоодын халдварын тоо харьцангуй бага байгаа учраас өрх айлын түвшинд эдийн засгийн шууд бус нөлөө түлхүү зонхилж байгаа юм. Нийгмийн нөлөөллийн хувьд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд учирч буй саатлыг авч үзэж болно. Энэхүү тайланд КОВИД-19 цар тахлын эдийн засгийн нөлөөг голчлон өрх гэрийн түвшинд авч үзэн, цар тахал нь макро эдийн засгийн шокоос хэрхэн өрхийн түвшний шок болон хувирах, ядуурлын үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлохоор зорилоо.

Зураг II.2. КОВИД-19 цар тахлын өрх гэрт нөлөөлөх хэлбэрүүд



Эх сурвалж: Дэлхийн Банк (2020a)-д тулгуурлан бэлтгэв.

Б. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн хөлсний орлогод үзүүлэх нөлөө

Утсанд суурилсан өрхийн судалгаа (УСӨС)-ны үр дүнгээс харахад цар тахал нь хөдөлмөр эрхлэлтэд хүчтэй нөлөөлжээ (шигтгээ II.1)[38]. Цар тахлаас өмнө цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн 19 хувь нь 2020 оны 5 дугаар сарын эцэст хөдөлмөр эрхлээгүй байв.[39] Тэдгээрийн гуравны хоёрын хувьд КОВИД-19 цар тахлын холбогдолтой хөл хорио, ажлын байр, бизнес хаагдсан болон бусад шалтгаанаар хөдөлмөр эрхлэлт нь зогссон байна. Харин, мөн оны 6 – 9 дүгээр сарын хооронд хөдөлмөр эрхлэлт эргэн сайжирч, 5 дугаар сарын сүүл гэхэд ажилгүй байсан дээрх иргэдийн хагас нь 9 дүгээр сарын эхэн гэхэд буцаж ажилдаа оржээ. Гэвч 11 дүгээр сард КОВИД-19 дотоод халдвар бүртгэгдэж хатуу хөл хорио тогтоосноор цар тахлаас өмнө цалин хөлстэй ажил эрхэлж байгаад ажилгүй сууж буй иргэдийн тоо 12 дугаар сар гэхэд 51 хувьд хүрч нэмэгдлээ (зураг II.3).

Шигтгээ II.1. Монгол Улсад КОВИД-19 цар тахлын нөлөөллийг тодорхойлох Утсанд суурилсан өрхийн судалгаа

Монгол Улсын хувьд КОВИД-19 цар тахлын өрх гэрт үзүүлж буй нөлөөллийн сувгийг тодорхойлохын тулд энэхүү тайланд Утсанд суурилсан өрхийн судалгаа (УСӨС)-ны гурван удаагийн санал асуулгын дүнг ашиглав. Уг санал асуулгыг өрх гэрт үзүүлж буй цар тахлын эдийн засаг, нийгмийн нөлөөг тогтоохоор Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ), Дэлхийн Банк хамтран явуулсан болно. Ингэхдээ 2018 оны Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-нд хамрагдсан монгол өрхүүдийг төлөөлөхүйц өрхүүдээс 2000 өрхийг түүвэрлэн авч, гурван үе шаттайгаар мэдээлэл цуглуулав. Эхний шатны асуулгыг 2020 оны 5 дугаар сарын 22-29-ний өдрүүдэд, хоёр дахь асуулгыг 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 9 дүгээр сарын 7-ны өдрүүдэд, гурав дахь асуулгыг 2020 оны 12 дугаар сарын 3-15-ны өдрүүдэд явуулаа. Хоёр дахь удаагийн хөл хориог 2020 оны 11 дүгээр сарын дундаас 12 дугаар сард тогтоосон нь УСӨС-ны гурав дахь шаттай давхцаж байна. Цаг хугацааны болоод хөл хорионы төлөвийн ялгаатай байдлаас шалтгаалан гурав дахь шатны санал асуулгын дүнг бусад шатны асуулгын дүнтэй, эсхүл өөр санал асуулгын дүнтэй харьцуулах нь зохимжгүй юм. Энэхүү судалгааны асуулгыг утсаар явуулсан учраас зөвхөн утастай айл өрхийн төлөөлөл хамрагдсан гэж үзнэ. 2018 оны ӨНЭЗС-нд оролцсон 16,454 өрхийн 95.1 хувь нь утсаар холбогдох боломжтой байв. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо аль нэг чиглэлд хэлбийхгүйгээр[a], тархалтын хувьд 2018 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхүүдтэй ижил шинж чанартай, байршил, өрхийн тэргүүний боловсролын түвшин, ядуурлын үнэлгээ зэрэг үндсэн шинжээр төлөөлөхүйц байхаар сонгосон болно. УСӨС-ны асуулга нь цар тахлын талаарх мэдлэг мэдээлэл, түүнтэй холбоотой зан дадал, ажил эрхлэлт, өрхийн бизнес, малчин өрхийн амьжиргаа, орлого, хүнс болон нийгмийн үндсэн үйлчилгээний хангамж, хүндрэл бэрхшээлийг даван туулж буй арга, тусламж дэмжлэг зэрэг өргөн сэдвийг хамарсан юм.

Хүснэгт II.1. | УСӨС-ны 1 - 3 дугаар үе шат

	Шат 1	Шат 2	Шат 3
Өгөгдөл цуглуулах үе шат	2020.05.22-29	2020.08.31-09.07	2020.12.03-15
Цуглуулах арга	Компьютерын тусламжтай утсаар ярилцах (КТУХ)		
Оролцогчдын тоо	1,333 өрх	1,212 өрх	1,147 өрх
Хариу ирүүлсэн хувь	66.7 хувь (ӨНЭЗС 2018-д оролцсон 2,000 өрхөөс)	90.9 хувь (Эхний шатанд оролцсон 1,333 өрхөөс)	94.6 хувь (Хоёр дахь шатанд оролцсон 1,212 өрхөөс)

Эх сурвалж: УСӨС 1-3 дугаар шат. https://www.worldbank.org/en/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia.
Жич: a. (Himelein, 2014)

[38] УСӨС-нд "ажил хийхээ зогсоосон" иргэд гэж цар тахлаас өмнө, эсхүл өмнөх санал асуулгаар ажил хөдөлмөр эрхэлж байсан, санал асуулга авахаас өмнөх долоо хоногт ямар нэг шалтгаанаар ажил эрхлээгүй иргэдийг оруулж тооцсон. "Ажил хийхээ зогсоосон" гэх энэ тодорхойлолт нь Ажиллах хүчний судалгаанд ашигладаг "сүүлийн 30 хоногт идэвхтэйгээр ажил хайж буй боловч ажилд ороогүй байгаа иргэд"-ийг хамруулсан тодорхойлолтоос өөр гэдгийг анхаарна уу.
[39] УСӨС-нд цар тахлын өмнөх үе гэдэгт 2020 оны 1 сарын 27-ны өдрөөс өмнөх үеийг ойлгоно.

Цар тахлын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө түр зуурын мэт байсан боловч ядуу иргэдийн хувьд урт хугацаанд ажлын байраа алдах эрсдэлтэй байна. Санал асуулгад оролцсон иргэдийн дунд 2020 оны 6-12 дугаар сарын хооронд цалин хөлстэй ажил, хөдөлмөр эрхлээгүй 10 хүний 6 нь "хөл хорионы дэглэм цуцлагдахад буцаж ажилдаа орно" гэжээ. Энэ чиг хандлага амьжиргааны түвшний бүх бүлгүүдийн дунд ажиглагдаж байгаа боловч ядуу бүлгийн ажиллагсад урт хугацаанд ажилгүй болж, ажилгүйдэлд нэрвэгдэх магадлал өндөр байна. Амьжиргааны бүлгийн доод 40 хувьд багтах иргэдийн хувьд цар тахлаас өмнө цалин хөлстэй ажил хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн 21 хувь нь 2020 оны 6 дугаар сард ажилгүй болж, 12 дугаар сарын байдлаар ажилгүй хэвээр байсан бол дээрх харьцаа нь амьжиргааны түвшний дээд 60 хувьд багтах иргэдийн хувьд дөнгөж 11 хувь байна.

Цар тахал эдийн засгийн ихэнх салбарт сөргөөр нөлөөлсөн бол үйлдвэрлэл, аялал жуулчлал, зочид буудал, тээвэр, худалдааны салбарын хөдөлмөр эрхлэлтэд хамгийн хүндээр тусжээ.[40] Аж үйлдвэрлэлийн салбарууд, тэр дундаа боловсруулах үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, барилга, уул уурхайн салбарын хувьд цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан иргэдийн 70 хувь нь 2020 оны 12 дугаар сарын байдлаар "ажиллахаа больсон" гэж асуулгад хариулсан байна (зураг II.4). Тухайлбал, 2020 оны 11 сарын дундаас 12 сарын дунд хүртэлх хугацаанд тогтоосон хөл хорио барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хүчтэй нөлөөлсөн бөгөөд цаг хугацааны хувьд УСӨС-ны 3 дахь шаттай давхцаж байна. Зорчих хөдөлгөөнд тавьсан хязгаарлалтын дэглэмийг сулруулснаар барилга, боловсруулах үйлдвэрлэлийн ажил эргэн идэвхэжсэн тул хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт нь түр зуурынх байх

Зураг II.3. Цар тахлаас өмнө хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн талаас илүү нь хоёр дахь хөл хорио эхлэхэд ажил эрхлэлтээ зогсоосон байна



Зураг II.4. Аж үйлдвэрлэлийн болон үйлчилгээний хувийн салбарт ажиллагсдын томоохон хувийн хөдөлмөр эрхлэлт нь саатсан

Эх сурвалж: УСӨС-ны 1, 3 дахь, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Аж үйлдвэрлэлийн салбарт уул уурхай, боловсруулах, барилга, нийтийн аж ахуйн салбар; хувийн үйлчилгээний салбарт зочид буудал, хоол хүнсний үйлчилгээ, харилцаа холбоо, санхүү, үл хөдлөх, тээврийн салбар; бусад салбарт урлаг соёл, амралт зугаа цэнгэл, өрхийн аж ахуй, олон улсын байгууллагууд хамаарна.

[40] Эдгээр салбарыг цар тахалд "өртсөн салбар", уг салбарт ажиллагсдыг "өртсөн ажиллагсад" гэж энэ тайланд тодорхойлов.

магадлалтай байна: санал асуулгад оролцсон эдгээр салбарт ажилладаг гурван хүний хоёр нь эргэж ажилдаа орох боломжтой гэж хариулжээ. Зочид буудал, ресторан, тээврийн үйлчилгээ, жижиглэнгийн худалдаа зэрэг үйлчилгээний бизнес эрхэлдэг хувийн хэвшлүүд (жишээлбэл, хувийн үйлчилгээ, амралт/зугаа цэнгэл)-ийн хувьд мөн хөдөлмөр эрхлэлтэд томоохон сөрөг нөлөө бий болжээ. Эдгээр салбарт ажиллаж буй иргэдийн хувьд 2020 оны 1 - 12 дугаар сард томоохон хувь нь ажил хөдөлмөр эрхлэхээ зогсоосон байна. Гэхдээ хөдөлмөр эрхлэлтийн энэхүү тасалдал нь гол төлөв бүх нийтийн хоёр дахь хөл хорионы нөлөө гэж үзэж болох бөгөөд эдгээр иргэдийн тэн хагасаас илүү нь хөл хорио дуусахад эргэн орох байнгын ажлын байртай хүмүүс байв.[41] Нөгөө талаас хөдөө аж ахуй, төрийн захиргаа, эрүүл мэнд, боловсролын салбарт ажилладаг иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд цар тахал төдийлөн нөлөөлсөнгүй. Хоёр дахь удаагийн хөл хорионы үед хүртэл эдгээр иргэдийн гуравны нэг нь л ажил хөдөлмөр эрхлээгүй байна. Гэхдээ хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад, малчид ажлын байраа нэгэнт алдвал хөл хорио тавигдсан ч буцаж тэр ажилдаа орох магадлал тун бага байна.

Судалгаагаар, 2020 оны 1 - 12 дугаар сарын хооронд ажиллахаа больсон гурван хүн тутмын хоёр нь цар тахалд хамгийн их өртсөн салбаруудад ажиллаж байжээ. 2019 оны байдлаар Монгол Улсад цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 48 хувь нь (557 мянган хүн) нь цар тахалд өртсөн салбаруудад ажиллаж байжээ (зураг II.5). Харин, цар тахал эхэлснээс хойш 2020 оны 12 дугаар сарын байдлаар хөдөлмөр эрхлэлт нь зогссон иргэдийн дунд дээрх салбарт цалинтай хөдөлмөр эрхэлж байгаад ажиллахгүй байгаа иргэдийн хувь 67 хувь байна. Ерөнхийдөө, цар тахлын нөлөөгөөр цалинтай хөдөлмөр эрхлэлтээ зогсоосон 10 хүн тутмын 3 нь үйлдвэрлэлийн салбарт, 6 хүн нь үйлчилгээний салбарт ажиллаж байжээ.

Гадаад, дотоод зорчих хөдөлгөөнийг эртнээс хязгаарлаж, удаан хугацаанд үргэлжлүүлж байгаа тул аялал жуулчлалын салбар цар тахлын нөлөөнд хамгийн их өртөөд байна. Зураг II.6-д үзүүлсэнчлэн Монгол Улсын Засгийн газар эхний хөл хориогоор олон улсын нислэг, тээвэр, төмөр замын тээврийг бүрэн зогсоож, нэн шаардлагатай бус бизнесийн үйл ажиллагааг 2 дугаар сараас эхлэн хязгаарласан нь зорчигч тээвэрт хүчтэй нөлөөлсөн байна. Дараа нь 2020 оны 11 дүгээр сараас тогтоосон хатуу хөл хорионы нөлөөгөөр зунаас эхлэн тогтвортой сэргэж байсан төмөр замын зорчигч тээвэр зогсоод байна. Зорчих хөдөлгөөнийг ийнхүү хязгаарласан нь аялал жуулчлалын салбар (зочид буудал, ресторан зэрэг), жижиглэнгийн худалдаа, тээвэр зэрэг түүнтэй холбоотой бусад үйлчилгээний салбарт (хувийн үйлчилгээ, амралт, зугаалга зэрэг) хүчтэй нөлөөлжээ. 2020 оны эхний улиралд Монгол Улсад ирсэн жуулчдын тоо 2019 оны эхний улиралд ирсэн

Зураг II.5. Цар тахалд өртсөн салбарт ажиллагсдын харьцаа, 2019 оны байдлаар



Эх сурвалж: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа 2019; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[41] Зочид буудал, амралт, ресторан, жижиглэнгийн худалдаа, тээвэр, мэргэжлийн болон техникийн ур чадвар шаардлагатай ажил, үл хөдлөх хөрөнгө, санхүү, даатгал, мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарынхны хувьд 2020 оны 12 дугаар сарын байдлаар ажиллагсдын 60 гаруй хувь нь ажлаа зогсоосон гэж хариулсан хэдий ч УСӨС-ны дүнгээс харахад эдгээр салбарт ажлын байраа алдах асуудал 2020 оны 9 дүгээр сар хүртэл буюу хатуу хөл хорио тогтоохоос өмнө бага байжээ.

жуулчдын тооны тэн хагаст нь ч хүрээгүй байна. Түүнчлэн жуулчны оргил улирал болох 2, 3 дугаар улиралд 10,000 хүрэхгүй жуулчин ирсэн байна (зураг II.7). Сүүлийн жилүүдэд жуулчны оргил улиралд тухайн жилийн нийт жуулчдын 70 хувийг хүлээн авдаг байсан бол аялал жуулчлалын салбарт ирэх жуулчдын тоо ийнхүү хэд хэдэн улирал дараалан ихээр буурснаар тус салбарын нөхцөл байдлыг улам муутгажээ.

КОВИД-19 цар тахалтай холбоотой зорчих хөдөлгөөний хязгаарлалт нь тээвэр, худалдаа, аялал жуулчлал, үйлчилгээ, амралт зугаалгатай холбоотой хувийн хэрэглээнд сөргөөр нөлөөлжээ. Зураг II.8 -т Google-ийн зорчих хөдөлгөөний өгөгдлийг харуулав. Энд 2020 оны 1 дүгээр сарын эхнээс 2 дугаар сар хүртэлх таван долоо хоногийн хугацаан дахь хөдөлгөөнтэй харьцуулахад олон нийтийн зарим газруудад хөл хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдсөнийг харуулж байна. Мөн 2020 оны 2 - 4, 11 - 12 дугаар саруудад дэлгүүр, хоршоо, зорчигч тээврийн буудал, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудад хүний хөдөлгөөн хэрхэн саарсныг ч харж болно. Ялангуяа, боловсролын байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоосон 2 дугаар сарын сүүлийн долоо хоногт болон 11 - 12 дугаар сард хөл хөдөлгөөн огцом буурчээ. Хэдийгээр хөл хөдөлгөөн 4 - 11 дүгээр сард нэмэгдсэн ч 2020 оны 11 дүгээр сард эхлүүлсэн хоёр дахь хөл хорионы үед КОВИД-19 цар тахал эдийн засгийн идэвхжилд хүчтэй нөлөөлжээ. Тэр дундаа хотын төв хэсгээр төвлөрсөн жижиглэнгийн худалдаа, зочид буудал, үсчин гоо сайхан гэх мэт хувь хүний үйлчилгээ, үзвэр үйлчилгээний бизнест хүчтэй нөлөөлсөн нь харагдаж байна.

Зураг II.6. 2020 оны I, II хөл хорионы үед тээвэрлэсэн зорчигчдын тоо буурлаа



Эх сурвалж: YCX;
Жич: Дотоод, гадаадад зорчсон бүх зорчигчдын тоо.

Зураг II.7. 2020 онд ирсэн жуулчны тоо өмнөх жилүүдээс маш бага байлаа



Эх сурвалж: YCX.

Зураг II.8. Үйлчилгээ авах зорилготой зорчих хөдөлгөөн хөл хориотой холбоотойгоор огцом буурчээ



Эх сурвалж: Google хөл хөдөлгөөний бүртгэлийн тайлан (2020.12.30-ны байдлаар).

Жич: Суурь өгөгдөл гэж 2020.01.03 - 02.06-ны хоорондох 5-долоо хоногийн хугацаанд ижил гарагууд бүртгэгдсэн өдрийн дундаж хөдөлгөөн болно.

Цар тахалд өртсөн үйлчилгээний салбарт мэргэжлийн ур чадвар харьцангуй бага шаарддаг, албан бус хөдөлмөр эрхлэлт зонхилдог тул эдгээр салбарт цалинтай ажиллагсад цар тахлын сөрөг нөлөөнд илүү эмзэг болж байна. Жижиглэн худалдаа, тээврийн салбарт ажилладаг иргэдийн талаас илүү нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид юм (зураг II.9.a). Худалдааны салбар болон зочид буудал, ресторан, хоолны үйлчилгээний салбаруудын хувьд харгалзан 44, 70 хувь нь цалинтай хөдөлмөр эрхэлдэг ажиллагсад байдаг бол тэдэн дунд дөрвөн хүн тутмын гурав нь 50-с цөөн ажиллагсадтай жижиг аж ахуйн нэгжид ажилладаг ажээ (зураг II.9.b). Бодлогын арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлэхгүйгээр эдгээр жижиг аж ахуйн нэгжүүд хүндрэлд орох магадлалтай юм. Учир нь санхүүгийн боломж бололцоо, зээл авах боломж нь хязгаарлагдмал учраас зардлаа хэмнэхийн тулд эдгээр аж ахуйн нэгжүүд ажилтнаа халах, эсхүл ажлын цагийг хорогдуулахад хүрч болзошгүй. Худалдаа, зочид буудлын салбарт цалинтай ажил эрхэлдэг иргэдэд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, цалинтай чөлөө зэрэг дэмжлэг туслалцаа хязгаарлагдмал байх хандлагатай (зураг II.9.c). Мөн, төрийн захиргаа, боловсрол, үл хөдлөх, санхүүгийн салбарт албан хөдөлмөр эрхлэгчидтэй харьцуулахад цар тахалд өртсөн салбарын ажиллагсад нь боловсролын түвшин доогуур байна. Цар тахлын нөлөөгөөр эдгээр ажиллагсдын хөдөлмөр эрхэлдэг жижиг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдох, бизнесийн тогтвортой байдал нь алдагдвал ур чадвар, боловсролын түвшин сул, албан бус хөдөлмөр эрхэлдэг эдгээр иргэд ажлын байраа алдах, орлого нь буурах илүү өндөр эрсдэлтэй байхаар байна.

Цар тахал тодорхой салбаруудын ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлсөн бол хөдөлмөрийн хөлс, орлогод үзүүлсэн нөлөө нь илүү өргөн хүрээтэй байна. Судалгаанд оролцсон өрхүүдээс 10 өрх тутмын 6 өрхийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлмөрийн хөлс, орлого нь буурчээ (зураг II.10). Хөдөө аж ахуйн бус чиглэлээр хөдөлмөр эрхэлдэг өрхүүдийн хувьд дийлэнх нь орлого буурсан гэж хариулсан байна. Тухайлбал, энэ чиглэлд ажил хөдөлмөр эрхэлдэг 10 өрх тутамд бараг 9 өрхийн хөдөлмөрийн орлого буурчээ. Цар тахлаас өмнө энэ чиглэлд ажиллаж байсан өрхүүдийн 40 гаруй хувь нь 2020 оны 6 дугаар сар гэхэд бизнесээ түр болон бүр мөсөн хаасан болохыг УСӨС-ны дүн харуулж байна. Дээрх хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байсан бизнесүүдийн хувьд орлого нь мэдрэгдэхүйц буурсан, ялангуяа хоёр дахь хөл хорионы үеэр хөдөө аж ахуйн бус бизнес эрхлэгчдийн талаас илүү хувийнх нь орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60 хувиар буурчээ.

Цар тахал хөдөө аж ахуйн бус салбарын хөдөлмөр эрхлэлтэд голлон нөлөөлсөн ч нийлүүлэлтийн сүлжээний доголдол, малын гаралтай бүтээгдэхүүний эрэлт гадаад зах зээлд унасантай холбоотойгоор хөдөөгийн малчдын орлого огцом буурчээ. Ихэнх малчид, фермерүүд цар тахал эхлэх үед ажил хөдөлмөрөө хэвийн явуулж, зөвхөн цөөн хэд нь 1 – 6 дугаар сард ажиллаагүй гэж хариулжээ.

Зураг II.9. Албан бус салбарт хөдөлмөрлөж буй ур чадвар багатай иргэд хамгийн эмзэг болоод байна



Эх сурвалж: ҮСХ, ӨНЭЗС 2018, Ажиллах хүчний судалгаа 2018; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Түүнээс хойших хугацаанд хөдөө аж ахуйн салбарт ажлын байраа алдах явдал нэмэгдсээр 2020 оны 12 дугаар сар гэхэд цар тахлаас өмнө ажиллаж байсан иргэдийн гуравны нэг нь ажиллахаа больсон байна. Үүнээс гадна, хөдөө аж ахуйн чиглэлээр ажилладаг гурван өрх тутмын хоёрынх нь орлого 2020 онд мэдэгдэхүйц хэмжээнд буурчээ (зураг II.10). Малчдын олонх нь малын гаралтай бүтээгдэхүүн дундаас хамгийн ашигтай ноолуурын орлогоос хамааралтай амьдардаг. Харамсалтай нь ноолуур бэлтгэх оргил үетэй давхцаад дэлхийн зах зээлд ноолуурын эрэлт унаснаар малчдын бэлэн мөнгөний орлого огцом буурчээ. Малчдын орлого ийнхүү огцом буурсан нь сөрөг үр дагавар ихтэй юм. Учир нь Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд (2016 - 2018 онд) ядуурал буурсан нь голчлон нийгмийн энэ бүлгийнхний орлого нэмэгдсэнтэй шууд холбоотой байсан юм.

Зураг II.10. ХАА-н бус салбарт бизнес эрхлэгчдэд хүчтэй нөлөөлжээ

Эх сурвалж: ҮСХ, УСӨС 3 дахь шат; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Өнгөрсөн 12 сарын хугацаанд зөвхөн дээрх ангиллын дагуу орлого олсон иргэдийг хамруулав.

Ядуу бүлгийн иргэд 2020 оны эхний хагас жилд ажлын байраа алдах магадлал өндөр байсан бол хоёр дахь хөл хорионы үед амьжиргааны бүх түвшинд ажлын байр, орлогоо алдах байдал ажиглагдсан байна.[42] Ядуу бүлгийн өрхүүд цар тахлын улмаас ажлын байраа алдах эрсдэлд хамгийн бага нэрвэгдсэн хөдөө аж ахуйн салбарт ажил хөдөлмөр эрхлэх нь түгээмэл хэдий ч энэ бүлгийн иргэд цар тахалд ихээр өртсөн боловсруулах үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, уул уурхай, үсчин гоо сайхан гэх мэт хувийн үйлчилгээний салбарт ур чадвар бага шаарддаг ажлуудыг мөн олноороо эрхэлдэг байна. Ерөнхийдөө орлогын түвшнээрээ амьжиргааны бүлгийн доод 20 хувьд хамаарах 3 ажилтан тутмын 2 нь ур чадвар шаарддаггүй ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаа юм.[43] Амьжиргааны бүлгийн дээд хэсэгт хамаарах иргэд хуулиар хамгаалагдсан, албан ёсны хөдөлмөр эрхэлдэг, эсхүл төрийн захиргаа, санхүү болон бусад ур чадвар, мэргэжил шаардах, тогтвортой ажил эрхэлдэг бөгөөд тэдний хувьд гэрээс ажиллах боломж харьцангуй өндөр байна. Амьжиргааны бүлгийн доод 20 хувь нь 2020 оны 1 - 6 дугаар сарын хооронд буюу хөдөлгөөний хязгаарлалт харьцангуй бага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байсан үед ч ажилгүй болох магадлал өндөр байжээ (зураг II.11.a). Гэхдээ 2020 оны 6 - 12 дугаар сард, ялангуяа бүх бизнесийн үйл ажиллагааг зогсоосон хоёр дахь хөл хорионы үед цар тахлын ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө амьжиргааны бүх түвшинд ажиглагдсан байна.

Чинээлэг бүлгийн иргэд худалдаа арилжаа, хөдөө аж ахуйн бус бизнест түлхүү оролцдог тул аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоосноор хөдөлмөр эрхлэлтэд гарсан өөрчлөлт 2020 оны сүүлийн хагаст энэ бүлэгт тод мэдрэгдсэн байна. Хэдий чинээлэг давхарга 2020 оны эхний хагаст ажилгүй болох эрсдэл бага байсан боловч, орлого буурах үзэгдэл нийгмийн бүх бүлэгт жилийн турш ажиглагдаж, амьжиргааны бүлэг тус бүрд хамаарах өрхийн талаас илүү хувийнх нь орлого 2020 онд буурсан үзүүлэлттэй байна (зураг II.11.b). Гадаад, дотоод эрэлт буурч, бизнесийн үйл ажиллагаа зогсон, богиносгосон цагаар ажиллаж эхэлснээр цалин, бизнесийн орлого буурахад хүргэжээ. УСӨС-ны дүнгээс харахад ядуу өрхтэй харьцуулахад чинээлэг өрхүүдийн орлогын бууралт абсолют дүнгээрээ ч, нийт орлогод эзлэх хувиараа ч илүү хэмжээгээр буурчээ. Гэхдээ ядуу өрхийн хувьд орлого нь нэг төгрөгөөр буурахад амьжиргаанд гарах сөрөг нөлөөлөл илүү өндөр байдаг. Эндээс 2020 оны эдийн засгийн агшилт нийт өрхөд далайцтай туссан болох нь харагдаж байна.

[42] Ажлын байраа алдсан гэдэгт хатуу хөл хорионы хугацаанд ажил нь түр зогссон иргэдийг хамруулав.
[43] Эх сурвалж: ҮСХ, Дэлхийн Банк (2020).

Зураг II.11. Хөдөлмөр эрхлэлт, орлогын алдагдал, амьжиргааны бүх бүлгээр



Эх сурвалж: ҮСХ, УСӨС 2020 1 ба 3 дахь шат; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: А багана дахь иргэдийн түвврийг санал асуулгын 1 болон 3 дахь шатанд хоёуланд нь оролцсон иргэдээр хязгаарлав. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор сургууль болон албан байгууллагуудын үйл ажиллагааг хааж, хөл хорио тогтоон, гэрээс ажиллах тухай Засгийн газрын шийдвэрийн нөлөөгөөр ажил нь зогссон иргэдийг л А баганад харуулав.

Газар зүйн байршлын хувьд хот, суурин газрын өрхүүд КОВИД-19 цар тахлын эдийн засгийн нөлөөнд автах магадлал өндөр байна. Цар тахалд хамгийн их өртсөн эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд хот суурин газарт түлхүү төвлөрсөн байна. Тодруулбал, эдгээр салбарт ажиллагсдын 82 хувь нь хот суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотод (62 хувь) амьдардаг байна. Улаанбаатар хот эсвэл аймгийн төвд амьдардаг иргэдийн хувьд 2020 оны 1 - 12 дугаар сард ажил эрхлэлт нь зогсох магадлал сумын төвийн болон хөдөөгийн иргэдтэй харьцуулахад харгалзан 1.9 болон 3.9 дахин их байжээ (зураг II.12). Тухайлбал хот, суурин газрын ядуу бүлгийн иргэд албан бус, цагийн ажил хийх, цар тахлын нөлөөнд нэрвэгдсэн салбарт жижиг бизнес эрхлэх нь түгээмэл тул ажлын байраа алдах эрсдэл чинээлэг иргэдтэй харьцуулахад өндөр байна.

Зураг II.12. Хот, суурин газрын иргэдийн ажил 2020 онд түлхүү зогссон байна



Эх сурвалж: ҮСХ, УСӨС 2020 3 дахь шат; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Улаанбаатар хот, аймаг, сумын төвийг хот суурин газар гэж үзлээ.

Цар тахал нь эдийн засгийн ялгаатай салбаруудад нөлөөлж байгаа тул эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил, хөдөлмөр эрхлэлтэд ялгаагүй нөлөөлжээ. Эмэгтэйчүүд боловсрол, эрүүл мэнд, үсчин гоо сайхан гэх мэт хувийн үйлчилгээ, зочид буудал зэрэг бусад үйлчилгээний салбарт түлхүү ажилладаг бол эрчүүд барилга, уул уурхайн салбарт түлхүү хөдөлмөр эрхэлдэг байна. КОВИД-19 цар тахлын эдийн засгийн нөлөө нь үйлдвэрлэл, үйлчилгээний бүхий л салбарт гарч байгаа тул эрэгтэй, эмэгтэй хүмүүс ажын байраа алдах явдал харилцан ялгаагүй байна. УСӨС-ны дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхүүд мөн ялгаагүй л орлогоо алдах магадлалтай байжээ.

Үүнээс гадна, КОВИД-19 цар тахлын үед ажилгүй иргэд ажил хайхад илүү хүнд байгаа тул ядуурал улам гүнзгийрэх магадлалтай. Ажил эрхэлдэг, тэтгэврийн иргэдтэй харьцуулахад цар тахлаас өмнөх хугацаанд ч ажилгүй, эдийн засгийн идэвхгүй байсан иргэдийн ядуурлын түвшин дунджаар өндөр байдаг байсан. Хүмүүн капиталын түвшин бага, ядуу, ядууралд ойрхон байгаа иргэдийн хувьд хөдөлмөрийн зах зээлийн шаардлагыг дийлэнхдээ хангаж чаддаггүй тул ажил олоход хүндрэлтэй байдаг. Ажилгүй буюу эдийн засгийн хувьд идэвхгүй байснаар цалин хөлсний орлогогүй болж, хэрэглээ нь бага, ядуу хэвээр үлдэх магадлал өндөр болно. КОВИД-19 цар тахал нь хүнд нөхцөлд байгаа эдгээр иргэдэд улам хүндээр тусч, энэ бүлгийн хүн амын дунд ядуурлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

B. Хөдөлмөрийн бус орлогод нөлөөлсөн байдал

Гэр бүлийн гишүүнээс ирүүлэх мөнгөн гуйвуулга нь хүлээн авч буй гэр бүлийнхээ хувьд өндөр ач холбогдолтой орлогод тооцогддог боловч КОВИД-19 цар тахлын үед шилжүүлгийн хэмжээ буурах эрсдэлтэй байна. 2018 онд хийсэн ӨНЭЗС-гаар судалгаанд оролцсон өрхүүдийн 18 хувь нь судалгаанаас нэг жилийн өмнөх хугацаанд ямар нэг шилжүүлэг хүлээн авсан гэж хариулжээ. Монгол Улсад шилжүүлгийн дийлэнхийг дотоод шилжүүлэг эзэлдэг ба нийт гуйвуулгын дөнгөж хоёр хувь нь гадаадаас шилжүүлсэн хувийн шилжүүлэг байдаг байна. Амьжиргааны бүлгээр авч үзвэл чинээлэг өрхийн 24 хувь нь шилжүүлэг хүлээн авдаг бол орлого багатай 40 хувьд багтах өрхүүдийн дөнгөж 14 орчим хувь нь шилжүүлэг авдаг ажээ (зураг II.13). Зураг II.14-т үзүүлсэнчлэн амьжиргааны түвшнээс үл хамааран энэ төрлийн орлого олдог бүх өрхийн хувьд шилжүүлэг нь өндөр ач холбогдолтой, өрхийн нийт орлогын 25-33 хувийг бүрдүүлдэг байна. КОВИД-19 цар тахал нь цагаач (оршин суух гэрээсээ өөр газарт ажилладаг) ажиллагсдын хувьд хөдөлмөр эрхлэлтэд нь хүчтэй нөлөөлөх тул тэдний шилжүүлэх шилжүүлгийн хэмжээнд мөн нөлөөлөхөөр байна. Хэрэв хөдөлмөрийн цагаач ажиллагсдын хөдөлмөр эрхэлдэг бизнесүүд богино хугацаанд эргэж сэргэхгүй бол энэ байдал урт удаан хугацаанд үргэлжилж болзошгүй. Мөнгөн гуйвуулгаас өндөр хамааралтай, аливаа хуримтлал эсхүл түр зуур ашиглах нөөц бололцоо, хөрөнгө байхгүй, ядуу, эмзэг бүлгийн өрхийн хувьд мөнгөн шилжүүлэг багасвал тэдний амьжиргаа улам л хүндэрнэ.

Ядуу өрхүүдийн хувьд хөдөлмөрийн бус бусад орлого, тэр дундаа төрөөс олгож буй халамж, тусламж, дэмжлэг нь орлогын чухал эх үүсвэр болдог байна. Ядуу өрхийн хувьд цалин хөлс нь өрхийн орлогын 60 гаруй хувийг бүрдүүлдэг хэдий ч орлогынх нь гуравны нэгийг хүүхдийн мөнгө, бусад нийгмийн халамжийн мөнгө, тэтгэвэр бүрдүүлдэг байна.[44] УСӨС (3 дахь шат)-ны дүнгээс харахад халамж хүртэгчдийн дөнгөж 3 хувь нь л цар тахлын үед төрөөс олгож буй тусламж, дэмжлэгийг цагтаа авч чадаагүй байна.

Зураг II.13. Мөнгөн шилжүүлэг авдаг өрхүүд (2018)



Эх сурвалж: ҮСХ, ӨНЭЗС 2018; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Босоо хэрчмүүд нь 95 хувийн итгэх интервалыг илэрхийлнэ.

Зураг II.14. Өрхийн орлогод мөнгөн шилжүүлгийн эзлэх хувь (дэмжлэг авдаг өрхүүдийн хувьд)



Эх сурвалж: ҮСХ, ӨНЭЗС 2018; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Жич: Босоо хэрчмүүд нь 95 хувийн итгэх интервалыг илэрхийлнэ.

[44] Эх сурвалж: ҮСХ, Дэлхийн Банк (2020).

Г. Ядуурал үзүүлж болох нөлөө

Энэ бүлэгт КОВИД-19 цар тахлын ядуурлын түвшинд үзүүлэх нөлөөг макро-микро симуляцын арга ашиглан тооцлоо[45]. ADePT макро-микро симуляцын аргыг ашиглахдаа (i) макро эдийн засгийн төсөөллийг өрхийн амьжиргааны түвшин болон хамгийн сүүлийн нийгэм эдийн засгийн судалгаанд танилцуулсан өрхийн зан байдлын төлөвийн мэдээлэлтэй нэгтгэж, (ii) хөдөлмөрийн зах зээл, цалин хөлсний бус орлого, хэрэглээний үнийн өөрчлөлттэй холбоотой урьдач нөхцөлүүдийг тусгасан микро симуляц хийх замаар өрхийн ядуурал, орлогын хуваарилалтад үзүүлэх КОВИД-19 цар тахлын нөлөөг тооцов.[46] Хүснэгт II.2-т ДНБ болон үнийн таамаглалын гурван хувилбарыг дэлгэрэнгүй танилцууллаа. Үүнд: (i) КОВИД-19 цар тахлын өмнөх үеийн төсөөлөл (амьдрал хэвийн үргэлжилж байсан бол), (ii) суурь төсөөлөл, (iii) муу хувилбар. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ялгаатай таамаглалаас гадна, суурь төсөөлөлд мөнгөн гуйвуулгын хэмжээ 2020 оны хоёр улирал дараалан 50 хувиар буурсан гэж үзсэн бол муу хувилбарын хувьд 2020 онд дөрвөн улирал дараалан 50 хувь буурсан гэж үзлээ. Энэхүү симуляцад хөдөлмөр эрхлэлт - эдийн засгийн өсөлт хоорондын мэдрэмжийг ашигладаг бөгөөд мэдрэмжийг 2010-2018 оны хооронд ДНБ-ий салбаруудын өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, НҮБ-ийн Дэлхийн хүн амын өсөлтийн таамаг (2019)-т тусгасан хүн амын өсөлтийн төлөвт үндэслэн тооцов.

Симуляцын дүнгээс харахад Засгийн газраас иргэдийн орлогыг дэмжих арга хэмжээ аваагүй тохиолдолд 2020 онд ядуурлын түвшин КОВИД-19 цар тахлын өмнө тооцож байсан түвшнээс 5.9 - 7.9 нэгж хувиар өсөх эрсдэлтэй байжээ. Өөрөөр хэлбэл, ойролцоогоор 195-260 мянган хүн ядуурал өртөх эрсдэлтэй байжээ (Зураг II.15, Зураг II.16). КОВИД-19 цар тахал болоогүй байсан ч гэсэн сүүлийн үед хүнсний барааны үнэ нэмэгдэж, ядуу өрхөд ачаалал үүсгэснээр 2019-2020 онуудад ядуурлын буурах хурдац саарах төлөвтэй байлаа.[47] КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн үзүүлэлт муудахын хэрээр ядуурлын түвшин өсөж, суурь болон муу хувилбарын үзүүлэлтээр харгалзан 31.7 болон 33.6 хувьд хүрэх эрсдэлтэй байв. Ингэснээр Монгол Улсын нэг сая гаруй иргэн ядуурлын шугамын доор орох эрсдэлтэй байсан байна. КОВИД-19 цар тахлын нөлөө цар тахал дуусан ч тодорхой хугацаанд үргэлжлэх ба эргэн сэргэх амаргүй байхаар байна. Ийнхүү эдийн засгийн сэргэлт удааширч болзошгүй нөхцөлд суурь төсөөллийн тооцоогоор 2022 он

Зураг II.15. Ядуурлын түвшин, төсөөлөл

Зураг II.16. Ядуу иргэдийн тоо, төсөөлөл



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (ADePT симуляц).

Жич: Ядуурлын түвшинг тооцохдоо КОВИД-19 цар тахлын үр нөлөөг бууруулах чиглэлд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нөлөөг оруулаагүй болно.

[45] Olivieri, et al. (2014)-д тодорхойлсон микро симуляцын загварыг энэ тайланд ашиглав.
[46] ӨНЭЗС 2018
[47] Симуляцад ашигласан ядуурлын шугамд хүнсний болон хүнсний бус бараа бүтээгдэхүүний үнийн инфляцыг тусгасан. Ядуурлын шугам дээрх өрхийн нийт хэрэглээний 51 хувийг хүнсний хэрэглээ эзэлдэг бол ХҮИ тооцдог сагсан дахь хүнсний бараа нь сагсны 26 хувийг бүрдүүлдэг. Иймд хүнсний барааны үнэ хүнсний бус барааны үнээс хурдтай өсөх тохиолдолд ядуу иргэдэд хүндээр тусдаг тул, ядуурлын шугамыг дээш нь татаж, олон хүнийг ядуурлын шугамын доор оруулна.

Хүснэгт II.2. | ДНБ-ий өсөлт, инфляц[a]

(1) КОВИД-19 өмнөх хувилбар (амьдрал хэвийн үргэлжилж байсан бол)					
	2018	**2019 төс**	**2020 төс**	**2021 төс**	**2022 төс**
Хөдөө аж ахуй	4.5%	4.5%	4.4%	4.4%	5.0%
Уул уурхай, үйлдвэрлэл	7.9%	3.4%	3.1%	5.6%	5.7%
Үйлчилгээ	4.7%	6.8%	6.2%	6.2%	6.7%
Нийт	7.2%	5.8%	5.3%	5.6%	5.8%
(2) Суурь төсөөлөл					
	2018	**2019**	**2020 төс**	**2021 төс**	**2022 төс**
Хөдөө аж ахуй	4.5%	8.4%	10.8%	5.0%	6.0%
Уул уурхай, үйлдвэрлэл	7.9%	3.1%	-11.0%	6.3%	5.4%
Үйлчилгээ	4.7%	5.8%	-5.1%	2.9%	5.2%
Нийт	7.2%	5.2%	-5.2%	4.3%	5.4%
(3) Муу хувилбар					
	2018	2019	2020 төс	2021 төс	2022 төс
Хөдөө аж ахуй	4.5%	8.4%	9.4%	4.0%	5.0%
Уул уурхай, үйлдвэрлэл	7.9%	3.1%	-12.2%	2.9%	3.9%
Үйлчилгээ	4.7%	5.8%	-7.9%	1.6%	3.0%
Нийт	7.2%	5.2%	-7.1%	2.4%	3.5%
Инфляц (жилийн) КОВИД-19-с өмнөх хувилбар					
	2018	**2019**	**2020 төс**	**2021 төс**	**2022 төс**
Нийт ХҮИ	8.1%	5.2%	7.0%	8.0%	8.5%
Хүнс ХҮИ	9.1%	8.3%	11.0%	9.0%	8.6%
Хүнсний бус ХҮИ	7.8%	4.2%	5.6%	7.6%	8.5%
Инфляц (жилээр) суурь болон муу хувилбараар					
	2018	**2019**	**2020 төс**	**2021 төс**	**2022 төс**
Нийт ХҮИ	8.1%	5.2%	2.3%	5.0%	7.0%
Хүнсний ХҮИ	9.1%	8.3%	8.5%	8.0%	8.2%
Хүнсний бус ХҮИ	7.8%	4.2%	0.1%	4.0%	6.6%

Жич: ХҮИ = хэрэглээний үнийн индекс.

a. КОВИД-19 цар тахлаас өмнөх үеийн хувилбарыг тооцохдоо Монгол Улсын Эдийн засгийн тойм (2020 оны 1 сар)-д танилцуулсан 2019 ДНБ-ий өсөлтийн таамаглалыг ашиглав. Тухайн үед 2019 оны ДНБ-ий бодит гүйцэтгэлийн мэдээ хараахан гараагүй байсан тул өсөлтийн таамаглалыг ашигласан болно. Суурь болон муу хувилбаруудын хувьд Дэлхийн Банкны 2021.01.18-ны байдлаарх төсөөлөл, таамаглалыг ашиглав.

хүртэл ядуурлын түвшин 2018 оны түвшин рүү буцаж буурах боломж хомс бөгөөд ойролцоогоор нэг сая орчим хүн ядуу хэвээр байх эрсдэлтэй байжээ. Харин, мөнгөн гуйвуулга хүлээн авдаг өрхийн тоо цөөн тул КОВИД-19 цар тахлаас шалтгаалан мөнгөн гуйвуулга буурахад дундаж иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөө харьцангуй бага байна. Хэрэв мөнгөн гуйвуулгад өөрчлөлт гарахгүй гэж үзвэл, ядуурлын түвшин суурь болон муу хувилбараар харгалзан 5.5 болон 6.4 нэгж хувиар өсөх тооцоо гарч байна.

Ядуу, ялангуяа "шинээр ядуу болсон" иргэдийн хувьд КОВИД-19 цар тахлын амьжиргаанд үзүүлэх нөлөө бусад бүлгийн иргэдтэй харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байхаар байна. КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөө нь амьжиргааны бүх түвшин дэх өрхүүдэд мэдрэгдэж байгаа боловч Засгийн газраас иргэдийн орлогыг дэмжих арга хэмжээ аваагүй тохиолдолд ядуу хүн амын амьжиргаанд илүү хүндээр тусаж, улмаар муу хувилбарын тооцоогоор тэдний хэрэглээ 2018 онтой харьцуулахад 2020 онд 18 хувиар буурах тооцоо гарч байна (зураг II.17). Үр дүнд нь ядуурлын гүнзгийрэлт, мэдрэмж аль аль нь муудаж, ядуурлын гүнзгийрэлт 3.4 нэгж хувиар, мэдрэмж 1.9 нэгж хувиар нэмэгдэх төлөвтэй. Ядуу иргэд, ялангуяа 2020 онд КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр ядуурлын шугам руу халтирч орсон "шинээр ядуу болсон" иргэд хамгийн хүнд нөхцөлд орж нэг хүнд ногдох бодит хэрэглээ нь 2018 оноос 2020 онд 27-32 орчим хувиар буурах тооцоо гарч байна (зураг II.18).

Цар тахал нь хөдөөгийн иргэдтэй харьцуулахад хот, суурин газрын иргэдийн амьжиргаанд илүү нөлөөлөх төлөвтэй. Засгийн газрын орлого дэмжих арга хэмжээний нөлөөг оруулаагүй симуляцын дүнгээс харахад 2020 онд хөдөөд ядуурал КОВИД-19 цар тахлын өмнөх үеийн түвшинд хэвээр хадгалагдах боловч бусад газарт мэдэгдэхүйц хэмжээнд өсөх тооцоо гарч байна (зураг II.19). Ялангуяа, аймгийн төвд хамгийн ихээр буюу муу хувилбараар тооцоход ядуурлын түвшин 28 хувиас 38 хувьд хүрч нэмэгдэх тооцоотой байна. КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр ядуурлын шугамаас доош унаж, "шинээр ядуу болсон" иргэдийн 75 орчим хувь нь нийслэл, аймгийн төвд амьдардаг айл өрхүүд байхаар байна. (зураг II.20) Муу хувилбараар тооцвол 200 мянга гаруй хот суурин газрын иргэд шинээр ядуу болох бол хөдөөгийн 74 мянган хүн ядуурлын шугам руу халтирч орох эрсдэлтэй байна.

Зураг II.17. Хэрэглээний өөрчлөлт (нэг хүнд ногдох хэрэглээний өөрчлөлт хувиар, 2018-с 2020 он)



Зураг II.18. Иргэдийн амьжиргааны өөрчлөлт, ядуурлын төлөв байдлаар, 2018-с 2020 он



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүд тооцоо (ADePT симуляц).

Жич: Ядуурлыг тооцохдоо иргэдийн орлогыг дэмжих Засгийн газрын арга хэмжээний нөлөөг оруулаагүй. 2018 оны хэрэглээг 2020 оны үнээр зэрэгцүүлэн өөрчлөв. "Шинээр ядуу болсон иргэд" гэдэгт КОВИД-19 цар тахлаас өмнө ядуу байгаагүй боловч цар тахлын дараа ядуу болсон иргэдийг, "ядуу байсан иргэд" гэж КОВИД-19 цар тахлаас өмнө ядуу бүлэгт байсан иргэдийг оруулаа.

“Шинээр ядуу болсон” иргэдийн гуравны хоёр нь КОВИД-19 цар тахлын үйлчилгээний салбарт үзүүлсэн нөлөөтэй холбоотой байна. КОВИД-19 цар тахал эдийн засгийн бүхий л салбарт сөргөөр нөлөөлж байгаа ч нөлөөллийн зэрэг нь харилцан адилгүй байна. Зураг II.21-д “шинээр ядуу болсон” болон КОВИД-19 цар тахлаас өмнө ядуурлын шугамаас доогуур буюу “ядуу байсан” иргэдийн тархалтыг хөдөлмөр эрхэлж буй салбараар нь харуулав. КОВИД-19 цар тахал эхлэхээс өмнө эдийн засгийн салбараар авч үзэхэд ядуурлын тархалт жигд байсан бол эдийн засгийн агшилтаас улбаалан үйлчилгээний салбарынхан ядууралд өртөх магадлал нэмэгдэж байна. Харин, хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх КОВИД-19 цар тахлын нөлөө (суурь болон муу хувилбаруудын хувьд нийт дүнгээрээ) бага байхаар байгаа тул хөдөө аж ахуйн салбарт шинээр ядуу болох иргэд нийт ядуу иргэдийн 6 хувийг л бүрдүүлэхээр байна.

Зураг II.19. Ядуурлын түвшин, байршлаар (%)



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (ADePT симуляц).

Жич: Ядуурлыг тооцохдоо Засгийн газраас КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах, орлогыг дэмжих арга хэмжээний нөлөөг оруулж тооцоогүй болно.

Зураг II.20. Ядуурлын тархалт, газар зүйн байршлаар



Зураг II.21. Ядуурлын тархалт, эдийн засгийн салбараар



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (ADePT симуляц).

Жич: Ядуурлыг тооцохдоо Засгийн газраас КОВИД-19 сөрөг нөлөөг бууруулах чиглэлд авсан арга хэмжээг оруулж тооцоогүй.

Д. Бодлогын арга хэмжээний үр дүн

КОВИД-19 цар тахлын шалтгаантай эдийн засгийн өнөөгийн хямралд өртөж буй ядуу иргэд, эмзэг бүлгийн өрхүүдийн ("шинээр ядуу болсон" иргэдийг оруулаад) гэнэтийн хямралыг даван туулах санхүүгийн чадамжийг сайжруулах шаардлага тулгамдаад байна. Монгол Улсын Засгийн газар шуурхай ажиллаж, иргэдийн амьжиргаанд үзүүлэх КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч байна. Тухайлбал, Хүүхдийн мөнгө, хүнсний талон, болон хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгалтай холбоотой тусламж дэмжлэгийг нэмэгдүүлсэн (хүснэгт II.3)[48]. Энэ бүлэгт микро-симуляцын аргыг ашиглан эдгээр бодлогын арга хэмжээ өрхийн амьжиргаанд хэр нөлөөтэй байгааг тооцлоо.[49]

"Хүүхдийн мөнгө" хөтөлбөр (ХМХ) нь Монгол Улсын хамгийн том нийгмийн хамгааллын хөтөлбөр бөгөөд ядуу өрхүүдийн 90 гаруй хувийг хамардаг байна.[50] Энэ хөтөлбөрийн хүрээнд (18 хүртэлх насны) хүүхэд бүрд 20,000 төгрөг олгодог ба нийт хүүхдүүдийн 80 хувь нь хамрагддаг. 2018 оны байдлаар ядуу хүн амын 92 хувь нь хүүхдийн мөнгө авдаг өрхөд амьдардаг байжээ (зураг II.22). Орлого багатай өрх олон хүүхэдтэй байх хандлагатай тул чинээлэг өрхтэй харьцуулахад ядуу өрх хүүхдийн мөнгөнөөс ахиу хэмжээтэй мөнгөн тэтгэмж авдаг байх төлөвтэй. Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь амьжиргааны түвшин доогуур 20 хувьд багтах өрхүүдийн орлогын 10 хувийг бүрдүүлдэг байна. (зураг II.23).

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг Засгийн газраас нэмсэн нь ядуу өрхийн хувьд КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөг багасгахад үр дүнтэй байх магадлалтай. КОВИД-19 цар тахлын сөрөг үр нөлөөг бууруулах зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх 15 сарын хугацаанд Засгийн газраас сар бүр нэг хүүхдэд олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 20,000 төгрөгөөс 100,000 төгрөг

Зураг II.22. Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдсан өрхүүд (2018)



Эх сурвалж: ҮСХ, 2018 ӨНЭЗС; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг II.23. Хүүхдийн мөнгө болон өрхийн бусад орлого, эх үүсвэрээр (2018)



Эх сурвалж: ҮСХ, 2018 ӨНЭЗС; Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

[48] 2020.11.23-ны байдлаар. 2020.11.01-нээс эхлэн хүүхдэд олгох хүнсний талоны мөнгөн дүн 16,000 төгрөгөөс анхны үнийн дүн болох 8000 төгрөг болж буурсан. Хэдийгээр том хүнд олгох хүнсний талоны үнийг нэмэгдүүлснийг хэвээр үргэлжлүүлэх шийдвэрийг зарлаагүй боловч уг хөтөлбөр 2020 он дуустал үргэлжилсэн. Дээрх нийгмийн хамгааллын арга хэмжээнээс гадна Засгийн газар COVID-19 цар тахлын нөлөөг бууруулах чиглэлд хэд хэдэн арга хэмжээ авсны дотор нийгмийн даатгалын шимтгэлийн хураамж, ус, цахилгаан, халаалтын үнэ, хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх шийдвэр гаргасан.

[49] ӨНЭЗС-д заасан "байнгын асаргаа шаардлагатай (16 хүртэлх насны) хүүхэд"-ийг тодорхойлоход хүндрэлтэй учраас энэ судалгаанд оруулаагүй.

[50] ӨНЭЗС-2018 -ын өрхийн өгөгдөлд суурилав (хүн амд жигнэсэн үзүүлэлтээр).

Хүснэгт II.3. КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах чиглэлд Засгийн газраас авсан арга хэмжээ (нийгмийн хамгааллын чиглэлд)

	Хөтөлбөрийн нэр	Шаардлага	Үндсэн дүн (сард, төг)	Нэмэгдүүлсэн дүн (төг)	Хүчинтэй хугацаа	Хамрагдсан иргэдийн тоо
1	**"Хүүхдийн мөнгө" хөтөлбөр (ХМХ)**	0-18 насны хүүхэд	20,000	100,000	2020.04.01 -2021.07.01	1,144,630
2	**Халамжийн тэтгэмж (дараах бүлгийн иргэдэд олгоно):**	(1) НД-с тэтгэвэр авдаггүй ахмад настан), Эм55+/Эр60+	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	3,140
		(2) 16 насанд хүрсэн одой иргэн	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	106
		(3) 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	36,486
		(4) 18 нас хүрээгүй бүтэн өнчин хүүхэд	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	14,219
		(5) 4 болон түүнээс олон 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	12
3	**Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд**	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд	188,000	288,000	2020.05.01-2020.12.31	10,243
4	**Хүнсний талон хөтөлбөр**	(1) Ядуу өрхийн гишүүн том хүн	16,000	32,000	2020.05.01-	118,748
		(2) Ядуу өрхийн гишүүн хүүхэд	8,000	16,000	2020.05.01-2020.11.01	123,189

Эх сурвалж: https://www.legalinfo.mn/law/details/15358?lawid=15358, http://hudulmur-halamj.gov.mn/.

болгож нэмэгдүүлсэн нь ДНБ-ий 3.0 хувьтай тэнцэх хэмжээний зардалтай болж байна.[51] Хүүхдийн мөнгөний нэмэлт тэтгэмж хамгийн ядуу иргэдийн сарын хэрэглээг дунджаар 30,000 төгрөгөөр нэмэгдүүлэх буюу нэг иргэнд ноогдох хэрэглээг 36-38 хувиар нэмэгдүүлж байгаа үзүүлэлт юм (зураг II.24). Ингэснээр амьжиргааны түвшний доод 40 хувьд багтах өрхүүдийн хувьд КОВИД-19 цар тахлын нөлөөг бүрэн арилгах боломжтой болж байна (зураг II.25). Тухайлбал, орлогын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ аваагүй үед эдийн засаг илүү хүндээр хямрах муу хувилбараар тооцоход ядуу иргэдийн хэрэглээ КОВИД-19 цар тахлын өмнөх үеэс 20 хувиар буурах тооцоо гарч байна. Харин хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмснээр энэ бүлгийн хэрэглээ эсрэгээрээ 11 хувиар өсөх тооцоо гарлаа. Нөгөө талаас, амьжиргааны түвшний дээд 50 хувьд багтах өрхүүдийн хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдэл нь КОВИД-19 цар тахлын амьжиргаанд нь үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад хангалтгүй байна.

[51] ДНБ 2019 оны дүнгээр (Эх сурвалж: ҮСХ).

Зураг II.24. Хүүхдийн мөнгөний нэмэгдэл нэг иргэнд ногдох хэрэглээг нэмэгдүүлэх хувь, (2020)[a]



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (AdePT симуляц).

Жич: а Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдагсдын мэдээллийг ӨНЭЗС 2018 авлаа.

Зураг II.25. Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлснээр амьжиргааны түвшинд үзүүлэх нөлөө, цар тахлаас өмнөх үетэй харьцуулахад (2020)



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (AdePT симуляц).

Суурь төсөөлөл болон муу хувилбаруудаар тооцоход Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд ядуурлын түвшин КОВИД-19 цар тахлын өмнөх үеэс буурах магадлалтай байна. Зураг II.26-д харуулсанчлан хүүхдийн мөнгөний нэмэгдлийг оруулан тооцож үзэхэд 2020 онд ядуурлын түвшин суурь болон муу хувилбаруудын үед харгалзан 22.3 ба 23.9 хувьд хүрч буурах тооцоо гарч байна. Харин, халамжийн тэтгэмж, хүнсний талоны хэмжээг нэмэгдүүлсэн нь ядуурал харьцангуй бага нөлөөтэй байхаар байна. Учир нь ядуу иргэд уг хөтөлбөрт хамрагдах байдал хязгаарлагдмал юм. Харин эдгээр арга хэмжээ нь эмзэг бүлгийн бусад иргэдэд хүрэх чухал ач холбогдолтой байна. Бодлогын дээрх бүх

Зураг II.26. Ядуурлын түвшин, бодлогын арга хэмжээ авсан, аваагүй ялгаатай нөхцөлд (2020)[a]



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (ADePT симуляц).

Жич: а. КОВИД-19 цар тахлын өмнөх үеийн халамж хүртэгчдийн мэдээллийг 2018 оны ӨНЭЗС-с авлаа.

ХМХ="Хүүхдийн мөнгө" хөтөлбөр. НХТ=Нийгмийн халамжийн тэтгэмж, ХТХ="Хүнсний талон" хөтөлбөр.

арга хэмжээний нөлөөг нийлүүлэн тооцож үзэхэд ядуу өрхийн амьжиргааны түвшнийг хэвээр хадгалж чадах төдийгүй ядуурлын түвшин КОВИД-19 цар тахлын өмнөх түвшнээс ч доош орох боломжтой харагдаж байна.

КОВИД-19 цар тахлын нөлөөг сааруулах зорилгоор төрөөс үзүүлсэн тусламж дэмжлэг нь хамрагдсан өрхүүд, тэр дундаа ядуу иргэдийн хувьд цар тахлаас улбаатай эдийн засгийн сөрөг үр нөлөөг бууруулахад ерөнхийдөө үр нөлөөтэй байсан болохыг УСӨС-ны үр дүн харуулж байна. Төрөөс ямар нэг тусламж, дэмжлэг авсан өрхүүдийн 35 хувь нь энэхүү гэнэтийн хямралын сөрөг нөлөөг төрийн тусламж дэмжлэг бүрэн арилгасан, 57 хувь нь үр нөлөөг тодорхой хэмжээнд бууруулсан гэж дүгнэжээ (зураг II.27). Энэ нь цар тахлаас шалтгаалан өрхийн орлогод гарсан сөрөг өөрчлөлтийг хүүхдийн мөнгөн тэтгэмжийн өсөлт бүрэн эсвэл тодорхой хэмжээнд сааруулж чадсан гэсэн дүгнэлттэй холбоотой байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмж авдаг ядуу болон ядуу биш өрхүүд дийлэнх нь “хүүхдийн мөнгө амьдралд нь тус нэмэртэй” гэж хариулсан бол ядуу өрхийн хувьд хүүхдийн мөнгө цар тахлаас улбаатай хямралын сөрөг нөлөөг бүрэн болон хэсэгчлэн сааруулсан гэж үзэх явдал 6 хувиар илүү байв.

КОВИД-19 цар тахлаас улбаатай хямрал, сөрөг нөлөө үргэлжилсээр байгаа бөгөөд Засгийн газар 11 дүгээр сарын дундаас хоёр дахь хатуу хөл хориог тогтоосноос хойш улам гүнзгийрсэн байж болзошгүй тул өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж буйг цаашид анхааралтай ажиглах шаардлагатай. Энэхүү тайланд тооцсон ядууралд үзүүлэх нөлөө нь хамгийн сүүлийн макро эдийн засгийн төсөөлөл, орлогын түвшний тархалт болон үнийн таамагт суурилсан болно. Макро эдийн засгийн үзүүлэлт болон бусад таамаг шинэчлэгдэхэд микро-симуляцыг дахин хийж, үр дүнг шинэчлэх шаардлагатай болно.

Зураг II.27. Засгийн газраас олгосон тусламж, дэмжлэгийн үр нөлөөг өрхүүд дүгнэсэн байдал



Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо (УСӨС-ны 2 дахь шат).

Ашигласан материал

Himelein, K. 2014. "Weight Calculations for Panel Surveys with Subsampling and Split-off Tracking." *Statistics and Public Policy* 1 (1). Taylor & Francis Online, December 23. https://www.tandfonline.com/doi/full/10.1080/2330443X.2013.856170.

IMF (International Monetary Fund). 2012. "Inflation Dynamics in Mongolia: Understanding the Roller Coaster." International Monetary Fund, Washington, DC.

_____. "2016. Guidance note on the assessment of reserve Adequacy and related considerations" https://www.imf.org/external/np/pp/eng/2016/060316.pdf

_____.. 2020. *World Economic Outlook, October 2020: A Long and Difficult Ascent*. Washington DC: International Monetary Fund.

National Statistics Office of Mongolia and World Bank. 2020. *Mongolia Poverty Update 2018 (English)*. Washington, DC: World Bank Group. http://documents.worldbank.org/curated/en/532121589213323583/Mongolia-Poverty-Update-2018.

_____. 2020. "Results of Mongolia COVID-19 household Response phone survey (Round 1)." Ulaanbaatar.

_____. 2020. "Results of Mongolia COVID-19 household Response phone survey (Round 2)." Ulaanbaatar.

_____. 2021. "Results of Mongolia COVID-19 household Response phone survey (Round 3)." Ulaanbaatar.

Olivieri S., S. Radyakin, S. Kolenikov, M. Lokshin, A. Narayan, and C. Sánchez-Páramo. 2014. "Simulating Distributional Impacts of Macro-dynamics: Theory and Practical Applications," World Bank Publications, number 20391, World Bank, Washington, DC, June.

World Bank. 2020a. *World Bank East Asia and Pacific Economic Update, April 2020: East Asia and Pacific in the Time of COVID-19*. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank.org/handle/10986/33477.

_____. 2020b. *World Bank East Asia and Pacific Economic Update, October 2020: From Containment to Recovery. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank.org/handle/10986/34497.*

_____. 2021. *Global Economic Prospects, January 2021*. Washington, DC: World Bank. https://openknowledge.worldbank.org/handle/10986/34710.

ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

Address: Floor 5, MCS Plaza, 4 Seoul Street, 14250 Ulaanbaatar, Mongolia
Tel: +(976)7007 8200 • Web: www.worldbank.org/mongolia
Facebook: World Bank Mongolia